

Ш.Оюунцэцэг, Б.Мөнгөнцэцэг, Л.Олзвой,
Ц.Оюун, Ц.Туул

МОНГОЛ ХЭЛ VI

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
6 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74.2
ДАА 373
М-692

Монгол хэл VI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 6 дугаар ангийн сурах бичиг /Оюунцэцэг Ш., ба бусад; Ред Оюунцэцэг Б./ УБ. 2018, 152х

Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN:978-99978-61-74-0

ГАРЧИГ

Бүлэг I Харилцан яриа	5
Гол асуудлыг ойлгон сонсож, асуулт асууж тодруулах	6
Санаа бодлоо бусдынхтай холбож харилцан ярих.....	11
Жинхэнэ нэрийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох.....	12
Бүлэг II Үйл явдлын уялдаа холбоо.....	21
Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлыг задлан шинжлэх.....	22
Үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой бичих.....	26
Үйл үгийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох	29
Бүлэг III Эхийн сэдэв, гол санаа	39
Үйл явдлын эхлэл, гол, төгсгөлийн уялдаа холбоог задлан шинжлэх	40
Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих.....	45
Орон цагийн нэрийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох.....	48
Бүлэг IV Үйл явдлын орчин.....	55
Орон цагийн дүрслэлийг ялгаж, үйл явдлын орчныг тодорхойлох.....	56
Үйл явдлын орчныг дүрслэн бичих.....	61
Өгүүлбэрийн цөм ба дэлгэрэнгүй бүтэц үүсгэн найруулах.....	64
Бүлэг V Дүрүүдийн харилцан яриа.....	77
Эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох.....	78
Эхэд харилцан яриа оруулан дэлгэрүүлж бичих.....	82
Харилцан ярианд цэг тэмдгийг зөв хэрэглэх.....	87
Бүлэг VI Үйл явдлын цагийн дараалал.....	91
Эхээс гол мэдээллийг ялгаж унших.....	92
Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлэн бичих.....	98
Эхийн найруулгыг судалж, алдааг таньж, сайжруулах.....	100
Бүлэг VII Бичигчийн сэтгэлийн өнгө аяс.....	103
Мэдрэмж, сэтгэгдлийг ялган, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах.....	104
Хэлц ашиглан мэдрэмж сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө дүрслэн бичих.....	110
Баймж, үг бүтээврийг зөв бичих.....	114
Бүлэг VIII Бичигчийн санаа.....	119
Чухал хэсгийг ялгаж, бичигчийн санааг тайлбарлах.....	120
Санаагаа оруулан дэлгэрүүлж бичих.....	125
Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих.....	128
Бүлэг IX Үйл явдлын мэдээ, мэдээлэл.....	133
Үйл явдлын мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж унших.....	134
Үйл явдлыг 6 асуултын дагуу мэдээлж бичих.....	144
Хэл зүйн мэдлэгээ бататгах.....	145

VI ангийн монгол хэлний сурах бичгийн агуулга

№		Унших- сонсох	Бичих-ярих	Хэлний зүйг судлах
1	Харилцан яриа	Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж тодруулах	Санаа бодлоо бусдынхтай холбож, харилцан ярих	Жинхэнэ нэрийн хувиллын хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох
2	Үйл явдлын уялдаа холбоо	Эхийн бүтэц, учир шалтгааны уялдаа холбоо, орон цагийн дарааллыг задлан шинжлэх	Орон, цагийн дарааллаар өрнүүлэн, учир шалтгааны уялдаа холбоотой бичих	Үйлийн нөхцөлүүдийн хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох
3	Эхийн сэдэв, гол санаа	Бүтцийн хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлох	Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих	Орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох
4	Үйл явдлын орчин	Уншсан эхээс орон цагийн дүрслэлийг ялгаж, үйл явдлын орчныг тодорхойлох	Орон цагийн нэр, тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг ашиглан орчныг дүрслэх	Өгүүлбэрийг хурааж, дэлгэрүүлэн, цөм ба дэлгэрэнгүй бүтэц үүсгэж найруулах
5	Дүрүүдийн харилцан яриа	Уншсан эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох	Үйл явдалд харилцан яриа оруулан дэлгэрүүлэн бичих	Харилцан ярианд цэг тэмдгийг зөв бичих
6	Үйл явдлын цагийн дараалал	Эхээс гол мэдээллийг ялгаж унших	Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлэх	Эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулах
7	Бичигчийн сэтгэлийн өнгө аяс	Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах	Хэлц ашиглан мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө дүрслэн бичих	Баймж үг, бүтээврийг таньж, зөв хэрэглэх
8	Бичигчийн санаа	Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах	Эхэд өөрийн санаагаа оруулан дэлгэрүүлэн бичих	Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих
9	Үйл явдлын мэдээ мэдээлэл	Үйл явдлын мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж унших	Үйл явдлыг хэн?, хаана?, юу? яагаад?, хэрхэн? яав? асуултын дагуу мэдээлж бичих	Хэл зүйн мэдлэгээ бататгах

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХАРИЛЦАН ЯРИА

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж тодруулах
- Санаа бодлоо бусдынхтай холбож, харилцан ярих
- Жинхэнэ нэр, түүний хувиллыг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

ГОЛ АСУУДЛЫГ ОЙЛГОН, АСУУЛТ АСУУЖ ТОДРУУЛЪЯ

Бусдын яриаг ойлгон сонсьё.



- Анх уулзсан хүнд өөрийгөө танилцуулж байсан тохиолдол байвал түүнийгээ ярина уу.
- Шинэ багш, найз нартаа өөрийгөө яаж хөгжилтэй, сэтгэлд үлдэх, сайхан харилцаа үүсэхээр танилцуулж болох вэ?

Танилцуулан ярих гэдэг нь сонсож байгаа хүндээ ямар нэгэн зүйлийн талаар чин сэтгэлээсээ тодорхой мэдээлэл өгөхийг хэлнэ. Энэ үед ярьж байгаа хүн, сонсож байгаа хүн хоёрын хооронд сайхан харилцаа бий болдог.

1. Бусдын яриа танилцуулгад юуны тухай өгүүлснийг анхааран сонсоорой.

Инээд муут

/Нэг эрэгтэй хүүхэд инээмсэглэсээр босож ирээд өөрийгөө танилцуулав/



Сайн байцгаана уу? Намайг Амарбаясгалан гэдэг. Миний нэрийг нагац өвөө маань өгсөн юм л даа. Өвөө тайлбарлахдаа амар амгалан, тайван сайхан байгаасай гэж Амар, бусдад инээд хөөр бэлэглэж дандаа баясаж яваг гэж Баясгалан гэдэг үгийг сонгосон гэнэ лээ. Тийм болохоор би дандаа бусдын сэтгэлийг сэргээх сайхан үг хэлж инээмсэглэж явдаг. */дахин инээв/*

Зарим хүн намайг “Инээд муут” гэж дууддаг. “Инээд муут” гэхээр хэр баргийн юманд инээдэггүй хүн гэж зарим нь ойлгож магадгүй. Үнэндээ баясгалантай царайгаар инээмсэглэж явдаг хүнийг хэлдэг юм байна. Би энэ нэрдээ дуртай. Яагаад гэвэл үргэлж баяр баясгалантай байх чинь үнэхээр гоё шүү дээ.

Миний сонирхол хөгжим сонсох. Сэтгэлээр унасан үед хөгжилтэй дуу сонсвол сэтгэл сэргэдэг. Чимээгүй бодолд дарагдахыг хүсэх үедээ намуухан ая сонсдог. Ямар вэ ? Дажгүй биш гэж үү? */дахин инээв/* Бас дуулах дуртай.

Би сайн найз нартай болмоор байна. Хэрэв миний тусламж хэрэгтэй болбол хэзээ ч хамаагүй хэлээрэй. Нэг багт орж ингэж уулзах болсондоо баяртай байна.

Би шувуу сонирхдог

Сайн байна уу? Намайг Баттөр гэдэг.

Бүгд өөрсдийгөө сайхан танилцууллаа. Харин би бусдын өмнө ярих гэхээр сандардаг. Алдаа гаргавал намайг уучлаарай.



Би амьтанд дуртай. Одоогоор хоёр хөх цэгцгий шувуу ажиглаж байгаа. Энэ зураг нь байна. Хөөрхөн байгаа биз. Амралтын өдөр Туул голын шугуйд очиж хоёр шувуугаа байнга ажигладаг. Тэр хоёрын эвсэг, хүндэтгэлтэй харилцаа нь надад сайхан санагддаг. Би шувуунд дуртай болоод шувууны тухай олон ном цуглуулж уншсан. Бас "Хүрээлэн" амьд ертөнцийн цуврал нэвтрүүлэг, байгалийн тухай кино үздэг. Цаашдаа "Байгаль судлаачийн мэргэжил сонгоно" гэж бодож байгаа.

Би бас спорт, тоглоомд дуртай. Та нарын адил хөл бөмбөг тоглох бүр ч их дуртай. Чөлөөт цагаа хөгжилтэй өнгөрүүлцгээе. Уулзсандаа баяртай байна. Цаашдаа сайхан найзууд болцгооё.

Гол асуудлыг задлан шинжилье.

1. Хоёр сурагчийн танилцуулга хэдэн догол мөрөөс бүтсэн байна вэ?
2. Догол мөр бүрийн санааг тодорхойлоод, яагаад үүнийг тайлбарлах болсон шалтгааныг ярилцаарай.


Сэдэв: **Инээд муут**

Догол мөр	Догол мөрийн санаа юу вэ?	Үүнийг танилцуулсан шалтгаан нь юу вэ?
1-р мөр	Өөрийнхөө нэрийн утга учрыг танилцуулсан.
2-р мөр	Үргэлж баяр баясгалантай байхын тулд
3-р мөр	Өөрийнхөө хүслийг илэрхийлсэн.


Сэдэв: **Би шувуу сонирхдог.**

Догол мөр	Догол мөрийн санаа юу вэ?	Үүнийг танилцуулсан шалтгаан нь юу вэ?
1-р мөр	Бусдын анхаарлыг татах гэж
2-р мөр	Шувуунд дуртайгаа танилцуулсан.	Сонирхсон зүйлээ гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй гэдгийг мэдүүлэх гэж
3-р мөр	Бусадтай сайхан харилцаатай байх гэж

3. Дээрх хоёр танилцуулгыг харьцуулан, тулгуур бичиглэлийг тайлбарлан ялгааг ярилцана уу.



4. Цэгийн оронд тохирох үгийг нөхөөд, эхийн сэдвийг тодорхойлоорой.



Сонсогчийн асуулттай танилцъя.

1. Амарбаясгалан, Баттөр хоёрын танилцуулгыг сонсоод, найзуудын асуусан асуултыг уншаарай.

- Сонсогч: Амарбаясгалангаас асууя.
- Чи танилцуулга бэлтгэхдээ яагаад нэрийнхээ учрыг сонгож оруулсан юм бэ?
 - Дуудах нэрийг эцэг эх зүгээр ч нэг өгдөггүй, дандаа л ямар нэг зүйлийг бэлгэдэж өгдөг шүү дээ. Би нэрдээ маш дуртай учраас энэ түүхээ хуваалцъя гэж бодсон юм аа.
 - Чи хүмүүсийн сэтгэлийг сэргээх сайхан үг хэлж явдаг, бас үргэлж баяр баясгалантай байхыг хүсдэг, хөгжим сонсох дуртай юм чинь урлагийн мэргэжилтэй болох уу?
 - Магадгүй ээ. Одоохондоо сонгоогүй байгаа. \бас инээв.\
- Сонсогч: Баттөрөөс асуулт асууя.

- Чи амьтанд дуртай гэж ярьсан. Гэртээ амьтан тэжээдэг үү?
- Би гэртээ загас, муур, нохой, яст мэлхий тэжээдэг.
- Байгаль судлаачийн мэргэжил хэцүү биш үү?
- Хэцүү биш байх аа. Миний уншсан, сонссоноор амьтдын төрөл зүйл их устаж байгаа гэсэн. Тийм болохоор би тэднийг хамгаалмаар байна.

2. Дээрх асуултаас санаа аваад, асуултаа бэлтгээрэй.

Бусдын санааг ялган тайлбарлая.

Алаг шаазгай араг дээр суучхаад жир жир

Бат энэ хоёр зургийг ашиглан ярив.



Би Ж.Мягмарсүрэн зохиолчийн “Унагаа зуусан хулан” номыг уншлаа. Энэ номд олон амьтны тухай бичсэн байдаг. Үүнээс би шаазгайн тухай яаж бичсэнийг та нарт танилцуулан ярих гэсэн юм. Зохиолч шаазгайг тал талаас нь судалжээ **гэж би бодсон**.

Алаг шаазгай бол байгалийн зарлан тунхаглагч **гэнэ**. Юу болох гэж байгаа болон юу болж байгааг тэр хамгийн түрүүнд мэднэ. Маш мэдрэмтгий. Мэдрээд зогсохгүй түүнийгээ олон түмэнд шагшран зарладаг. Шүдэнзтэй хайрцаг сэгсэрч байгаа юм шиг шагшрах дуу нь анхаарч сонсвол олон янз байдаг. Баярт мэдээ, түгшүүрт мэдээ, ердийн амар амгаланг зарладаг **гэнэ**.

Шаазгай шагшраад эхэлмэгц “Хүүе ээ, цаана чинь юу болоод байна. Гараач. Шаазгай шагшраад уналаа” гэж авгай нар сандарч эхэлдэг. Шаазгай худлаа хэлээгүй байдаг. Их нүүдэл юм уу, аянчин жинчин ирж байхыг нисэж явахдаа харсан шаазгай хэл дуулгах гэж шон дээр нь яаран бууж шагширдаг байна. Зарим хүн шаазгайг худалч гэдэг ч худлаа хэлэх санаа түүнд байхгүй. Харин хүмүүс л өөрсдөө буруу

ойлгож андуурах талтай **ГЭНЭ**.

Манай шаазгайтай ах дүү гэмээр адилхан зантай шувуу Африк тивд байдаг байна. Нэр нь “балын зарч” шувуу. Тэр зөгийн бал олчихоод тосгон руу нисэж очин чанга дуугаар хашхиран жиргэж, далавчаа дэвж, цовхчин сүйд болдог **АЖ**. Хүмүүс араас нь очиж зөгийн балыг авдаг. Тэгэхдээ түүнд бал агуулж байсан сархинагийг салгаж өгдөг **ГЭНЭ**. Зарим хүн хуншгүй загнаж шувуунд хувийг нь үлдээдэггүй **АЖ**. Тэгвэл бяцхан шувуу их гомдоно.

Харин манай шаазгай цайлган. Түүний хэлснийг тоож байна уу, үл тоож байна уу гэдгийг анзааралгүй үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол шагшран шагширсаар л байдаг **ГЭЖ БИЧЖЭЭ**.

Би шаазгайн тухай уншаад түүнийг хайж, амьдаар нь үзсэн. Мөн шаазгайн тухай өөр зүйл уншиж, энэ олон зургийг цуглуулж тайлбар бичсэн байгаа. Та нар надаас шаазгайн тухай асуувал би мэдэж байгаагаа дуртай хариулах болно. Сайн анхаарч сонссонд баярлалаа.


1. Асуултад хариулан ярилцаарай.
 - а. Алаг шаазгай бол байгалийн зарлан тунхаглагч гэдгийг юу юугаар баталсан бэ?
 - Юу болох гэж байгааг хамгийн түрүүнд мэднэ.
 -
 -
 - ердийн амар амгаланг зарладаг.
 - б. Хүмүүс алаг шаазгайг худалч гэж хэлэх нь бий. Яагаад ингэж хэлдэг юм бол?
 - в. Манай алаг шаазгай, балын зарч шувуу хоёр ямар ялгаатай вэ?
2. Батын танилцуулгын бүтцийг задлан бичээд, тайлбарлаарай.

Эхийн хэсэг	Юуны тухай өгүүлсэн бэ?
Эхлэл хэсэг	<ul style="list-style-type: none"> • •
Гол хэсэгт	Алаг шаазгайн онцлогууд: <ul style="list-style-type: none"> • • • • танилцуулж байна.
Төгсгөл хэсэг	<ul style="list-style-type: none"> •

3. Ж.Мягмарсүрэнгийн бичсэн зохиолыг Бат бидэнд танилцуулан ярилаа. Зарим өгүүлбэрт ямар өөрчлөлт орж байгааг ажиглан, ялгааг тайлбарлаарай.
 Зохиолч: Алаг шаазгай бол байгалийн зарлан тунхаглагч **ЮМ**.
 Бат: Алаг шаазгай бол байгалийн зарлан тунхаглагч **ГЭНЭ**.
4. Бат өөрийн санаагаа хэрхэн баяжуулсныг тодорхойлоорой.
 - Эх сурвалжийг тодруулна уу.
 - Аль хэсэгт бусдын санаа бодлыг оруулсныг олж, тайлбарлаарай.
 - Аль хэсэгт Батын өөрийн санаа илэрснийг тодруулж, тайлбарлана уу.

САНАА БОДЛОО БУСДЫНХТАЙ ХОЛБОЖ ЯРЬЯ

1. Ярих сэдвээ доорх аргаар бэлтгээрэй. Үлгэрлэвэл:



Сэтгэлд үлдэхээр танилцуулга хийх арга

Ярихдаа сонсогчийн сонирхол татахуйц, санаа авмаар, амархан мартагдахааргүй байхаар илэрхийлээрэй.

1. Ярих зүйлийнхээ онцлогийг гаргаж болно.
2. Бусдаас ялгарах онцлогийг хялбархан ойлгуулахаар ямар нэгэн амьтан, эд зүйл зэрэгтэй зүйрлэж болно.
3. Сэдэвтэй холбоотой сонирхолтой баримт, мэдээлэл ашиглаж болно.
4. Ярихдаа цагаа сайн тооцоолох хэрэгтэй. Хэтэрхий удаан, эсвэл хурдан ярих хэрэггүй.

2. Ярих зүйлээ төлөвлөх нь хамгийн чухал. Төлөвлөгөөний дагуу танилцуулгаа бичээрэй.

- а. Найз нартаа өөрийнхөө тухай хамгийн түрүүнд мэдүүлэхийг хүсэж байгаа сэдвийг сонгох
- б. Эхэнд нь юу ярихаа төлөвлөх
- в. Дунд хэсэгт нь юу ярихаа төлөвлөх
- г. Төгсгөлд нь юу ярихаа төлөвлөх
- д. Сэтгэлийн хөдөлгөөнөө яаж илэрхийлэхээ шийдэх

3. Яриагаа сонирхолтой болгохын тулд юу ашиглахаа сайн төлөвлөөрэй.

Ямар ном, сэтгүүлээс мэдээлэл авах вэ?	Цахим орчноос ямар мэдээлэл авах вэ?	Бусдын ярианаас ямар баримт ашиглах вэ?
.....

4. Өөрийгөө танилцуулах төлөвлөгөөг бичихдээ дараах загварыг хэрэглээрэй.

Догол мөр бүрийн агуулга юу вэ?	Үүнийг яагаад таниулах болсон бэ?
Танилцуулгын нэр
Эхний догол мөр
Дараагийн догол мөр
Сүүлчийн догол мөр

ЖИНХЭНЭ НЭРИЙН ХЭЛ ЗҮЙН ШИНЖ, НАЙРУУЛГЫН ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛЪЁ

Жинхэнэ нэрийг таньж, ялгая.

Монгол хэлний үгийн аймаг



1. “Цэцэрлэгч өвгөн” эхийг уншаад, хэн? юу? гэсэн асуултад хариулагдах үгсэд асуулт тавиарай.
2. Асуулт тавьсан үгсээ хүн заасан, юм заасан, үзэгдэл заасан гэж ангилаарай.
3. Ангилсан үгсээ ажиглаад жинхэнэ нэрийн тухай ойлголтоо бататган тайлбарлаарай.

Цэцэрлэгч өвгөн

хэн? хэнийг? юуны? юунд?



Цэцэрлэгч өвгөн хүүхдүүдээ цэцэрлэгийн ажилд сургах сан гэж хүсдэг байжээ. Нас өндөр болж, хүүхдүүдээ дуудан ирүүлж:

За, хүүхдүүд минь. Намайг өнгөрөхөөр та нар усан үзмийн цэцэрлэгт нуусан юмыг олж аваарай! гэж захижээ. “Цэцэрлэг дотор эрдэнэ бий байх” гэж хүүхдүүд нь бодоод, эцгээ нас барсны дараа цэцэрлэгийн бүх газрыг онгичин ухжээ. Усан үзмийн газрыг хэчнээн дахин ухавч эрдэнэ олсонгүй.

Харин усан үзэм тарьсан газрын хөрсийг сайн сэндийлж ухсаны ачаар жимс учиргүй их ургаж, тэд баян чинээлэг, элбэг хангалуун амьдрах болжээ.

Лев. Толстой

4. Дараах тулгуур бичиглэлийг ашиглаад, жинхэнэ нэрийн талаар найз нартаа тайлбарлан яриарай.

Жинхэнэ нэр — ХҮН аав, ээж, Дорж, эмч
 — ЮМ унага, ус, завь, од
 — ҮЗЭГДЭЛ шуурга, аянга, бороо — зааж, ХЭН? ЮУ?
гэсэн асуултад хариулагдана


Жинхэнэ нэрийн утгыг мэдье.

1. Дараах эхэд байгаа үгсэд асуулт тавьж, жинхэнэ нэрийг олж, хоёр ангилан бичээрэй.

Бид 5-р анги төгсөхдөө монгол хэлний хичээлээр Т. Очирхүүгийн “Хүмүүс ээ! Надад урам хайрла” шүлэг, Н.Н.Носовын “Өргөст хэмх” өгүүллэгийг уншиж судалсан. Үлгэрээс Цуутын цагаагч гүү, Цолмон цоохор унаганы тухай мэдэж илтгэл тавьж, хэлэлцүүлэг хийн мэдээ мэдээлэл цуглуулж их зүйлд суралцлаа.

Ерийн нэр: Ямар нэг юмыг ерөнхийлөн нэрлэсэн жинхэнэ нэр анги...	Оноосон нэр: Ямар нэг юмыг оноож нэрлэсэн жинхэнэ нэр Т. Очирхүү-хүнд оноож өгсөн
---	--

2. Дараах тулгуур бичиглэлийг уншаад, жинхэнэ нэр ямар утга заадаг талаар найздаа тайлбарлан яриарай.



1. Өөрийгөө товч танилцуулж бичээрэй. Оноосон нэрийн зөв бичих дүрмийг ярилцаарай.

- а. Овог нэр
- б. Төрсөн газар /хот, аймаг, дүүрэг, сумын нэр /
- в. Оршин суугаа хаяг хот, аймаг, дүүрэг, сумын нэр /
- г. Сурч байгаа сургууль
- д. Аавын ажлын хаяг
- е. Ээжийн ажлын хаяг.....

Оноосон нэрийг зөв бичих дүрэм

Оноосон нэрийг өгүүлбэрийн хаана орсноос үл хамааран ямагт том үсгээр эхэлж бичнэ. Жишээ нь: Би Архангай аймгийн Хашаат суманд амьдардаг. Манай нутагт Өгийнуур оршдог.

Жинхэнэ нэрийн бүтэцтэй танилцъя.

1. Монгол хэлний үг бүтэх арга

Жинхэнэ нэр үг дагаврын аргаар бүтэх

Монгол хэлний бүх үгийг үүсмэл, үүсмэл биш гэж хоёр хуваадаг. Жишээ нь:

- Нар, яв, мал, хүн, хөх, өндөр гэвэл үүсмэл биш.
- Мал+чин- малчин, сур+гч- сурагч гэж шинэ үг үүсэж байна.

1. **Дагаврын аргаар үг бүтэх:**

- **Барь** гэсэн “яа-” гэсэн асуултад хариулагдах үйл үгэнд –**лга** гэсэн дагавар залгахад “юу” гэсэн асуултад хариулагдах жинхэнэ нэр, **барилга** гэдэг хүний хийж бүтээсэн юмны нэр үүсжээ.
- **Барилга** гэсэн юмны нэр заасан үгэнд –**чин** гэсэн дагавар залгахад “хэн” гэсэн асуултад хариулагдах, **барилгачин** гэсэн барилга барьдаг хүнийг нэрлэсэн утгатай үг бүтэж байна.

Ингэж шинэ үг дагаврын аргаар бүтэхэд яаж зөв бичих вэ? **барь+лга-зөөлөрсөн** эгшигт гийгүүлэгч “**рь**”-ийн дараа ардаа эгшиггүй “**лга**” дагавар залгахад “**ь**” нь “**и**” болно. **барилга+чин =барилгачин-эгшгээр** төгссөн үгэнд гийгүүлэгчээр эхэлсэн дагаврыг шууд залган бичнэ.

1. Дараах өгүүлбэрээс дагаврын аргаар бүтсэн үгсийг ялган, задалж тайлбарлаарай.
Бид хадан дээрх бичээс, эртний бичвэр, соронзон бичлэг зэргийг сонирхлоо.

Жинхэнэ нэрийн тоо

1. Дараах үгсийг ажиглаад, хоёр дахь хэсгийн үгсийг бүтцээр нь задалж бичээрэй.

морь, бөх, далай, тэмээ,
гэр, монгол

морьд, бөхчүүд,
далайнууд, тэмээнүүд,
гэр, монголчууд

2. Хоёр хэсгийн ялгааг тайлбарлан ярина уу.
3. Дараах үгсийг олон тооны утгатай болгон хувиргаарай.

*малчин, дэвтэр, гол, хөрөө, эмч, үнэг, ишиг, уул, унага, үр, ятуу,
жишээ, жигүүртэн, багш, гөрөөс, нагац, авга, жолооч*

Жинхэнэ нэр үгэнд –чууд, -чүүд, нар, -ууд, -үүд, -д, -с залгаврыг залгаж олныг заасан утга илрүүлнэ.


4. Дараах жинхэнэ нэр үгэнд тохирох олон тооны залгаврыг залгаж, зөв бичих дүрмийг тайлбарлан бичээрэй.
Жишээ нь: салбар+ууд-салбарууд “салбар” гэдэг гийгүүлэгчээр төгссөн жинхэнэ нэрд олон тооны “-ууд” эгшгээр эхэлсэн залгаврыг шууд бичнэ.

Эмэгтэй, эрэгтэй, дуучин, ширээ, нөхөр, нохой, тогооч, Хөвсгөл

5. Дараах өгүүлбэрийн цэгийн оронд олон тооны залгавар залгаж, зөв бичээрэй.

*Хөдөө орон нутагт ажиллахаар залуу..., эмч..., ажилчин..., багш...,
зохиолч..., саналаа өгөө*

Жинхэнэ нэрийн тийн ялгал



1. Дор өгсөн өгүүлбэрээс жинхэнэ нэрийг таньж доогуур нь зураарай. Асуулт тавьж утгаараа хойшоо ямар үгтэй холбогдож байгааг зурж тэмдэглээрэй. Жишээ нь:

Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй. (Д.Н)

2. Холбоо үг болгон задалж бичихдээ үгийг юугаар холбосныг тайлбарлаарай. Жишээ нь:

- тал**ын** шувууд ----- тал, шувууд гэсэн хоёр салангид үгийг харьяалахын тийн ялгалын **-ын** нөхцөл холбожээ.
- шувууд**ын** өндөг
- өндгө**нд** бүү хүргэх
- сүүдр**ийг**ээ бүү хүргэх

3. **-ын, -д, -ийг** гэсэн нөхцөлүүд дээрх өгүүлбэрт ямар үүргээр орсныг тайлбарлан яриарай.

4. Ямар аймгийн үг ямар аймгийн үгтэй холбогдож холбоо үг болсныг таньж цэгийн оронд нөхөн бичээрэй.

- Жишээ нь:
- талын – жинхэнэ нэр, шувууд – жинхэнэ нэр
 - шувуудын, өндөг
 - өндгөнд, бүү хүргэх
 - сүүдрээ, бүү хүргэх – үйл үг

Тийн ялгалын нөхцөл нь жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй, жинхэнэ нэрийг үйл үгтэй холбох үүрэгтэй.

1. Харьяалахын тийн ялгалын нөхцөл нь жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй холбоно.
Юуны ? юу?
 Хэнтий Хангай Соёны өндөр сайхан нуруунууд
2. Бусад тийн ялгалын нөхцөл нь жинхэнэ нэрийг үйл үгтэй холбоно.
хэн? яасан бэ?
3. Бат, Наран хоёр унших аргад сайн суралцсан.

4. Дараах “Дэвтэр” эхийг уншаад жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй, жинхэнэ нэрийг үйл үгтэй холбосон холбоо үг тав тавыг олж жагсаан бичээрэй. Жишээ нь:

- Содгэрэлийн дэвтэр --- жинхэнэ нэрийг жинхэнэ нэртэй холбосон.
- хаягтай байх --- жинхэнэ нэрийг үйл үгтэй холбосон.

1. “дэвтэр” гэдэг үг энэ эхэд хэдэн удаа орсон байгааг тооцож үзээд, ямар ялгаатайг ярилцаарай.

Дэвтэр

Содгэрэлийн дэвтэр цэвэрхэн, зөв хаягтай байдаг. Содгэрэл дэвтэрт тавих шаардлагыг сайн хангасан байна. Нэг дэвтрийг бүрэн дуусгаж нөгөө дэвтэрт бичнэ. Багш бидэнд жишээ болгож Содгэрэлийн дэвтрийг үзүүллээ. Түүний дэвтрийн хуудас ямагт бүрэн байдаг. Сурагчдын цэвэрхэн дэвтрээр үзэсгэлэн гаргав. Содгэрэл шиг цэвэрхэн бичиж, гамтай эдэлсэн дэвтэртэй сурагч манай ангид олон бий. Би Содгэрэл шиг нямбай ажиллаж сурахаар хичээж байна.

2. Дараах хүснэгтээс тийн ялгалын нэр, нөхцөл, асуулт, хувилгасан үгийн зөв бичих дүрмийг ажиглан тогтоогоорой.

	Тийн ялгал	Нөхцөл	Асуулт	Жишээ
1	Нэрлэх	-	хэн? юу?	самбар, эгч
2	Харьяалах	-ын, -ийн, -ы, -ий, -н	хэний? юуны?	самбарын, эгчийн
3	Өгөх-орших	-д, -г	хэнд? юунд?	самбарт, эгчид
4	Заах	-ыг, -ийг, -г	хэнийг? юуг?	самбарыг, эгчийг
5	Гарах	-аас, -ээс, -оос, өөс	хэнээс? юунаас?	самбараас, эгчээс
6	Үйлдэх	-аар, ээр, -оор, -өөр	хэнээр? юугаар?	самбараар, эгчээр
7	Хамтрах	-тай, -тэй, -той	хэнтэй? юутай?	самбартай, эгчтэй
8	Чиглэх	-руу, -рүү, -луу, -лүү	хэн рүү? юу руу?	самбар руу, эгч рүү

Тийн ялгалын нөхцөлийг хэрэглэе.

1. Гийгүүлэгчээр төгссөн гээгдэх эгшигтэй үг, **ж, ч, ш, г** гийгүүлэгчээр төгссөн эр үг, **ь**-ээр төгссөн эр үгийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгасныг ажиглан, зөв бичих дүрмийг ярилцаарай.

№	Тийн ялгал	Гээгдэх эгшигтэй үг	Ж, Г-ээр төгссөн эр үг	Ь-ээр төгссөн эр үг
1	Нэрлэх	сандал, дэвтэр	багаж, будаг	толь, бахь
2	Харьяалах	сандлын, дэвтрийн	багажийн, будгийн	толины, бахины
3	Өгөх-орших	сандалд, дэвтэрт	багажинд, будагт	толинд, бахинд
4	Заах	сандлыг, дэвтрийг	багажийг, будгийг	толийг, бахийг
5	Гарах	сандлаас, дэвтрээс	багажаас, будгаас	толиос, бахиас
6	Үйлдэх	сандлаар, дэвтрээр	багажаар, будгаар	толиор, бахиар
7	Хамтрах	сандалтай, дэвтэртэй	багажтай, будагтай	тольтой, бахьтай
8	Чиглэх	сандал руу, дэвтэр рүү	багаж руу, будаг руу	толь руу, бахь руу


2. Дээрх хүснэгтийг ашиглаад, багана бүрд тав таван үг олж, тийн ялгалын нөхцөлөөр хувилгаарай.
3. Богино, урт хос эгшгээр төгссөн үг, оноосон нэрийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

№	Тийн ялгал	Богино, урт, хос эгшгээр төгссөн үг	Оноосон нэр
1	Нэрлэх	хурга, лаа, далай	Завхан, Гэрэл
2	Харьяалах	хурганы, лааны, далайн	Завханы, Гэрэлийн
3	Өгөх орших	хурганд, лаанд, далайд	Завханд, Гэрэлд
4	Заах	хургыг, лааг, далайг	Завханыг, Гэрэлийг
5	Гарах	хургаас, лаанаас, далайгаас	Завханаас, Гэрэлээс
6	Үйлдэх	хургаар, лаагаар, далайгаар	Завханаар, Гэрэлээр
7	Хамтрах	хургатай, лаатай, далайтай	Завхантай, Гэрэлтэй
8	Чиглэх	хурга руу, лаа руу, далай руу	Завхан руу, Гэрэл рүү

- Дээрх хүснэгтийг ашиглаад багана бүрд тав таван үг олж, тийн ялгалын нөхцөлөөр хувилгаарай.

Жинхэнэ нэрийн хамаатуулах нөхцөл

“Гэр бүтээсэн эцгийнх**ээ** ухаанд хөвгүүд **нь** биширч, аятай тавтай аж төрөх болжээ. Аав нь хадан гэрт**ээ** буцах боллоо” гэсэн өгүүлбэрийн тодруулсан нөхцөл хэнд хамаатуулж байгааг ярилцаарай.



Биед хамаатуулах нөхцөл

- Дараах өгүүлбэрт байгаа тодруулсан нөхцөл хэнд хамаатай болохыг ярилцаарай.
 - Аав **тань** сайн байна уу?
 - Аав **маань** амар сайн сууж байна.
 - Доржийн ээж хаана амьдарч байгаа вэ?
 - Ээж **нь** Завхан аймагт өвөлжиж байгаа гэнэ лээ.



БИ
1-р бие

МИНЬ, МААНЬ



ЧИ, ТА,
2-р бие

ЧИНЬ, ТАНЬ



ТЭР, ЭНЭ
3-р бие

НЬ

- Дараах эхийг уншаад биед хамаатуулах нөхцөлтэй үгийг ялгаж, хэнд хамаатай болохыг тайлбарлаарай.

Сурцгаа, дүү нар минь!

Хөөрхөн хонгор дүү нар минь
 Хөгжилтэй бяцхан охид минь
 Эцэг эх чинь та нараас
 Эрдмийн ихийг хүсэж байна.
 Эгч ах нар чинь та нараас
 Эрхэм сахилгыг хүсэж байна.
 Багш нар чинь та нарын төлөө зүтгэж
 Баян нутаг чинь та нарын төлөө цэцэглэж
 Сайхан бүхнийг та нарын төлөө зориулж
 Сайн бүгдийг та нарт өгдөг.
 Сурцгаа дүү нар минь, сурцгаа
 Соёлын зам урт байна.

Ч.Лхамсүрэн, Шүлэг найраглал, 1941

Эзэнд хамаатуулах нөхцөл

1. Дараах өгүүлбэрийг уншаад тодруулсан нөхцөлийн утгаас **ЭНЭ ЮМ** хэнийх болохыг тодорхойлоорой.
 - Тэгээд өвгөн долоон хүүтэйг**ээ** хана**аа** дэлгэж, хаал**гаа** босгож, тооно**оо** өргөж, уни**а** өлгөж, туурга**аа** барьж, дээвр**ээ** тавьж, бүслүүр**ээ** татаад бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ.
 - Удаах ах нар нь удалгүй хаалга, тооно, унь, дээвэр, туурга**аа** үүрсээр ар арааса**аа** цувран айсуй. Тийнхүү долоон хүү буурал эцгийнх**ээ** гэрээс үгийн учрыг сая л ухаарч, түүнээс хойш, үеийн үед, өргөө цагаан гэр**ээ** эвийн сүлд болгон дээдэлсээр амар сайханд**аа** жаргажээ.
2. Дараах өгүүлбэрээс эзэнд хамаатуулах нөхцөлтэй үгийг ялгаж, энэ юм хэнийх болохыг тодорхойлон ярилцаарай.

... Дараах хүү туургандаа хоргодон суутал уулын үер урсгаад явчих шахав. Бас нэг нь дээвэр дороо амарч хэвттэл хуй салхи босож хуу татаад хаяж гэнэ. Нөгөө нь толгой дээрээ тооноо өргөөд сууж байтал шөнө болж, араатан чоно тал талд нь архиралдаж золтой л хүү татчихсангүй. Униа боож шовойлгон хоргодож суусан нэгийг нь хүйтэн жавар хайрч хөлдүүс болгох дөхөв гэнэ. Бүслүүрээс ондоо юм үлдээгүй болохоор отгон дүү нь бүр ч хэцүү байсан нь мэдээж.

... "Ханан гэрээсээ аав нь хадан гэртээ буцах боллоо. Яаж аж төрөхийг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү бүслүүрээ л чангалж яваарай" гээд насан өөд болжээ.

... Бие биедээ найдсаар хэн нь ч чангалж таталгүй суутал гэр нь яйжийж унав гэнэ.

Эзэнд хамаатуулах нөхцөл –аа, -ээ, -оо, -өө

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

1. “Минж бодож сэтгэдэг байж магадгүй” эхийг уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Минж бодож сэтгэдэг байж магадгүй

Булган гол өнөө жил ус багатай байгаа аж. Яагаад гэвэл Алтайн цаадах говьд байнга нүүрлэдэг их ган гачиг нөлөөлж эхэлсэн нь мэдээж. Энэ голд цөөн тооны минж бий.

Булган голын минж овоохойгоо улиас бургас модоор барина. Яндангийн чинээ модыг тас мэрж унагана. Шүд нь хурц, унагасан модоо зөөхийн тулд суваг татна. Газраар чирч байснаас усаар хөвүүлэх нь хамаагүй амар. Моддыг зөрүүлэн босгож мөчрөөр сүлжин бэхэлж хаяаг нь шавардаж битүүлдэг байна. Морины хусуур хэлбэрийн хайрсан сүүл нь нийвий болдог аж. Овоохой босгож буй нь энэ. Овоохойнуудтай тохой байнга устай байх ёстой. Тийм байлгахын тулд далан барина.



Ажилсаг, ухаалаг, цэвэрч, нямбай энэ амьтад эрэг дээр нь амьдрагч зарим хүнээс илүү байх шиг санагддаг сан. Малчид түлээ бэлтгэнэ гэж байхгүй. Тэгсэн атлаа минжний унагачихсан модноос хулгайлна. Тэгэхэд минж шөнө нь нөгөө модныхоо араас заавал ирдэг. Тэр, нохой шуугиулж ганц модыг шөнөжингөө гол руу чирдэг. Гол дээр шугуй шуугьж байхад иймхэн юмны төлөө үхэхээ мэдэхгүй зүтгэнэ гээч. Иймхэн ч юу байх вэ дээ. Хөлс хөдөлмөр нь шингэсэн эд шүү дээ.

Булган голын хөндий гантай байна. Минжний овоолсон, босгосон нь ч бага л харагдана. Гэхдээ тэд нэгийг бодож байгаа биз. Минжийг сэтгэдэг байж магадгүй гэж эрдэмтэд

горьддог. Яагаад гэвэл минжнээс тэнэг хүн олон байдаг учир ингэж бодоход хүргэсэн.

Ж.Мягмарсүрэн

Унагаа зуусан хулан, 2004

1. Асуултад хариулан бичээрэй.
 - а. Булган гол ус багатай байдгийн учир юу вэ?
 - б. Нийвий гэдэг үгийн утга аль нь вэ?

Тулгуур	Шавар түрхдэг багаж
Боодол	Морины хөлсний хусуур
 - в. Тохой гэдэг үгийн утгыг бичнэ үү.
 - г. Гол дээр шугуй шуугьж байхад минж яагаад иймхэн юмны төлөө үхэхээ мэдэхгүй зүтгэнэ вэ?
 - д. Минж яагаад зарим хүнээс илүү санагдах болсон бэ?
 - е. “Минж сэтгэдэг байж магадгүй” гэсэн санааг баримтаар нотолно уу.
 - ё. “Минж сэтгэдэг байж магадгүй” эх нь минжийг танилцуулсан эх мөн үү? Батлан тайлбарлаж бичээрэй.
2. “Минж сэтгэдэг байж магадгүй” эхийг ангийн найз нартаа танилцуулан бичээрэй.
 - а. Зохиолчийн бичсэн эхийг уншаад, бусдад танилцуулахдаа өгүүлбэрээ ихэвчлэн ямар үгээр төгсгөх вэ?
 - б. Өөрийн санаагаа төгсгөл хэсэгтээ дүгнэн бичээрэй.
3. Цэгийн оронд тохирох залгаврыг нөхөж бичээд зөв бичих дүрмийг тайлбарлана уу.
4. Оноосон нэрийн доогуур 1, ерийн нэрийн доогуур 2 зураарай.

Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруу...
 Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уул.....
 Мэнэн, Шарга, Номины өргөн их говь....
 Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далай.....
 Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрөн
 Хотол олны эм болсон горхи булаг рашаан

Д.Нацагдорж, Түүвэр зохиол, 2016
5. Дараах үгс ямар тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөлтэй байгааг тайлбарлан бичнэ үү.

ахынхаа, дугуйтайгаа, түлээ, дугуй, дугуйнаасаа, хүүхдүүд
6. Цэгийн оронд тохирох тийн ялгалын нөхцөлийг зөв залгаж бичээрэй.

... Монгол нутаг хангай газар дэлгэр зун... сайхан өдөр хонь... хариулна гэдэг юутай сайхан билээ.

Хавар... сүүлч... цас
 Хамаг... сүүлч... цас
 Харахад цав цагаан
 Хавар ... цас орж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮЙЛ ЯВДЛЫН УЯЛДАА ХОЛБОО

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Эхийн бүтэц, учир шалтгааны уялдаа холбоо, орон цагийн дарааллыг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних
- Орон, цагийн дарааллаар өрнүүлэн, сэдэв, агуулгын хэсгүүдийг учир шалтгааны уялдаа уялдаа холбоотой бичих
- Үйл үг, түүний хувиллыг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

ЭХИЙН БҮТЭЦ, УЧИР ШАЛТГААНЫ УЯЛДАА ХОЛБООГ ЗАДЛАН ШИНЖИЛЬЕ

Эхийн утгыг ойлгоё.

1. Эхийг уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.

Нэгэн сэхээ

Олон нуурын голд Хэцүү цүнхээл гэж зард гарсан бэрх нуур байдаг юм. Томоороо ч гавихгүй л дээ. Нэг захаасаа нөгөө захаа хүртэл ердөө зуугаадхан л алхам. Жижигхэн хэрнээ учиргүй гүнзгий эргүүлэгтэй, дотор нь орсон хэрийн амьтан эсэн мэнд эргэж гарах нь ховор дуулддаг. Уг нь ус нь тунгалагхан тогтуун дөлгөөн, ёроолын шаргал элс нь тун ойрхон мэт туяаран харагддаг. Дэргэдүүр нь янз бүрийн өвс ургамал алаглан ургасан, хажуухандаа нарийн ширхэгтэй зөөлөн элстэй, ёстой л амьдарч байгууштай сайхан газар байдаг юм. Зургаан сарын аагим халуун ид шатаж байсан үе юм сан. (1)

Мятав "Хонь салхидаад Хэцүү цүнхээлд үйчих вий, юмыг яаж мэдэх вэ?" гэсээр нуурын хойд ухаа дээгүүр гарч иржээ. Гэтэл бачимдсан хүний муухай орилох дуу гарч гэнэ. Тогтож харвал, нуурын усанд нэг хүн орчихсон үе үе шовхийн, сарвалзаж байгаа үзэгдлээ. Мятав нэг мэдэхнээ нуурын эрэг дээр ирчихсэн "Одоо яана аа сүйд боллоо. Нуур луу орчихоор хамт өнгөрчих, гарт нь бариулчих гэхээр юу ч байдаггүй" гэж гаслан зогсож байв. Ядаж уснаас их айдгийг хэлэх үү, яадаг ч аргаа олохгүй нэг хэсэг болжээ. Нөгөө хүн нэг ил гарч, нэг далд орж орь дуу тавьсан хэвээр. Дууны нь хүч улам суларч байхыг үзээд бүр ч их бачимдсан гэнэ. "Улс амьтанд дуулгая уу" гээд эргэтэл тэвдсэндээ болоод морио алдчихсан хөл залгаж хэл хүргэх унаа бүү хэл, гартаа барьсан шидэмсний тасархай ч үгүй хоцорсон байжээ. (2)

"Яана аа, өнгөрчихлөө л дөө" гэж харамсан ийш тийшээ хартал бөөр алаг хүрэн бяруу нь оодгонон сүүл хатгасаар айсууг үзэнгүүт:

-Тэгдэг хэрэг, болдог арга! гэж дуу алдан бярууг амдлаа. Ялаа шумуулд хөөгдөн ухаан жолоогүй яваа бярууг ойртоод ирэхээр нь ухасхийн сүүлдэж барьж аваад, тэврэн нуур луу гүйв. Нуурын эрэг дээр ирж, нөгөө хүний ил гарч ирэхийг отоож байснаа байдаг чадлаа шавхан, бярууг нуурын тэг дунд чулуудчихлаа. Палхийх сүртэй чимээ гарч, Мятав цалгисан усны хүчит давалгаанд цохигдон, ар тийшээ саван унажээ. (3)

Долгио намдахаар эргэн тойрноо харсан чинь нөгөө хүн тэртээ эргийн шаргал элсэн дээр хэвтээ харагдлаа. Очтол нөгөө хүн амьсгаа авч жаахан уужраад:

-Ус, элс хоёрт үхэх шахлаа. Юу ч болов доо. Усанд сарваганаж явтал минь нэг хүн том алаг юм чулуудчих шиг болсон. Тэгсэн чинь ус хүчтэй палхийгээд, би түүнээс үүссэн хүчтэй долгионд цохигдон шидэгдэж, яаж ч чадалгүй элс рүү шаачхаад, бүтэж үхэх шахлаа гэхэд:

-Арай хүчтэй шидчихсэн юм болов уу даа. За яамай, яамай. Эрдэнэт хүний амь л мэнд гарсан бол болох нь тэр! гэж Мятав олзуурхан баярлаж суужээ. (4)

Хүний золионд амь алдах шахсан бярууны хошуу үе үе цухалзан явсаар, нуурын эрэг рүү огло харайн гарч, усаа шилгээгээд "Ингэж сэрүүцүүлдэг бол ч аюултай юм байна" гэсэн янзтай эзэн рүүгээ харж байснаа ижлээ үгүйлэх мэт мөөрөн, гэрийн зүг шогшиход Мятав:

-Ингэх л ёстой сон. Овоо шүү, бөөр алаг минь. Монгол үхрийн эрдмийг ёстой нэг үзүүлж чадлаа даа гэж бахдан хайрлажээ. (5)

Ш.Цэнд-Аюуш.

Монголын уран зохиолын дээжис, 102-р боть, 2008

- Тэмдэглэсэн үгийн утгыг хам сэдвийн хүрээнд таамаглан ярилцаарай.
- Дараа нь тайлбар толь бичгээс утгыг нь мэдэж тайлбарлана уу.

Тэмдэглэсэн үгээ тайлбар толь бичгээс цагаан толгойн дарааллын дагуу хайж олно.

Тайлбар тольд буй үгийн тайлбарыг уншина.

Уншсан үгийн утгыг эхийн агуулгатай холбоно.

хонь **салхидаад**
Хэцүү цүнхээлд
үйчих вий

САЛХИДАХ

- Салхинд зүдэх, ядрах;
- Нохой зэрэг үнэрч амьтан салхин талаас ямар нэгэн зүйлийн үнэрийг сэрж мэдрэх, үнэр авах;
- Амьтан **салхи сөрж явах**

цүнхээл, эргүүлэг, үйх, ухаа, өнгөрөх, шидэмс, оодгонох, отох, шилгээх

2. Асуултад хариулж, ярилцаарай.

- Энэ болсон явдалд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Яагаад тэр газрыг “Хэцүү цүнхээл” гэж нэрлэсэн бэ?
- Мятавт тохиолдсон бодит явдлыг дүрслэхэд чухал үүрэгтэй түлхүүр үгсийн доогуур зураарай.
- Зурсан үгсээ ашиглан тулгуур бичиглэл хийж, эхийн гол санааг дүгнээрэй.
- Мятавын аварсан хүн, Мятав, алаг бяруу гурвын харьцааг дараах байдлаар гаргаж болох уу?

нуур } хүн — Мятав — алаг бяруу } нуур
элс } } эрдэм

е. Догол мөр бүрийн утгыг шинжлээд эхийн гол санааг тайлбарлаарай.

3. Дараах асуултад хариулж, болсон явдлыг амьдралд тохиолдсон үйл явдалтайгаа холбон ярилцаарай.


- Чи энэ болсон явдлыг уншсанаар өөрийнхөө эргэн тойронд болсон ямар нэг явдлыг эргэн санасан уу? Яриарай.
- Хэрвээ усанд живж буй хүнтэй таарсан бол чи хамгийн түрүүнд ямар арга хэмжээ авах вэ?
- Чи үерлэсэн юм уу, эсвэл орж үзээгүй, мэдэхгүй гол ус аюултай гэдгийг хэн нэгэнд хэрхэн ухааруулж ойлгуулах вэ?

Эхийн бүтэц, дарааллыг шинжилье.

а. Дараах хүснэгтийн дагуу эхийн утга, бүтцийг шинжлээрэй.

Эхийн хэсэг	Догол мөрийн дугаар	Юуны тухай өгүүлсэн бэ?
Эхлэл	(1)	Хэцүү цүнхээлийн тухай
Гол	(2)	Усанд хэн нэгэн живж байгаа тухай
	(3)	
	(4)	
Төгсгөл	(5)	

б. Эхийн бүтцийг шинжлэхдээ дараах даалгаврыг гүйцэтгээрэй.




в. Хаана, ямар үйл явдал болсон дарааллыг доорх хүснэгтэд нөхөөрэй.

Орны дараалал	Үйл явдал
нуурын хойд ухаа дээгүүр ↓	Мятав гарч ирэв.
нуурын усанд ↓	Нэг хүн орчихсон үе үе шовхийн, сарвалзаж байгаа үзэгдлээ.
нуурын эрэг дээр ↓	
нуур луу ↓	
нуурын эрэг дээр ↓	
элсэн дээр ↓	
нуурын эрэг рүү	

Хүүрнэсэн эхэд үйл явдал орон, цагийн дарааллаар өрнөдөг. Энэ эхэд үйл явдал орны дарааллаар өрнөсөн байна.

Үйл явдлын учир шалтгааны холбоо хамаарлыг тодорхойлъё.

1. Асуултад хариулаарай.
 - Мятав хэзээ, хаана живж буй хүнтэй таарсан бэ?
 - Хонь салхидаагүй бол Мятав Хэцүү Цүнхээл рүү явах байсан уу?
 - Мятав яагаад морь ч үгүй, шидэмсний тасархай ч үгүй хоосон хоцорсон бэ?
 - Живж буй хүн юунаас болж нуурын эргийн элсэн дээр унасан бэ?
 - Эрдэнэт хүний амь мэнд гарах шалтгаан нь юу байв?
 - Мятав юуны учир ихэд олзуурхаж, баяртай байсан бэ?
2. Бат асуултад хариулсан дээрээ тулгуурлан эхийн учир шалтгааны холбоо хамаарлыг бүдүүвч зургаар ингэж илэрхийлжээ. Зөв бурууг шүүн дүгнээрэй.



3. Дээрх тулгуур бичиглэлийг өөрийнхтэйгөө харьцуулан ялгааг ажиглана уу.
 - а. Яагаад хоёр үгийг улаан, бусад үгийг ногооноор будсан юм бол?
 - б. Эдгээр түлхүүр үгийн заримыг сумаар холбоогүй, заримыг нь сумаар холбосны учир юу вэ?
 - в. Аль нь учир шалтгааныг бий болгож, аль хэсэг нь холбоо хамаарлыг үүсгэж байна вэ?

Учир шалтгаан гэж юу вэ?


Энэ ямар учиртай юм бэ? гэж асуудаг. Юм бүхэн, болж байгаа үйл явдал бүхэн ямар нэг шалтгааны улмаас бий болдог. Эхний үйл явдал дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болно. Учир шалтгаанаас үүссэн үйл явдлууд хоорондоо холбоо хамааралтай байна.

Ямар учраас, яагаад, ямар асуудал урган гарч ирсэн бэ? гэх зэрэг асуултаар учир шалтгааны холбоо хамаарал урган гарна.

Өгүүллэгийн зангилаа буюу учир шалтгаанаас дараагийн үйл явдал өрнөнө.

Учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгосноо бататгая.

Үндэс



Өвс ургамал, навч цэцэг ургавал хүн ба амьд амьтад даган баясдаг. Ургамал бол бүх амьд амьтны үндэс билээ.

Иш нь дээшээ нахиалж, үндэс нь газарт ургадаг. Навч, гэрлийг чиглэн нарны туяаг шингээдэг бол үндэс нь хөрсөнд шигдэн газрын шим тэжээлийг өөртөө шингээдэг. Навч, мөчир зэргийн ургаж байгаа нь нүдэнд харагддаг ч үндэс нь бидэнд харагддаггүй.

Нүдэнд харагддаггүй энэхүү үндэс нь газрын гүнд тархаж бат бөх болбол илүү их үржил шимийг өгч чаддаг. Үндэс эрүүл байвал навч нахиалж, цэцэг дэлгэрч, жимс жимсгэнэ ургана. Навч нь үндсээр дамжин ирсэн шим тэжээлийг авч нарны туяаг шингээн хүнд шаардлагатай хүчилтөрөгчийг түгээн,

хүн ба амьтны гаргадаг нүүрстөрөгчийн хийг сордог. Үндэс газар сайн сууж гэмээн өндөр, сайхан ургана. Үндэс өчүүхэн, ядмагхан байвал мод, навч цэцэгс хатаж хорчийн цаашлаад үхдэг.

Үндсийг сайтар бодож тунгаавал үндэс суурийн талаар бодогдох болно. Миний бодлын үндэс хаанаас эхэлж, хаашаа явж байгаа бол? Үндэсгүйгээр амьдрал ямар утга учиртай вэ? Навч гэрэл рүү чиглэдэг шиг би хаашаа чиглэн амьдарч байгаа юм бол? Миний бодлын үндэс хаанаас үүдэлтэй юм бол? Манай өвөг дээдсийн үндэс угсаа хаанаас эхлэлтэй юм бол? Миний аз жаргалтай амьдрах үндэс хаана байгаа юм бол? Яагаад хүн аз жаргалтай амьдрахыг хүсдэг юм бол?

Нэгэн яруу найрагчийн хэлсэн шиг “Хавар модонд маш сайхан навчин хувцас өмсгөдөг, харин зун модонд цагаан, улаан, шар цэцэгсийг дэлгэрүүлж өгдөг, намар амтат жимс жимсгэнэ, өнгө өнгийн навчсыг өмсгөдөг бол хахир хүйтэн өвөл модонд амралт өгдөг”. Хүний амьдралд хавар, зун, намар, өвөл гэж байдаг. Хүүхэд нас бол миний амьдралын хаврын улирал юм.


*Дон Боскогоос хүүхэд залуучуудад илгээсэн захидал,
2016*

Зургийг ба анги Б.Алимансаран



Өгүүллэгийн учир шалтгааны холбоо хамаарлыг задлан шинжилье.

1. Уншаад утгыг ойлгоорой.
 - а. Унших явцдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглэж уншаарай.
 - б. Тэмдэглэсэн үгийн өмнөх хойдох үгийг ажиглаад ямар утгатай болохыг тайлбарлаарай.
 - в. Эхийн агуулгыг таван мөрд багтаан товчлон бичнэ үү.
2. Өгүүллэгийн үйл явдлын холбоо хамаарлыг задлан шинжлээрэй.
 - а. Өгүүллэгийн догол мөр бүрийн илэрхийлж байгаа утга санаанд тохирох нэр өгч, үйл явдлыг тайлбарлан яриарай.
 - Ургамал бол бүх амьд амьтны үндэс
 -
 -
 -
 - б. Дараах тулгуур бичиглэлийн дутууг гүйцээгээд ярилцаарай.



3. Өгүүллэгийн утга бүтцийг тодорхойлж, нэгтгэн дүгнээрэй.
 - а. Дараах асуултыг ашиглан, эхийн сэдвийг тодорхойлон найзтайгаа ярилцаарай.
 - Яагаад “Ургамал бол бүх амьд амьтны үндэс” гэж хэлсэн бэ?
 - Нүдэнд харагдаж байгаа навч, цэцэг, мөчир яагаад гоё харагддаг вэ?
 - Үндэс бат бөх, шим тэжээл сайн авч байх нь юунд хэрэгтэй вэ?
 - Яагаад ургамлын үндсийг хүний үндэс суурьтай зүйрлэсэн бэ?
 - Яруу найрагчийн хэлсэн үгийг тайлбарлана уу.
4. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг дараах хүснэгтэд бичээрэй.
5. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэг яаж холбогдож байгааг зурж холбоорой.

<p>Эхлэл Ургамал бол бүх амьд амьтны үндэс</p>	<p>Гол хэсэг Модны үндэс Миний бодлын үндэс</p>	<p>Төгсгөл хэсэг Яруу найрагчийн үг</p>
---	--	--

Учир шалтгааны уялдаа холбоотой бичье.

1. “Үндэс” эхийн учир шалтгааны холбоо хамаарлыг загвар болгоод, “Миний бодлын үндэс” сэдвээр хүүрнэсэн эх зохион бичнэ үү.
2. Бичихдээ дараах төлөвлөгөөний дагуу бичээрэй.

Миний үндэс

- а. Ургамал бол бүх амьд амьтны үндэс юм.
 - б. Навч гэрэл рүү чиглэдэг шиг чиний бодол юунд тэмүүлж байна вэ?
 - в. Мөрөөдлөө биелүүлэхийн тулд юу сурч, хэрэгжүүлэх вэ?
 - г. Аз жаргалтай амьдрахын тулд өөрийнхөө ямар сайн талыг хөгжүүлэх вэ?
3. Бичсэн эхээ дахин уншиж найруулгын болон зөв бичих дүрмийн алдааг хянаарай.
 4. Дараах шалгуураар үнэлж сайжруулаарай.

Бүтцийн хэсэг	Үнэлгээний асуулт	Үнэлгээ
Эхлэл	Эхлэл хэсэгт зангилаа асуудлыг шийдэж чадсан эсэх	☺☺☹
Гол	Үйл явдлыг өрнүүлэн бичиж чадсан эсэх	☺☺☹
Төгсгөл	Үр дүнг тодорхой бичиж чадсан эсэх	☺☺☹
Учир шалтгааны холбоо хамаарлыг гаргасан байдал	Зангилаа хэсгээ бичсэн эсэх	☺☺☹
	Шалтгаанаа дэлгэрүүлэн бичсэн эсэх	☺☺☹
	Зангилаагаа төгсгөл хэсэгтэй холбон бичиж чадсан эсэх	☺☺☹

ҮЙЛ ҮГИЙН ХЭЛ ЗҮЙН ШИНЖ, НАЙРУУЛГЫН ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛЪЁ

Үйл үгийг таньж, ялгая.

1. “Аялалд явах” эхийг уншаад яаж, яах, яадаг, яаж байна вэ? гэсэн асуултад хариулагдах үгсийг тэмдэглэж асуулт тавиарай.
2. Эдгээр үгс юуг зааж, ямар утга илэрхийлж байгааг ярилцаарай.
Жишээ нь: явах – яах гэсэн асуултад хариулагдан, явах үйл хөдлөлийг заажээ.
3. Ялгасан үгсээ ажиглаад үйл үгийн тухай тайлбарлаж яриарай.

Аялалд явах

яахдаа? яах? яах?

Та нар аялалд явахдаа гал түлэх, хоноглох газраа зөв сонгох нь чухал. Ойд гал түлэх хэрэг гарвал цагаан газрыг сонго. Хөрс болон ширгийг сул шороонд нь хүртэл хуулан хажуу тийш нь тавиарай. Ингэж түлсэн гал аюул багатай ба буцааж тавьсан ширэг нь амархан сэргэж ургана. Хуурай өвсөн дээр, шигүү модтой шилмүүст ойд гал түлж ер болохгүй. Гал тэр дорхноо тархана.

- а. Дараах тулгуур бичиглэлийг ашиглаад үйл үгийн тухай ойлголтоо бататган тайлбарлаж яриарай.

<p>Хүн /Бат/ Юм /бөмбөг/ Үзэгдэл /салхи/</p>	} үйл хөдлөл зааж	{	<p>яаж байна? яаж? яадаг? яах? яагаад?</p>
--	-------------------	---	--

1. Үйл үгийг ялган таньж, тайлбарлан ярилцъя
 - а) “Ус” эхийг уншаад үйл үгийн доогуур зурж тэмдэглээрэй.
 - б) Үйл үгээсээ ургуулан асуулт тавьж, ямар нэр үгтэй холбогдсоныг зурж тэмдэглээрэй.
 - в) Яаж холбогдсоныг тайлбарлан яриарай.

Жишээ нь:



Өндөр уулын оройд үүл манан тунана.

Юу тунана? Үүл манан тунана.

Хаана тунана? Уулын оройд тунана.

Ус

Өндөр уулын оргилд үүл манан тунана
Өндөр түүний хавцлаас түргэн мөрөн урсана
Өнөө бидний харахад үүл манан, цас, мөс
Өнгөнд ялгавар олон ч чанартаа ганцхан ус
Харсаар байтал хувилах тунгалаг хар ус
Хамаг амьтныг ундаалах рашаан болсон ус.

Ц Дамдинсүрэн

Монголын уран зохиолын товчоо, 2007



Үйл үгийн утгыг мэдье.

1. Дараах зургийг ажиглаад, дэлгэрэнгүй өгүүлбэр зохион бичээрэй.



2. Зохиосон өгүүлбэрийнхээ үйл үгсийг жагсаан бичээрэй. Жишээ нь:
тоглох, услах

3. Дээрх жагсаан бичсэн үйл үгээс ургуулан, асуулт тавьж, холбоо үг зохиогоорой.

<i>дээсээр</i> тоглох салхилах
..... услах шуурах
..... орох ганхах
<i>шүхэр/ийг/</i> барих бичих

4. Дээрх холбоо үгсийг дараах асуултын дагуу хоёр ангилан бичээрэй.


Үйл үгийн өмнөх үг заахын тийн ялгалд байгаа	Үйл үгийн өмнөх үг заахын тийн ялгалд байхгүй байгаа
1. шүхэр/ийг/ барих	6. дээсээр тоглох
2.	7. хүүхэд унтах
3.	8.
4.	9.
5.	10.

5. Дараах үгсэд заахын тийн ялгалын нөхцөл залгаж бичихэд яаж зөв бичих вэ?
шүхэр+ийг, цэцэг+ийг, бичиг+ийг, дугуй+г, бөмбөг+ийг, утас+ыг

Тусах ба эс тусах үйл үг

Үйл үгийг утгаар нь тусах, эс тусах гэж хоёр ангилна.
Үйлэнд өртөж байгаа юмыг заахын тийн ялгалаар хэлбэржүүлэн захирч байгаа үгийг **тусгах үйл** үг, захирч чадахгүй байвал эс тусах гэнэ.

6. Дараах тулгуур бичиглэлийг уншаад, үйл үг ямар утга заадаг талаар найздаа ярьж тайлбарлаарай.



7. “Нэгэн сэхээг” өгүүллэгийн үйлийн эзнийг тодорхойлно уу.

- Мятав сандрахдаа юу хийсэн бэ?
- Мятав юуг шидсэн бэ?.....
- Хүний амь аварсан эзэн хэ бэ?.....
- Хэн? юуг? яасан?
-

Хүн, бяруу, морь, ус, эрдэм **зэрэг үг нь** үйлэнд өртөж байгаа бөгөөд заахын тийн ялгалд байна.

8. Дараах эхийн үйл үгээс ургуулан асуулт тавиарай. Холбоо үг болгоорой. Холбоо үгээ тусах, эс тусах үйл үгээр нь тайлбарлан ярилцаарай.

Жишээ нь: Юу хаясан бэ? чөдөр хаях
тусах үйл үг

Аав

Чөдөр хаяжээ, би.
 Чимээгүйхэн гэгч нь аав ширтэнэ.
 Харц нь намайг ороолгоно.

Б.Лхагвасүрэн



Сургаал үгс

Эрхийг сурахаар бэрхийг сур
 Хүний гараар могой барих
 Гурван үгийн утга мэдэхгүй
 Гурвалжин нөхөөсний зүйдэл мэдэхгүй

9. Хүснэгтийг нөхөж яагаад тусах, эс тусах үйл үг болж байгааг тайлбарлаарай.

Үйлэнд өртөж байгаа юм, өртөөгүй юм	Үйл үг	Тусах, эс тусахын аль нь болох
чөдөр	хаях	
намайг	ширтэх	
	ороолгох	
эрхийг, бэрхийг	сурах	тусах үйл үг
утга, зүйдэл	мэдэхгүй	

Үйл үгийн бүтэцтэй танилцъя.

1. Үйл үгийн бүтэх аргыг уншаад, ярилцаарай.

Үйл үг дагаврын аргаар бүтэх


Монгол хэлний үйл үгийг үүсмэл, үүсмэл биш гэж хоёр хуваадаг.
Жишээ нь:

- яв, оч, ир, бод, сана, тат гэвэл үүсмэл биш үйл үг.
- баяр+л= баярла, ус+л= усал гэж үүссэн үүсмэл үйл үг байна.

Үйл үг дагаврын аргаар бүтэх:

- **Шүүр+д**= шүүрд, “юу” гэсэн асуултад хариулагдах “шүүр” жинхэнэ нэрэнд–**д** гэсэн дагавар залгахад “ях” гэсэн асуултад хариулагдах үйл хөдлөлийг заасан “шүүрд” гэсэн үг үүсжээ.

2. Дараах тулгуур бичиглэлийг уншаад, жишээ олж найздаа тайлбарлан яриарай.



1. Дараах өгүүлбэрийн үйл үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

2. Үйл үгс нь тусах үйл үг болохыг батална уу.

Аргыг нь ол+бол арсланг ч нэг үгээр дийл+нэ.

Ажлыг сур+вал уулыг ч нэг хүн нураа+на.

3. Дараах үгсийг харьцуулан уншаад хоёр дахь хэсгийн үгсийг бүтцээр нь задалж бичээрэй.

хуур, дуу, унш, бич, хэвт,

хуурд, дууд, хөрөөд, ногтол, тоол,
хазаарла, давсал, лаазал

Үйл тодотгон ба нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг мэдье.

1. Уншихдаа үйл үгийн доогуур зурж тэмдэглээрэй.

Цасан дээрх мөр

Хаврын наран **мишээсэн** цэнхэр тэнгэрийн доор цастай сүрлэг нуруу **дүнхийнэ**. Энэ бол Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваа **билээ**.

Үүгээр хоёр хөлтний мөр **гарах нь** төдий элбэггүй. Хариулах эзэнгүй мөртлөө араатан гөрөөс ч ховорхон явж, **халих** жигүүртэй атлаа шувуу ч цөөхөн нисэж, **хашигдах боогдох** юмгүйгээрээ салхи л чөлөөтэй **зугаацдаг** ийм л зэлүүд нутаг даа... Гэтэл Үертийн эх рүү **орох** давааны мөөг шиг мөлгөр өвгөр ирмэгийн цасанд **шигдсэн** монгол гутлын мөр байдаг чинь юу билээ... Ойрхон ойрхон гишгэж, бүдэрч шургачсаар **явсныг нь бодоход** их л ядарч **сульдсан** шинжтэй. Мөрний хэмжээг харвал төдий л том хүн биш шиг. Ганц явган хүн өдий цагт өлсгөлөн араатны ам, **өрөвдөх** сэтгэлгүй цасан шуурганаас айхгүй ямар хэргээр **яваа нь** энэ вэ? Хаанахын хэн гэгч юм бол?


2. Дараах үйл үгүүд ямар үгтэй холбогдож байгааг тодруулж, нөхөөрэй.

Жишээ нь: мишээсэн тэнгэр (яасан? - юу?), ядарч сульдсан(яаж? - яасан?) гэх мэт

гарах нь	бүдэрч
шигдсэн	харвал.....
зугаацдаг	гишгэж
яваа	шургачсаар.....

3. Үйл үг нь ямар асуултад хариулагдах үгтэй холбогдож байгааг ярилцана уу.

- Улаанаар тодруулсан нөхцөл үйл үгийг ямар үгтэй холбож байна вэ?
- Ягаанаар тодруулсан нөхцөл үйл үгийг ямар үгтэй холбож байна вэ?
- Ямар утга, үүрэгтэй байна вэ?



4. Тодотгох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг дэвтэртээ тэмдэглэж аваад, тогтоогоорой.

Тодотгон холбох	нөхцөл	Нөхцөлдүүлэн холбох	нөхцөл	Нөхцөлдүүлэн холбох	нөхцөл
Өнгөрсөн цаг	-сан, -сэн, -сон, -сөн	Зэрэгцэн холбох	-ж, -ч	Бэлтгэн холбох	-магц, -мэгц, -могц, -мөгц
Үргэлжилж буй одоо цаг	-аа, -ээ, -оо, -өө	Урьдчилан холбох	-аад, -ээд, -оод, -өөд	Угтан холбох	-тал, -тэл, -тол, -төл
Байнга үйлдэх одоо цаг	-даг, -дэг, -дог, -дөг	Хам холбох	-н	Дагалдах	-хлаар, -хлээр, -хлоор, -хлөөр
Энгийн ирээдүй цаг	-х	Үргэлжлэн холбох	-саар, -сээр, -соор, -сөөр		
Боломжит ирээдүй цаг	-маар, -мээр, -моор, -мөөр	Дутагдан холбох	-вч	Дашрамдах	-нгаа, -нгээ, -нгоо, -нгөө
		Болзон холбох	-вал, -вэл, -вол, -вел	Үгүйсгэх	-лгүй

5. Тодотгон холбох нөхцөлтэй дараах үгсийг ажиглаарай. Жинхэнэ нэрийн ямар нөхцөлөөр хувилсныг тайлбарлаарай.

явсныг нь бодоход, яваа нь энэ, амарсны дараахан, явчихыг мэдсэнгүй

- Араас нь жинхэнэ нэрийн ямар нөхцөл орсныг тэмдэглээрэй.
- Яагаад үйл үг жинхэнэ нэрийн нөхцөлөөр хувилсан юм бол? Ярилцана уу.
- Тодотгон холбох нөхцөлтэй тодруулсан үгс жинхэнэ нэртэй холбогдох атал яагаад үйл үгтэй холбогдсон юм бол? Учрыг тайлбарлаарай.

6. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаад, дүрмийг тайлбарлаарай.

бүрэх, бүрх, хавах, хавх

7. Дараах өгүүлбэрт нөхцөлдүүлэн болон тодотгон холбох нөхцөл нөхөөрэй.

Нутаг усаа санахуй

Хаврын урь уна..., газар дэлхий цасан цагаан хөнжлөө ногоон магнагаар солив.


Нуур цөөрөм, гол мөрөн мөсөн хуягаа тайл..., нүүдлийн шувууд ир..., жигүүрээ амраа..., нуур усандаа жаргалаа. Байгаль ертөнц аажим, аажмаар дулаар... зуны найртай сайхан улиралтай золголоо. Чухам ийм үед би төр... нутгаа зорив. Нутгийн уулс алсад харагд... улам ойрт... алагла... ногоор... үзэгдэнэ. Эр хүн өтөл..., өвгөр... уна... газар, угаа... усаа мөрөөд... нь жам билээ. Багадаа тогло... өс... Билүүтийн бууцандаа оч... мориноосоо буу..., нутгийн агаараар цээж дүүрэн амьсгал... хамаг бие сэтгэл амар... дахин төр... мэт бодогдоно. Ийнхүү нутаг усныхаа тухай бод... бага насныхаа хөгжөөнтэй үеийг дахин дурсав.

Би төрсөн нутагтаа ир... тун уджээ.


Ц.Өнөрбаян, Монгол хэл 6, УБ, 1999

8. Дээрх хоёр хүснэгт дэх нөхцөлийг ашиглан, тав таван өгүүлбэр зохиогоорой.

9. Дараах зургийг ажиглаад, "Цасан дээрх мөр" эхийн хэлбэрийг дуурайн, үйл явдлын орчныг дүрслэн бичээрэй.



Холбоо үг, өгүүлбэрийн бүтцэд орсон үйл үгийг бусад үйл үг болон нэр үгтэй холбох үүрэгтэй нөхцөлүүдийг үйлийн холбох нөхцөл гэнэ.



Цагаар болон биеэр төгсгөх нөхцөлийг зөв хэрэглэе.

1. Дараах хоёр эхийн хэсгийг уншихдаа, өгүүлбэрийн төгсгөлийг тодруулаарай.

Шороон дээрх мөр

... Байр эргэж явсан захирал Жигжид 7 дугаар ангийн сурагч Анандад ирсэн захидлыг нь гардуулж өгөв... Ананд 4 дүгээр анги хамт төгсөөд хөдөө гарчихсан найз нөхөр Хуягийнхаа захидлыг сэтгэл догдлон задлав. Гэтэл хөрслөг бор царай нь цэлмэг тэнгэрт аадрын хар үүл цогцлох адил барайв. Гал цогтой сэргэлэн бор нүд нь хачин жигтэй гөлийгөөд явчихыг нөхөд нь ажигласангүй...

“... Танайх Индэртэд... Дүү чинь (Бор) гэнэт алга болоод арваад хонож байна...

Нутгийнхан чиний шалгалт дундуур үүнийг дуулгамааргүй байх шиг байна. Гэвч...” гэхчлэн бичжээ.

...Сурагчдыг амарсны дараахан... эрэгтэйчүүдийн байрны хашааны хаалга сэмхэн онгойж, цагаан нэхий дээлтэй ганц хүүхэд гарч ирсэн бөгөөд улмаар сэмхэн алхалсаар Тэгшийн ганга руу орлоо...

*Ж.Гал, Монголын өгүүллэг туужийн дээж,
III боть*

Дорлиг: - Та нар гараан дээр дахиад очигтүн. Анхаарч байгаарай.

- Марш

- Зогс. Дахиад гараан дээрээ очоод, миний хэлэхийг сонсож бай.

Бат: - Түргэлээч дээ, чамайг гуйя.

Энэ ажлаа хурдан дуусгая.

Дорлиг: За, чи яасан тэвчээр муутай эр вэ? Дулмаа хүлээж л байг.

Хүлээх гэж ямар байдгийг тэр мэдэж аваг.

Бат: - За, за чиний санаснаар л болтугай. Чамд ямар өрөвдөх сэтгэл байх биш дээ.

Дорлиг: - Чи тайвшир л даа.

Дасгал одоохон дууслаа шүү дээ.

Д.Даржаа

2. Тодруулж зурсан үйл үгийнхээ утгыг тодорхойлохдоо дараах асуултад хариулаарай.

- Аль хэсгийн өгүүлбэр төгсгөсөн үйл үгүүд цагийн утга илэрхийлж байна вэ?
- Аль хэсгийн үйл үгүүд өгүүлэгч этгээдийн хандлага, сэтгэлийн өнгө аясыг илүү илэрхийлж байна вэ?
- Эдгээр нөхцөлийг төгсгөх нөхцөл гэсний учир юу вэ?

3. Доор өгсөн нөхцөлийн утгыг харуулсан хүснэгтийг ашиглан, дээрх хоёр эхэд байгаа өгүүлбэр төгсгөсөн үйл үгийг цагаар, биеэр төгсгөх нөхцөлтэйгээр нь бүлэглэж бичээрэй.

Цаг	Нөхцөл	Жишээ
Өнгөрсөн цаг	-в	Цай өгөв. Цай уув.
	-лаа (-лээ, -лоо, -лөө)	Цай өглөө. Цай уулаа.
	-жээ, (-чээ)	Цай өгчээ. Цай уужээ.
Одоо цаг	-на, (-нэ, -но, -нө)	Цай өгч байна. Цай ууж байна.
Ирээдүй цаг	-на, (-нэ, -но, -нө)	Цай өгнө. Цай ууна.

Бие	Утга	Нөхцөл
I бие	Шийдэн хүсэх	-я, -е, -ё
	Даалган захирах	-сугай, сүгэй
II бие	Тушаан захирах	Тэг нөхцөл
	Зөвлөн захирах	-аарай, -ээрэй, -оорой, -өөрэй
	Шаардан захирах	-аач, -ээч, -ооч, -өөч
	Хүндэтгэн захирах	-гтун, -гтүн
	Сануулан захирах	-уузай, -үүзэй
III бие	Зөвшин хүсэх	-г
	Ерөөн хүсэх	-тугай, -түгэй
	Мөрөөдөн хүсэх	-аасай, -ээсэй, -оосой, -өөсэй

4. Цэгийн оронд тохирох нөхцөлийг нөхөж, зөв бичээрэй.

Саран гий(...) сайхан шөнө боловч хад байцын ёроолд бараан сүүдэр тунар(...). Янгирын хөлөөр чулуу өнхөр(...) нь дуулдаж, үргэж цоч(...) шувуухайнууд дуу шуу болон далавчаа сүржигнүүл(...). Дээшээгээ хар(...)д уулсын оройгоор тусгаарлагд(...) одот цэлмэг тэнгэр ерөнхий дүрсээрээ адил биш боловч олон өнцөгтийг санагдуул(...).

Өрх өсгөж
Сум сунгаж яв...

Хүний тусыг март...
Хүсэл зоригоосоо няц...

Саасан сүү нь сав дүүр...
Санасан хэрэг нь
Сэтгэлчлэн бүт...

Эх орон, элгэн садан минь
Энх амгалан бай...

Аав ээж, ах дүү нартаа
Ач буян, амжилт бүтээлээ өргө...

Нөхрөө харж биеэ зас...
Сүүдрээ харж, бүсээ зас...

5. Дараах онолын ойлголтыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.

Цагаар болон биеэр төгсгөх нөхцөлүүд нь цаг ямагт өгүүлбэрийн адагт ордог учраас тэдгээрийг төгсгөх нөхцөл гэнэ. Эдгээр нөхцөл нь өгүүлэгчийн тухайн зүйлд хандах хандлагыг илэрхийлдэг.

6. Цагаар болон биеэр төгсгөх нөхцөлийг ашиглан тав таван өгүүлбэр зохиогоорой.

7. Бусдад тохиолдсон хөгжилтэй явдал бичээрэй.

- Өгүүлбэрээ цагаар төгсгөх нөхцөлөөр хэлбэржүүлэх
- Харилцан яриа оруулаарай.
- Ярианы төгсгөлөө биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржүүлээрэй.

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

“Дугуй” эхийг уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Дугуй

Батбаатар дугуй унаж сурахыг туйлаас хүсэх болов. Нэг өдөр ахынхаа дугуйг унаж үзэхээр мордоод явах гэтэл дугуйтайгаа ойчжээ. Гараа шалбалсныг тоосон ч үгүй дугуйгаа босгоод дахиад явахдаа хураалттай байсан түлээ мөргөж унав. Хүчтэй мөргөснөөс толгой нь дүйрч байжээ.

Ах нь гүйж ирээд:

- Их өвдөв үү? Миний дүү, дугуй унаж сурах болоогүй байна. Хойтонгоос унаж сурах хэрэгтэй гэв.

Ахыгаа явсны дараа Батбаатар “Заавал дугуй унаж сурна даа” гэж хатуу шийджээ. Орой болоход Батбаатар дугуйн дээрээ тогтохоор барахгүй ойрхон газар явдаг болжээ. Айлын хүүхдүүд түүнд баяр хүргэв. Ээж нь ирээд:

- Миний хүү овоо доо гээд духан дээр нь үнсэв.
- Би дугуйнаасаа олон унасан гэж Батбаатарыг хэлэхэд
- Ямар ч бэрхшээлийг давж чадвал юуг ч сурдаг юм гэж ээж нь захив.

Д. Давааням, Цасны хүү тууж, 1984

1. Асуултад хариулж бичээрэй.

- а. Энэ өгүүллэгийн үйл явдал өрнөх учир шалтгаан нь юу вэ?
- б. Батбаатарт бусад хүмүүс яагаад баяр хүргэх болов?
- в. “Заавал дугуй унаж сурна даа” гэсэн Батбаатарын шийдвэр, “Ямар ч бэрхшээлийг давж чадвал юуг ч сурдаг юм” гэж ээжийн захисан захиас хоёр ямар холбоотой вэ?
- г. Өгүүллэгийн учир шалтгааны холбоо хамаарлыг тайлбарлан бичнэ үү.
- д. Төлөвлөгөөний дагуу “Дугуй” эхээс санаа авч, өөрт тулгарсан бэрхшээлийг даван туулж, зорилгодоо хүрсэн тухай хүүрнэсэн эх зохиож бичнэ үү.
 - Чи юуг яахыг хүсэж байсан тухай
 - Гэтэл ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
 - Чи тэр саад бэрхшээлийг яаж даван туулсан бэ?
 - Ямар үр дүнд хүрсэн бэ?

е. Цэгийн оронд тохирох нөхцөлийг нөхөж бичээд, ямар утга үүрэгтэй болохыг ярилцаарай.

- Нүүдэлчин монголчууд галаа тойрон сууж, эргэ... хорвоогийн элдэв явдлыг хүүрнэн ярь... бай... нь тэдэнд эрүүлж... увдисыг заяаж бай...
- Өвөг дээдэс маань энэ шидийг мэд... бай...аас тэр үү, нялх хүүхэд өвдвөл нүцгэлэн ил гал дээр эргүүл... бай...
- Аманд ор... алтыг хэлээрээ түлхэх
- Зөв мөрийг заан таниул... багшийн ач үнэн
Зөөн хураа...аа хайргүй эдлүүл... эцэг эхийн өршөөл үнэн
Зөөлөн авираар тустай үгийг өгүүл... ах дүүгийн хайр үнэн
Зүдэх цагт тус хүргэ... сайн нөхрийн тэтгэмж үнэн

ё. Дараах өгүүлбэрийн үйл үгийг ажиглаад, цагаар төгсгөх нөхцөлтэй үгийн доогуур нэг, биеэр төгсгөх нөхцөлтэй үгийн доогуур хоёр зураад, нөхцөлүүдийн утгыг ярилцаарай.

- Хүний тусыг мартуузай.
- Борогчны талд болжмор жиргэнэ.
- Хээр талынхаа энэ бяцхан шувууг хэчнээн хайрлаж яваагаа сая л ухаарлаа.
- Үрээ танихгүй өнөр, үрээгээ танихгүй баян болог.
- Ар талыг арлаад, өвөр талыг өвөрлөөд, өөд уруугүй шогшино.
- Эх орондоо гавьяатай, энэ дэлхийд нэртэй, сайн хүн болохын ерөөл өргөө.
- Өвч цасанд дарагдсан өвлийн цагаан болжмороос өөр юу ч жиргэдэггүйг сая л анзаарав.
- Энх явж, мөнх жаргаарай.

ж. Хэл зүйн тайлбарыг жишээтэй нь харгалзуулаарай.

“Эрхийг сурахаар, бэрхийг сур” гэж ямагт сурган, хэрд минь таарсан ажлын хатууг хийлгэж, ачааны хүндийг үүрүүлэн, хийж бүтээхийн амтанд оруулж, эрийн цээнд хүргэсэн хангай шиг түшигтэй аавынхаа холч ухааныг өвлөн авчээ.

1. Эс тусах, үүсмэл биш, тодотгон холбох нөхцөлтэй үйл үг	a. үүрүүлэн
2. Тусах, үүсмэл биш, цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үг	b. өвлөн
3. Тусах, үүсмэл биш, хам холбох нөхцөлтэй үйл үг	c. авчээ
4. Эс тусах, үүсмэл биш, цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үг	d. хүргэсэн
5. Тусах, үүсмэл, хам холбох нөхцөлтэй үйл үг	e. явлаа

з. Дараах хүснэгтийг гүйцээгээрэй.

Нөхцөл	Тодотгон холбох нөхцөл	Нөхцөлдүүлэн холбох нөхцөл	Цагаар төгсгөх	Биеэр төгсгөх
Утга	Цаг заана.
Үүрэг	Нэр үгийн утгыг тодотгоно.
Байр	Нэр үгийн өмнө байрлана.
Онцлог	Нэрийн хувиллаар хувилна.

и. Өгүүлбэрүүдийг зөв дараалалд оруулж санааг оновчтой гаргаарай.

Өвлөөс өөр улирал байдаггүй аж
 Чулуу хөлөрсөн зун
 Өндөр уулын оргилд
 Цастай хэвээрээ өнждөг аж

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭХИЙН СЭДЭВ, ГОЛ САНАА

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Хүүрнэсэн эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлох
- Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих
- Орон цагийн нэр хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

БҮТЦИЙН ХЭСГҮҮДИЙН УЯЛДАА ХОЛБООГ ЗАДЛАН ШИНЖИЛЖ,
СЭДЭВ ГОЛ САНААГ ТОДОРХОЙЛЪЁ

Эхийн утгыг ойлгоё.

1. Уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.

Уучлах гэдэг ухааных



Долоо хоногийн эхний өдөр дунд сургуулийн нэгэн багш сурагчдаасаа “Амьдралын...” гэсэн тодотголтой нэгэн туршилтад орохыг хүссэн байна. Нэр нь их сонирхолтой байсан тул хүүхдүүд дуртай нь аргагүй зөвшөөрчээ.

Багш нь хүүхэд бүрийг 5 килограмм төмс, нэг ширхэг гялгар уут авчрах даалгавар өгсөнд тэд ихэд гайхсан ч маргааш нь бүгд авчирчээ. Багш ангидаа оронгуут асуусан харцаар өөдөөс нь ширтэх шавь

нартаа хандан, “Хүүхдүүд ээ! Та нар өнөөдрийг хүртэл үзэн ядаж байсан, эсвэл дургүй хүмүүсийнхээ нэрийг нэг нэг төмсөн дээр бичээд, тор луугаа хийгээд байгаарай.” гэв. Хэдэн минутын дараа зарим хүүхдийн торонд ганц нэг төмс орсон байхад, заримынх нь бүр дүүрэн болсон харагдана. Сурагчдыг торондоо төмсөө хийж дууссаны дараа багш “Одоо тортой төмсүүдээ долоо хоногийн турш хаа явсан газраа авч яв. Автобусанд суухдаа, хичээлдээ ирэхдээ ч авч яв. Унтахдаа ч орныхоо хажууд тавиарай.” гэлээ.

Товлосон долоо хоног нь дуусаж, багшийг ангидаа орж иртэл хүүхдүүд “Багш аа, ийм хүнд ачааг үргэлж авч явах хэцүү байна. Зарим төмс нь бүр ялзарч эхэллээ. Би залхаж байна. Бас ядарч байна” гэх зэргээр гомдоллож эхлэв.

Эцэс сүүлд нь багш инээмсэглэн байж, “Хүнийг уучлахгүй байх нь тэднийг бус, өөрийгөө шийтгэж байдаг.” гэдгийг л та нарт ухааруулах гэсэн юм. “Бусдын алдааг уучлахгүй бол бид сэтгэлдээ энэ төмс шиг хүнд ачааг тээж явдаг юм. Бусдыг уучилна гэдэг өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл юм шүү дээ.” гэж хэлжээ.

“Сургамжит өгүүллэг” зохиолын түүвэр, 2014

2. Тэмдэглэсэн үгээ хам сэдвийн хүрээнд таамаглан тайлбарлаарай. Үлгэрлэвэл:

Тайлбарлах үг	Таамагласан утга	Шалтгаан
товлосон	...тэр өдөр гэсэн утгатай байх	... ДОЛОО ХОНОГ НЬ ДУУСАЖ гэж байгаа учир
.....
.....
.....

1. Дараах даалгаврыг гүйцэтгэж, эхийн сэдэв, утгыг ойлгоорой.

а. Асуултад хариулаарай.

- Багш шавь нартаа ямар даалгавар өгсөн бэ?
- Сурагчдадаа долоо хоногийн турш тортой төмсийг хаа явсан газартаа авч явуулсан нь ямар учиртай вэ?
- Ялзарсан төмсийг хүний ямар зан чанартай адилтгаж болох вэ?
- Ууч сэтгэлийн тухай шавь нартаа ойлгуулсан багшийн арга хэр оновчтой санагдсан бэ? Яагаад?
- Чи хэр ууч хүн бэ? Өөрт тохиолдсон явдлаар нотолж яриарай.

б. Эхийн үйл явдлыг хурааж бичээрэй.

- Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Эхийн утгыг илэрхийлэхэд чухал гэж үзсэн 4-5 үгийг олж бичээрэй.
- Түүсэн үгээ оруулан гол утгыг алдагдуулахгүйгээр бичээрэй.

в. Эхийг уншихдаа юу бодож, эцэст нь юуг ухаарснаа дараах загварын дагуу бичээрэй.

Өнөөдөр би өгүүллэг уншлаа. Уг өгүүллэгт

..... талаар өгүүлдэг.

Харин би “Багшийн даалгавар өгдөг” хэсгийг уншиж байхдаа

..... гэж бодлоо. Гэтэл миний таамагласантай

..... байлаа. Цааш уншлаа. Багшийн

туршилт хийж байгаа хэсгийг уншаад

гэж байгаа юм болов уу? юм болов уу? гэсэн олон бодол толгойд эргэлдлээ.

Харин төгсгөл хэсгийг уншаад л арга ухааныг нь

.....

Би энэ өгүүллэгээс ухаарч ойлголоо.

г. Бичсэнээ хоёр, хоёроороо солилцон уншаарай.

д. Ангидаа ууч сэтгэлийн тухай ярилцлага өрнүүлээрэй.

Эхийн утга, бүтцийн хамаарлыг тодорхойлъя.

1. Эхийн бүтцийг тайлбарлаарай.

а. Эх хэдэн цогцолбороос бүтсэнийг тодорхойлоорой.

- Хэсгүүдийг зааглаарай.
- Яаж заагласан аргаа бусадтайгаа хэлэлцээрэй.

б. Хэдэн хэрэг явдал болж байгааг шинжлээрэй. Дараах хүснэгтийн дагуу ажиллана уу.

Цогцолборын дугаар	Болж буй хэрэг явдал юуны тухай өгүүлэв?	Эхийн аль хэсэгт хамаарах вэ?
1-р цогцолбор	Хүсэлт тавьж байгаа тухай	Эхлэл
2-р цогцолбор	
3-р цогцолбор	

в. Хэрэг явдал, цогцолбор хоёрын хамаарлыг дээрх хүснэгтэд тулгуурлан тайлбарлана уу.

- Нэг цогц санаа илэрхийлсэн нэг буюу хэд хэдэн өгүүлбэрийг цогцолбор гэж үзэж болох уу?
- Нэг цогц санаа гэдэг нь нэг хэрэг явдал мөн үү? Яагаад?
- Эхийн бүтцийн хэсгүүд юунаас бүтэж байна вэ?
- Цогцолборыг бичигт яаж тэмдэглэх вэ?

г. Эхэд хэдэн үйл явдал өгүүлэгдэж байгааг түлхүүр үг ашиглан тодорхойлоорой. Дараах хүснэгтийг нөхнө үү.

Цогцолборын дугаар	Юуны тухай өгүүлэв?	Эхийн аль хэсэгт хамаарч байна вэ?
...	Хүсэлт
2	Гол хэсэгт
...	
...	Туршилт	
...	Гомдол	
3

д. Эхийн аль хэсэгт олон үйл явдал дүрслэгдэж байгааг ажиглаад, бүтцийн хэсэг тус бүрийн хэмжээг зураглаж харуулаарай.

Үйл явдлын дарааллыг тодорхойлъя.

1. Үйл явдлын дарааллыг тайлбарлаарай.

а. Эхээс дараах үгсийг түүж, доор харуулав. Эндээс хэзээ гэсэн асуултад хариулагдах үг, өгүүлбэрийг тодруулж будаарай.

Долоо хоногийн эхний өдөр, дунд сургууль, туршилтад, даалгавар, маргааш нь, багш ангидаа оронгуут, өнөөдрийг хүртэл, төмсөн дээр, хэдэн минутын дараа, долоо хоногийн турш, автобусанд суухдаа ч, хичээлдээ ирэхдээ ч, унтахдаа ч, товлосон долоо хоног, багш ангидаа орж иртэл, үргэлж, ингэх үед нь

б. Хугацаа заасан үг, өгүүлбэрээ бүлэглээрэй. Жишээ нь:

Үг	Өгүүлбэр
маргааш.....	Багш ангидаа оронгуут...

в. Үйл явдлыг болсон цаг хугацаатай нь зөв харгалзуулаарай.

- | Үйл явдал | Цаг хугацаа |
|---|------------------------------|
| 1. Багш туршилт хийх хүсэлт тавив. | а. Ингэх үед нь |
| 2. Багшийн өгсөн даалгаврыг хүүхдүүд биелүүлэв. | б. Хэдэн минутын дараа |
| 3. Багш туршилтаа эхлэв. | в. Долоо хоногийн эхний өдөр |
| 4. Хүүхдүүд ёсоор хийв. | г. Долоо хоногийн дараа |
| 5. Шавь нар нь гомдоллов. | д. Багш ангидаа оронгуутаа |
| 6. Багш учрыг ойлгуулав. | е. Маргааш нь |

- г. Үйл явдлыг ямар дарааллаар өрнөдөг гэж ойлгосон бэ? Ярилцаарай.
 д. Үйл явдал бүрийг яагаад догол мөрөөр илэрхийлж бичээгүйн учрыг багшаасаа асууж мэдээрэй.

2. Өмнөх даалгавруудаа эргэн хараад, эхийн утга бүтцийг хамаарлаар нь зөв холбож дараалуулаарай.


- | | |
|---|---------------|
| 1. Үйл явдал болох суурь мэдээллийг агуулна. | Төгсгөл хэсэг |
| 2. Үйл явдлын орон, шалтгаан, шинж байдлыг дэлгэрүүлж харуулна. | Эхлэл хэсэг |
| 3. Эхийн гол санааг агуулна. | Гол хэсэг |

Эхийн сэдэв, гол санааг тодорхойлъя.

1. Үйл явдал тус бүрийн учир шалтгааны холбоо хамаарлыг тайлбарлаарай.
 а. Эхээс хэрэг явдлын шалтгааныг олж бичнэ үү.

Шалтгаан (юунаас болж?)	Хэрэг явдал (яав?)
.....	Багш хүсэлт тавьсан нь
.....	Багш даалгавар өгсөн нь
.....	Сурагчид гайхсан нь
.....	Багш туршилт хийсэн нь
.....	Сурагчид гомдоллосон нь
.....	Багш сурагчдыг ухааруулсан нь

2. Дараах тулгуур бичиглэлийг сумаар холбож, үйл явдал, бүтцийн уялдааг ойлгосноо харуулаарай.



3. Гол санааг тодорхойлоорой. Тэгэхдээ 42 -р хуудасны "г" хүснэгт, 43 -р хуудасны хоёрдугаар дасгалын тулгуур бичиглэлийг ашиглана уу.
- Эхэд ямар асуудал дэвшүүлснийг ярилцаарай.
 - Хэдэн үйл явдал гарч байсныг сэргээн санаарай.
 - Тухайн үйл явдал тус бүр эхийн аль хэсэгт хамаарч байгааг тайлбарлаарай.
 - Үйл явдал өрнөх гол шалтгаан алин болохыг тодорхойлно уу.
 - Үйл явдлын төгсгөлийг дахин уншаарай.
 - Эхэд дэвшүүлсэн асуудлыг үйл явдлын төгсгөлтэй холбон гол санааг дүгнээрэй.

Ойлголтоо нэгтгэн дүгнэе.

1. Цогцолборын тухай ойлголтоо бататгаарай.
- а. Дараах ойлголтыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.


Цогцолбор нь хэрэг явдлыг тусгаж, түүний тухай цогц санааг илтгэнэ. Цогцолборыг бичигт догол мөрөөр тэмдэглэнэ. Үйл явдлууд нь өөр хоорондоо учир шалтгаанаар нөхцөлдөж орон ба цагийн дарааллаар өрнөнө. Үйл явдал нь өгүүлбэрээр илэрнэ.

- б. Өмнө нь ажилласан дасгалуудаа эргэн хараад, ярилцана уу.
- Эхийн хэрэг явдал аль аль нь байсан бэ?
 - Цогц санаа гэдэг нь юуг хэлж байгаа тухай жишээгээр батлан ярилцаарай.

2. Дараах дүгнэлтийг гүйцээгээрэй.

Зохиогчоос уул эхийн санааг гаргах гэж сэдсэн санааг ... гэнэ. Өөрөөр хэлбэл, өгүүлэгдэж буй гол юмнаас үүдэлтэй санааг эхийн ... гэнэ. Нэг ерөнхий сэдвийн дор олон дэд сэдэв байж болно. Зохиолын сэдвийг гол үйл явдлаар дүрсэлж, дүгнэлт гаргахыг ... гэнэ.

3. Эхийн хэсгүүдийн хэмжээг ажиглаарай. Эхлэл, гол, төгсгөл хэсгийн хэмжээг заасан дүрс нь аль нь байж болох вэ? Тайлбарлаарай



СЭДЭВ, ГОЛ САНААНД ТОХИРУУЛАН ҮЙЛ ЯВДЛЫГ СОНГОЖ БИЧЬЕ

1. Зургийг анхааралтай ажиглаад, богино өгүүллэг зохиогоорой.

а. Дараах сэдэв санаанд тохируулж бичээрэй.


Сэдэв: Хүүхдийн хүмүүжил

Гол санаа: Хүүхэд бол гэр бүлийн тусгал



Херлуф Бидструп "Садовые радости"
<https://www.m24.ru/articles/vystavki/19092016/116819>

б. Үйл явдал бүрийн утгыг түлхүүр үгээр илэрхийлээрэй. Дараах загварыг гүйцээгээд, бичих ерөнхий төлөвлөгөө болгож ашиглана уу.



в. Дээрх загварыг гүйцээснийхээ дараа үйл явдал, эхийн бүтцийн хэсгийн уялдаа хамаарлыг зураасаар холбон тэмдэглээрэй.

г. Эхэд нэр өгөөрэй.

д. Ноороглохын өмнө дараах үйл ажиллагаануудыг яаж хийхээ сайн бодоод, тэмдэглэл хэсэгт товч бичээрэй.

Бүтцийн хэсэг	Зөвлөмж	Тэмдэглэл
Эхлэл хэсэг	<ul style="list-style-type: none"> Цаг улирал, газар орны байдал, гол хэсэгт өрнөх үйл явдлын суурь мэдээллийг дүрслэх 	
Гол хэсэг	<ul style="list-style-type: none"> Үйл явдлын зангилаа болох сонирхолтой асуудал үүсгэх Үйл явдлын өрнөлийг бичихдээ учир шалтгааны холбоо хамаарлыг тодорхой гаргах Үйл явдлын дарааллыг ямар цаг хугацааны хүрээнд гаргахаа шийдэх 	
Төгсгөл хэсэг	<ul style="list-style-type: none"> Төгсгөл хэсэгт гэр бүлийн амьдрал дундаас хүүхдийг зөв хүн болгон хүмүүжүүлэх нь цэцэг тарих үйлтэй ямар хамааралтай болохыг тунгаасны эцэст гол санаа буюу дүгнэлтээ бичих 	

е. Дээрх даалгаврыг хийснийхээ дараа ноороглоод, дараа нь сийрүүлээрэй.

ё. Дараах шалгуурын дагуу өөрийгөө үнэлнэ үү.

Шалгуур	Үнэлгээ
Эхлэл хэсгээ бичих	😊😊😊
Үйл явдал өрнөх шалтгааныг гаргах	😊😊😊
Үйл явдлыг дарааллаар нь, тодорхой дүрслэн өрнүүлэх	😊😊😊
Дүгнэлт өгүүлбэр буюу гол санааг бичих	😊😊😊
Үйл үгийн төгсгөх нөхцөлүүдийг хэрэглэх	😊😊😊
Зөв бичих дүрмийн алдаагүй байх	😊😊😊

ЭХИЙН ХЭСГҮҮДИЙГ ХОЛБОЖ БИЧЬЕ

Эхийг дэлгэрүүлж бичье.

1. Дараах эхийн хэсгийг уншаад, эхлэл болон төгсгөл зохиож бичээрэй.

.....

 Ах эгч нар маань намайг ямар наймаа хийснийг сонсонгуутаа, уг-ыг би дөрөв дахин их үнээр авсныг хэлж, илүү гарзадсан мөнгөөрөө хэчнээн гоё юм авч болох байсныг тайлбарлалаа. Тэд миний тэнэгийг шоолж инээлдэхэд би гутарсандаа үйлж, тэр-тай болоод баярласныг минь оргүй болгочхож билээ.

2. Дараах эхэд үйл явдлын зангилаа болох хэсгийг нөхөж бичээрэй.

Гэмээ сонсохуй

Дүрсхийдэг зантай нэгэн эр байжээ. Нэг удаа байшингийн дэргэд хоёр хүн ярилцаж байв.

Үүнийг сонссон нөгөөх эр дүрсхийн уурлаж, гэрээсээ харайн гарч ирээд, ярилцаж байсан хоёрыг дайран доромжилж, цус нөжийг нь гартал зоджээ.

Ухаантай хүн гэм бурууг нь хэлэхэд түүнийгээ засахыг эрмэлзэнэ. Мунхаг хүн гэмээ сонсож, засаж авахын оронд улам том алдаа гаргадаг.

3. Болсон хөгжилтэй явдлыг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

а. Дараах эхийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийн уялдаа холбоог тодорхойлоорой.

б. Үйл явдлыг үргэлжлүүлэн зохионо уу .

Тарагны үнэ

(Болсон хөгжилтэй явдал)

Долоон настай хүүгээ ээж нь гэрийн ойролцоох цагаан идээний дэлгүүрээс тараг авчруулахаар явуулжээ. Хүү мөнгөө хадгалах газаргүй болохоор гээхгүйн тулд таглаатай савандаа хийж, санаа амрав.

Худалдагч “ Чи тараг авах нь уу? Хэдэн литрийг авах вэ? гэхэд хүү “Гурван литрийг авна” гэв. Худалдагч саванд нь таргаа хийж өгөөд мөнгөө нэхвэл, хүү мөнгөө савандаа хийгээд мартсанаа гэнэт санаж, “Мөнгө савны ёроолд байгаа...” хэмээн сандрав...

ОРОН ЦАГИЙН НЭРИЙН ХЭЛ ЗҮЙН ШИНЖ,
НАЙРУУЛГЫН ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛЪЁ

Орон цагийн нэрийг таньж мэдье.

1. Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” туужийн хэсгийг уншаад **хаана?**, **хаагуур?**, **хаашаа?** гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бичээрэй. Дараа нь эдгээрээс жинхэнэ нэрийг ялгаж бич. Үлдсэн үгсийн утгыг ярилцана уу.

... Адаг зүүн өмнө аргийн чинээ хар овоохойн хаяа ба тооноор зэрэг зэрэг хар утаа бургилж, гадна нь хэдэн муу тэрэг, дэргэд нь дэлүүн чинээ аргалыг дээлийн хөдсөөр бүтээсэн байжээ. Баян айлын барлаг багир хар гэрүүдийн нэг Долингорын гэр ажээ.

... Долингорын гэр доторх байдал: Хойморт бяцхан хар авдартай, түүн дээр гүнгэрвээтай бурхан Үүдэн тэнгэр тахижээ. Өмнө нь цайны дээж тавих цөгц ба хүж хатгах ховд байна. Зүүн талд нэг авдрын дээр нэг аяга, цом, пял таваг байна. Зүүн хойно Долингор Мядаг хоёрын хэвтэх ор байна. Бусад зайд хуучин муусайн ширмэл ширдэг, уранхай тасархай хөм зэргийг дэвсжээ.

(Ц.Дамдинсүрэн)

Зарим үгийн тайлбар:

гүнгэрваа - Бурхан агуулдаг сав

ховд - арц хүж уугиулдаг онгоц хэлбэрийн сав

хөм - дэвсгэр болгон ашиглах үхэр малын шир

2. Дараах үгсийн утгыг тольчлон тайлбарлаарай.

овоохой, хөдөс, барлаг, багир, цөгц, пял таваг

3. Дараах хоёр эхээс **хэзээ?**, **хэдийд?** гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бичээд, утгыг ярилцана уу.

Төгсөөгүй дуулал	Төрийн дуулал
<p>Энэ дууг би уржигдар эхэлсэн Энэ дууг өчигдөр бас аяллаа. Энэ дууг би өнөөдөр мөн дуулсаар Эцсийг ер үзээгүй байна. Энэ дууг маргааш бас аялна Энэ дууг нөгөөдөр мөн дуулна Энэ дууг насан үүрд аялах болно...</p> <p><i>Л.Түдэв</i></p>	<p>Дархан манай тусгаар улс Даяар Монголын ариун голомт Далай их дээдсийн гэгээн үйлс Дандаа энхжиж, үүрд мөнхөжнө ...</p> <p><i>Ц.Дамдинсүрэн</i></p>

4. Дараах орон цагийн нэрийн тодорхойлолт ба бүдүүвчийг уншаад ярилц.

Юмс үзэгдлийн орших орон, зүг чиг, цаг хугацааг нэрлэн заасан үгсийг орон цагийн нэр гэнэ. Орон цагийн нэрийг орны нэр, цагийн нэр гэж хоёр ангилна.



5. Онъсогыг уншаад таагаарай. Орныг нэрлэсэн үгийн доогуур нэг, цагийг нэрлэсэн үгийн доогуур хоёр зурж тэмдэглэнэ үү.


Дээрээс ирсэн Дэжид ноён
 Урдаас ирсэн унхар ноён
 Дэргэд ирээд дэвхэрнэ
 Дээшээ үсрээд бүжиглэнэ (.....)
 Өмнөх шилийн өлөн сайхан
 Хойдох голын хулс сайхан (.....)
 Урдаа сэрээтэй
 Дундаа хөхүүртэй
 Ардаа ташууртай (.....)
 Энд ч мөнгөн таваг
 Тэнд ч модон таваг (.....)
 Дээрээс нь харахад
 Дэргэр ногоон
 Хажуунаас нь харахад
 Хавтгай ногоон (.....)

Орон цагийн нэрийг хэрэглэе.

1. Дараах өгүүлбэрт тохирох үгийг сонгож бичээрэй.

урд - урьд:	Эрт цагт эмгэн өвгөн хоёр амьдарч байв. Зүүн зүгээс наран мандлаа.
өнө - өн:	Бороо хур тэгширч,.....-тэй сайхан зун боллоо. мөнх мандан бадраг.
хойд -хойт: зүгийн чимэг болсон ой хөвчийн нуруунууд

2. Дараах зургийг ажиглаад, тухайн байрлалд тохирсон орны нэрийг бичээрэй. Нэг зурагт хэдэн ч үгийг бичиж болно.



ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

1. Дараах эхийг уншаад, утгыг мэдэхгүй үгийг тэмдэглэж, толь бичиг ашиглан тайлбарлаарай.

Халуун гурил

Намайг бага байхад ах минь гурил зуурч, эгч элдэнэ. Ахын зуурсан гурил цав цагаан голын захын чулуу шиг мөлгөрхөн хавтгай, бариад үзэхэд бүлээхэн байдаг сан.

Ах минь дайнд яваад эргэж ирээгүй. Тэгээд би гурил зуурч сурсан юм. Миний зуурсан гурил бас л цав цагаан голын чулуу шиг мөлгөрхөн боловч ер халуун болдоггүй байлаа. Эгч маань ахын зуурсан гурилыг шууд элддэг атлаа миний зуурсан гурилыг нухаж байж элдэх нь гагцхүү халуун хүйтний зөрүүнд л байна даа гэж би боддог байжээ.


Тэгээд нэг өдөр гурилаа халуун болтол нь нухахаар шийдлээ. Эртээ гэгч гурилаа зуураад, эгчийн үнээгээ сааж байх хооронд нь удаан гэгч нухаж билээ. Нухсаар байтал би өөрөө их л халууцан, гурил ч бүлээн болох шиг санагдав. Эгч минь гурилыг авч эргүүлэн тойруулан дарж үзээд над руу харж инээмсэглэн нухалгүй элдэж орхилоо. Би ч халуун гурил зуурсандаа ихэд баясан ахын дайтай болсон шиг санаж явжээ.

Энэ гурилыг өчнөөн ядарч бүлээн болгов. Гэтэл ах минь хормын дотор халуун болгодог мөн ч бүлтэй хүн байж дээ гэж би бодно. Энэ тухайд эгчдээ хэлбэл, тэрбээр сүүгээ самрах мэт уртаар санаа алдсанаа ахтайгаа улам адил болж өсөж байгаа, дүү намайгаа ширтэн инээмсэглэхэд сэтгэл нь өрөмтөн байгаа сүү шиг хөөсөрч байлаа.

Ж.Лхагва, Саарал даага 1970 он

2. Эхийн утгыг задлан шинжилж ойлгоорой.

- Түлхүүр үгийн доогуур зураарай.
- Эх хэдэн догол мөрөөс бүтсэнийг тоолж, дугаарлана уу.
- Догол мөр тус бүрийн санааг тайлбарлаарай.
- Эхийн гол санааг тодорхойлно уу.
- Яагаад “Халуун гурил” гэж нэрлэсэн гэж бодож байна вэ?
- Түлхүүр үг, өгүүлбэрээ ашиглан тулгуур бичиглэлийг гүйцээгээрэй.



- Тулгуур бичиглэлээ багаараа ярилцаарай.

2. Тулгуур бичиглэлээ ашиглан, эхийн сэдэв, гол санааг тодорхойлно уу.
- Эхэд хэдэн цогцолбор байгааг олоод, зааглаж зураарай.
 - Цогцолбор бүрд юуны тухай өгүүлснийг олно уу.
 - Сэдвийг тодорхойлж гол санааг дүгнэнэ үү.
 - Үйл явдлын дараалал орон цагийн алинаар дараалсныг дүгнэж бичээрэй.
3. Үйл явдлын дараалал, утга бүтцийн холбоо хамаарлыг тулгуур бичиглэл хийж харуулаарай.
4. Дараах эхээс орны нэрийг олоод доогуур нь нэг, цагийн нэрийн доогуур нь хоёр зураарай.

Дээрээ дэн шар
Дундаа дун цагаан
Доороо азай буурал

Өдөр гурвалжин
Шөнө дөрвөлжин

Эргүү бяруу
Үүгээр явав уу
Түүгээр явав уу.

Арван тавны сар
Алсуур хүрээлэв үү?
Ойроор хүрээлэв үү?

Өглөөний хонь хойшоо бэлчинэ
Үдшийн хонь урагшаа бэлчинэ.

Маргаашийн өөхнөөс
Өнөөдрийн уушги дээр

Урдаа сэрээтэй
Дундаа хөхүүртэй
Ардаа ташууртай

Наашаа харвал наад голын жараахай
тоологдмоор
Цаашаа харвал цаад голын загас
тоологдмоор

5. Дараах үгсийг ангилж бичээрэй.

Дээр, ноднин, өнөөдөр, үргэлж, дотор, өчигдөр, хойгуур, тогтмол, одоо, цаана, уржигдар, дэргэд, байнга, баруун, дэргэдүүр, гадна, саяхан, одоо, дандаа, өнөөдөр, хооронд, ард, дээгүүр, урагш, дээш, өмнө, дараа, мөдхөн, уржнан, удахгүй, хойтон, яваандаа, аажимдаа, завсар, наана

Орон байр заасан:

Зүг чиг заасан үг

Өнгөрсөн цаг заасан үг

Одоо цаг заасан үг

Ирээдүй цаг заасан үг

Байнга давтагдах цаг заасан үг

Өөрт тохиолдсон явдлаа хүүрнэн бичээрэй.

1. Өөрт тохиолдсон сонин содон, мартагдашгүй үйл явдлуудаа жагсаан бичээрэй. Дараах сэдвээс сонгон авч болно.

Хэзээ болсон бэ?	Хаана болсон бэ?	Ямар үйл явдал вэ?
<input type="radio"/> шинэ жилээр	<input type="radio"/> сургуулийн гадаа	<input type="radio"/> сургамжтай
<input type="radio"/> өчигдөр	<input type="radio"/> гэрт	<input type="radio"/> хөгтэй
<input type="radio"/> бага байхад	<input type="radio"/> хөдөө	<input type="radio"/> гунигтай
<input type="radio"/> энэ зун	<input type="radio"/> ангид	<input type="radio"/> баяртай
<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/> бахархалтай
<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/> хөгжилтэй
<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>

- Аль нэгийг нь сонгож, тэр тухай сэргээн бодож, юу юу болсныг тулгуур үгээр товч тэмдэглээрэй.
- Сонгосон сэдвийн хүрээнд бичихдээ юуны өмнө дараах асуултад хариулт олохыг хичээгээрэй. Үүнд:
 - Өөрийн эргэн тойронд болсон ямар нэгэн үйл явдлыг эргэн санасан уу.
 - Үйл явдал хаана болсон бэ?
 - Үйл явдал хэзээ болсон бэ?
 - Юунаас болж үйл явдал өрнөсөн бэ?
 - Цаашид яаж яаж өрнөсөн бэ?
 - Үйл явдлын үр дүнд нь юу болсон бэ?
 - Тухайн үед чиний сэтгэл санаа ямар байсан бэ?
 -

2. Дараах төлөвлөгөөний дагуу бичээрэй.

Эхлэл хэсэгт

Хэзээ: _____
 Хаана: _____
 Цаг агаар: _____
 Газрын төрх байдал: _____

Хэнд тохиолдсон

Сэтгэл хөдлөл

Гол хэсэгт

Үйл явдал өрнөх шалтгаан: _____
 Үйл явдал цаашид орон, цаг эсвэл учир шалтгааны дарааллаар өрнөсөн нь: _____

Төгсгөл хэсэгт

Үйл явдлын үр дүн: _____
 Өөрийн чинь бодол, дүгнэлт

Болсон явдлыг бичихэд тухайн цаг үе, орчны тухай, мөн өөрийн үзэл бодол, үнэлэмжээ дэлгэрэнгүй ба товч хэлбэрээр бичиж болно.

3. Бичсэнээ дараах шалгуурын дагуу үнэлж, сийрүүлээрэй.


Шалгуур	сайн	дунд	тааруу
Үйл явдлын орчинг тодорхой дүрсэлсэн үү?			
Бүтэц болон дарааллаа зөв гаргасан уу?			
Эхийн догол мөр хоорондын уялдаа холбоог гаргаж чадсан уу?			
Сэтгэл хөдлөлөө илэрхийлсэн үү?			
Дүгнэлт буюу гол санаа нь оновчтой болсон уу?			
Найруулгын болон зөв бичих дүрмийн алдааг сайтар хянасан уу?			

Бусдад тохиолдсон явдлыг хүүрнэн бичье.

1. Дараах өгөгдлийг уншаад, хэрхэн дэлгэрүүлж болох талаар саналаа солилцоорой.

... Нэг удаа манай хичээл үдээс хойш орох болсон юм. Тэр өглөө мужаан ах, бид хоёр л үлдээд байсан юм. Энэ завшааныг ашиглаж би хичээлээсээ бараг цаг гаруйн өмнө гэрээсээ гарлаа.

2. Дараах бүтэц, дарааллын дагуу төлөвлөгөө гаргаж бичээрэй.



Бичихийн өмнө:

- Дээрх өгөгдлийг дахин уншаад, ямар үйл явдал тохиолдсоныг төсөөлөн бодоорой.
- Өөрсдөө төлөвлөгөө гаргаарай.

Бичихдээ:

- Хэзээ, хаана, юу болсныг бодоорой.
- Бичих бүтэц, дарааллаа гаргаж ноороглоорой.

Бичсэний дараа:

- Бичсэн эхээ бие биедээ уншуулж, найруулгын ба зөв бичих дүрмийн алдаа байгаа эсэхийг хянаарай.
- Эхээ дахин сийрүүлж бичээрэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮЙЛ ЯВДЛЫН ОРЧИН

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Уншсан эхээс орон ба цагийн дүрслэлийг ялгаж, үйл явдлын орчныг тодорхойлох
- Тодотгон холбох нөхцөлтэй үйл үг, орон цагийн нэр ашиглан орчныг дүрслэн бичих
- Өгүүлбэрийг хурааж, дэлгэрүүлэн, цөм ба дэлгэрэнгүй бүтэц үүсгэж найруулах

ҮЙЛ ЯВДЛЫН ОРЧНЫГ ТОДОРХОЙЛЪЁ

1. Унших явцдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.

Хадат булаг



Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ. (1)

Нэгэн удаа эрлийн хүүхэд ирж, амны цангаагаа гаргаж сууснаа дүрсгүй зан нь гэнэт хөдлөн, худгийн ёроол руу жижигхэн чулуу унагавал “шол” гэснээ сураггүй болжээ. “Том чулуу шидвэл ямар сүртэй дуугарах бол” гэж бодон хашлаганых нь бул чулууг арайхийн өнхрүүлж худагт унагавал “пол” гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй. Тэр хүү ямар хэрэг тарьснаа ч

ухаарсангүй, эрлийн замаа хөөн оджээ. (2)

Болчимгүй зантай хүүгийн бодлогогүй унагасан чулуу худгийн ёроолд унахдаа газрын гүнээс шүүрч байсан булгийн ундаргыг таг даржээ. Удсан ч үгүй худгийн ус ширгэж, хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл гиншин хатаж, мөчир нь нүцгэрэн тэнгэрээс хур гуйн сарвайв. Хайлаас дамжин жиргэж байсан богширго нисэн одож, хаа нэгтээ уянгалан байсан дуу эгшиг тасарч, эрэлчин явуулын хүмүүс ч бууж тухлахаа больж, эл хуль болон хоцорчээ. (3)

Хэнэггүй хүний хар гайгаар амьдрал хайрласан булаг хатаж, хадат биш “хадан” булаг болсон нь энэ ажээ. (4)

*Н. Өлзийбат
Сэтгэлийн эгшиг, 1991*



2. Тэмдэглэсэн үгийн өмнөх ба хойдох үгийг ажиглаад ямар утгатай болохыг тайлбарлаарай. Жишээ нь:

Хуурай **сайрын** адагт-ус урсахаа больсон газрын төгсгөлийн хэсгийг хэлжээ.

Тайлбарлах үгс: эрлийн хүүхэд, лайдах, бөглүү дуу, болчимгүй, богширго, эл хуль, хар гай

3. Эхийн агуулгыг гурван мөрд багтаан бичнэ үү.

Эхийн утгыг задлан шинжилье.


1. Өгүүллэгийн түлхүүр үгийн доогуур зураарай.
2. Өгүүллэгт хэдэн догол мөр байгааг зааглан дугаарлаарай.
3. Догол мөр бүрийн санаанд тохирсон нэр өгөөрэй.

Нарангийн өгсөн нэрийг гүйцээгээрэй.

1. Газрын нүд
2.
3.
4.

Тухайн эхэд олон давтагдсан жинхэнэ нэрийг **түлхүүр үг** гэнэ.

4. Догол мөр бүрийн санаанд өгсөн нэрээ ажиглан, өгүүллэгийн гол санааг тайлбарлан ярина уу.
5. Хадат булаг юунаас болж хадан булаг болсныг олж тайлбарлана уу.
6. Өгүүллэгийн сэдвийг тодорхойлон найзтайгаа ярилцаарай.
 - а) Гол ус ширгэж хуурай сайр олон болов.
 - б) Бодлогогүй зүйл хийдэг дүрсгүй хүүхдийн үйлдлээс байгаль сүйрч байна.
 - в) Усгүй эл хуль болсон нутаг.
 - г) Хуурай сайрын адагт байдаг гурван хайлаас.
7. Түлхүүр үгийг ашиглаад агуулгыг бүрэн илэрхийлэх тулгуур бичиглэл хийе. Цэгийн оронд тохирох үг нөхөж дэлгэрүүлээрэй.




Эхийн утгыг дүгнэе.

1. Тулгуур бичиглэлээ багийн найз нартаа ярьж, санал бодлоо солилцоорой.
2. Асуултад хариулан ярилцъя.
 - а) Яагаад том чулуу унагахад “пол” гэсэн бөглүү дуунаас өөр дорвитой юм болсонгүй вэ? Та нар ямар дуу гарна гэж төсөөлж байна вэ?
 - б) Хөдөө алс хязгаар нутагт малчид худаг ухах, хүн мал тэндээс ус уудаг. Худгийн ус ширгэснээс байгальд ямар хөнөөл учирсан бэ?
 - в) Хүү яагаад ийм бодлогогүй, болчимгүй үйлдэл хийснийг дүгнэн ярилцана уу.
3. Энэ хичээлээр ямар үйл ажиллагаа гүйцэтгэж, юу мэдэрсэн сэтгэгдлээ бичнэ үү.

Өгүүллэгийн бүтцийг задлан шинжилье.

1. Өгүүллэгийн эхлэл хэсэг хэдээс хэддүгээр мөрд багтаж, юу юу дүрсэлснийг цэгийн оронд нөхөж бичээрэй.
 - Өгүүллэгийн үйл явдал болж байгаа газар
 - Өгүүллэгт гарч буй дүр
 - Үйл явдал өрнөх зангилаа
2. Өгүүллэгийн гол хэсэг хэдээс хэддүгээр мөрд багтаж, ямар үйл явдлууд өрнөж байна вэ?
 - Үйл явдал 1. Булгийн ундарга дарагдсан.
 - Үйл явдал 2.
 - Үйл явдал 3.
3. Өгүүллэгийн төгсгөл хэсэг хэдээс хэддүгээр мөрд багтаж, ямар үр дүн гарсан бэ?
4. Хүүрнэн бичсэн өгүүллэгийн бүтцийг тулгуур бичиглэлээр илэрхийлж тайлбарлан ярилцаарай.

Хүүрнэмж эхийн бүтэц



Үйл явдлын орчныг дүрсэлсэн аргыг мэдье.

1. Үйл явдал болсон орон, цагийн дүрслэлийг ялгаарай.

- Үйл явдал хаана өрнөж байна вэ?
- Цаг улирлын байдал ямар байсан бэ?
- Газрын төрх байдал ямар байсан бэ?

2. Дараах хоёр баганын бичлэгийг харьцуулна уу.

а) Энгийн бичсэн, дүрсэлж бичсэн хоёр хэсэг уншигчид ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ? Жишээ нь:

Энгийн бичсэн	Дүрсэлж бичсэн	Тодруулсан үгс ямар үүрэгтэйг бичнэ үү
Сайрын адагт гурван хайлаас ургаж, түүний хөлд худаг байдаг байжээ.	Хуурай сайрын адагт гурван хайлаас ногоорон хүглийж, түүний хөлд чулуугаар хашиж лайдсан бяцхан худаг газрын нүд болон тормойж байдаг байжээ.	
Хүүгийн унагасан чулуу худгийн ёроолд унахдаа булгийн ундаргыг даржээ	Болчимгүй зантай хүүгийн бодлогогүй унагасан чулуу худгийн ёроолд унахдаа газрын гүнээс шүүрч байсан булгийн ундаргыг таг даржээ.	
Удсан ч үгүй худгийн ус ширгэж хавийн ургамал гандаж гурван хайлаас хатаж мөчир нь нүцгэрэн сарвайв.	Удсан ч үгүй худгийн ус ширгэж хавийн ургамал гуниглан гандаж, саглагар гурван хайлаас хүртэл гиншин хатаж, мөчир нь нүцгэрэн, тэнгэрээс хур гуйн сарвайв.	

3. Тодруулсан үгсийг бүлэглэж бичээрэй.

- Орон цагийн нэр
- Тэмдэг нэр.....
- Үйл үг.....


4. Эдгээр үгс эхэд ямар үүрэгтэй байгааг ярилцаарай.

- Орон цагийн нэрийг хэрэглэснээр үйл явдлын ямар шинж илүү тодорхой болж байна вэ?
- Үйл үг ямар нөхцөл авахаараа хүн, юм, үзэгдлийн шинжийг илэрхийлж байна вэ?
- Тэмдэг нэрийг хэрэглэснээр уг үйл явдал яаж нүдэнд харагдтал дүрслэхэд нөлөөлж байна уу?

5. Үйл явдлыг уншигчийн чихэнд сонсогдохоор яаж дүрсэлснийг харьцуулан дүгнэлт гаргана уу.

Энгийн бичсэн	Чихэнд сонсогдох байдал	Дүгнэлт
... Богширго нисэн одож, дуу эгшиг тасарч....	Хайлаас дамжин жиргэж байсан богширго нисэн одож хаа нэгтээ уянгалан байсан дуу эгшиг тасарч.....	
... жижигхэн чулуу унагавал сураггүй болжээ. Бул чулууг худагт унагавал дорвитой ч юм болсонгүй.	... жижигхэн чулуу унагавал “шол” гэснээ сураггүй болжээ. ... бул чулууг арайхийн өнхрүүлж худагт унагавал “пол” гэсэн бөглүү дуу гарснаас өөр дорвитой ч юм болсонгүй.	

4. "Хадат булаг" өгүүллэг ямар мэдрэмж төрүүлж байна вэ? Хүснэгтийг нөхөөд, тайлбарлан ярина уу.



Өгүүллэгийн үйл явдлын орчныг дүрслэн бичихдээ:

1. Түлхүүр үгсийн гол шинж чанарыг тодотгон дэлгэрүүлнэ.

Жишээ нь:

- Гурван хайлаас **яаж** харагдаж байна вэ?
- Гурван хайлаас **ногоорон хүглийж** харагдана.
- **Ямар** худаг **яаж** харагдаж байдаг вэ?
- **Бяцхан** худаг **газрын нүд болон тормойж** байдаг.

2. Уншигчийн чихэнд сонсогдохоор бичнэ.

Жишээ нь:

- Жижигхэн чулуу унагахад ямар дуу сонсогдсон бэ?
- Жижигхэн чулуу унагавал “шол” гэснээс өөр сураггүй болжээ.

3. Сэтгэлд ямар нэг мэдрэмж төрөхөөр бичнэ.


Жишээ нь:

... ургамал **гуниглан гандаж**, саглагар гурван хайлаас хүртэл **гиншин хатаж**, мөчир нь **нүцгэрэн** тэнгэрээс хур гуйн **сарвайв** гэснээс харамсах, сэтгэл хоосрох мэдрэмж төрж байна

4. Зохиолч Н.Өлзийбатын “Хадат булаг” өгүүллэг яагаад уншигчийн сэтгэлд тааламжтай санагдаж байна вэ? Сэтгэгдлээ хуваалцан гурваас дөрвөн зүйлээр батлан тайлбарлаарай.

Өгүүллэгийн үйл явдлын орчныг дүрслэн бичье.

Зурагт дүрслэгдсэн үйл явдал, дүрүүдийн харилцаа, үйл явдал болж байгаа орчныг ажиглаад ярилцаарай.



Евгений Иванович Чарушин 1982 он

Гол хэсэг. Үйл явдлын өрнөл 1

Ямар үйл явдал өрнөж байна вэ?

- Туулай ямар их сэтгэл хангалуун байгааг яаж дүрслэн бичмээр байна вэ?
- Цаад талын нугас ямар дуу чимээ гаргаж байгааг төсөөлөн бодоорой. Усанд хөвж яваа нугас, долгион үүсгэсэн усны чимээ яаж сонсогдож байна вэ?

Эхлэл хэсэг.

Үйл явдал болж буй орчныг нэг бүрчлэн ажигла.


Мод, зүлэг ногоо, ус яаж харагдаж байна вэ?

Дүрслэн бодоорой.

Энэ үед чихэнд юу сонсогдож, сэтгэлд юу таатай санагдаж байгаа бол?

Үйл явдалд хэн хэн оролцох вэ? Тэдний гадаад талыг үгээр зураглаарай.

Тэд юуны тухай ярилцаж байгааг төсөөлөн бодоорой. Юу хийхээр шийдсэн бол?



Үйл явдлын өрнөл 2

- Хоёр нугасны анхаарал яагаад сарнисан бэ?
- Мэлхий, хоёр нугас, туулай, голын ус ямар байдалтай болж, ямар дуу чимээ сонсогдож байгааг дүрслэн бодоорой.



Төгсгөл хэсэг

- Асуудал яаж шийдэгдсэн тухай бичигчийн дүгнэлт

Дээрх зургийн үйл явдлын дарааллаар төлөвлөж зохион бичье.

1. Эхийг ямар бүтэцтэй зохиож бичихээ төлөвлөх
2. Эхэд хэрэглэх түлхүүр үгсээ сонгох
 - а. Эхлэл хэсэг
 - Үйл явдал хэзээ хаана болж буй орчныг дүрслэн бичих
 - Үйл явдалд хэн хэн оролцохыг дүрслэх
 - Туулай, хоёр нугаст ямар санал тавьсан тухай
 - б. Гол хэсэг
 - 2-р зургийн үйл явдал - Сэтгэл хангалуун туулай
 - 3-р зургийн үйл явдал - Нугасны дуртай мэлхий
 - в. Төгсгөл хэсэг.
 - Үр дүн нь юу болсон бэ? Туулайн хүсэл талаар болсон нь
 - Миний үзэл бодол, дүгнэлт
 - г. Бичихдээ үйл явдлын орчныг яаж дүрслэх вэ?
 - Нүдэнд харагдтал дүрслэн бичнэ. Жишээ нь: Нуурын ус цэлс цэлс долгион, хүрээ татан цэнхэртэнэ.
 - Чихэнд сонсогдтол бичнэ. Жишээ нь: Туулай нуурын усанд цүл цал хийн уналаа.
 - Сэтгэлд мэдрэгдтэл бичнэ. Жишээ нь: *Туулай, хоёр нугасны нуруун дээр хүсэл нь биелсэн шиг итгэлтэй нь аргагүй зогсож явна.*
 - Орон цагийн нэр тодотгон холбох нөхцөлтэй үйл үгийг хэрэглэнэ. Жишээ нь: *Баярласан* туулай хоёр нугасны нуруун дээр санаа амар явж байв.
3. Зохиосон эхээ дахин уншиж найруулгын болон зөв бичих дүрмийн алдааг хянаарай.
4. Зохиосон эхээ дараах шалгуураар үнэлээрэй.

Эх	Үнэлгээний асуулт	Үнэлгээ
Эхлэл хэсэг	Эхлэл хэсэгт асуудал дэвшүүлж чадсан эсэх	😊 😐 😞
Гол хэсэг	Үйл явдлыг өрнүүлэн бичиж чадсан эсэх	😊 😐 😞
	Дараа нь ямар үйл болсон бэ?	😊 😐 😞
Төгсгөл хэсэг	Үр дүнг тодорхой бичиж чадсан эсэх	😊 😐 😞
Орчноо бүрдүүлж бичих	Нүдэнд харагдтал дүрсэлсэн эсэх	😊 😐 😞
	Чихэнд сонсогдтол дүрсэлсэн эсэх	😊 😐 😞
	Сэтгэлд мэдрэгдтэл дүрсэлсэн эсэх	😊 😐 😞

Өгүүллэгийн эхлэлээс төсөөлөн бодож зохион бичицгээ.

- а. "Хадат булаг" өгүүллэгийн бүтэц, агуулгыг загвар болгон дуурайн бичээрэй.
- б. Доор өгсөн эхлэл хэсгээс нэгийг сонгоод, ургуулан бодож өөрийн төсөөллөөр зохион бичээрэй.
- в. Үйл явдлын орчныг дүрслэхдээ нүдэнд харагдан, чихэнд сонсогдож, сэтгэлд мэдрэгдэхээр бичээрэй.

Өгүүллэгийн эхлэл хэсэг

1. Жаал хүү Болдыг ээж нь гэртээ орхиод талх авахаар явжээ. Болд нээлттэй цонх руу очив. Цонхны тавцан дээрх вааран дээр томоо гэгчийн эрвээхэй сууж байв. Болд эрвээхэйг барихаар болов.


Дээрх хэсгийг сонголоо гэж бодвол:

а. Эхлэл хэсгийг анхааралтай уншаад ямар үгээс ургуулж зохион бичих вэ? гэдгийг бодож олоорой. Болд эрвээхэйг барихаар ухасхийсэн чинь нээлттэй цонхоор гараад нисчхэв гэвэл үйл явдал өрнөхгүй болно. Харин эрвээхэйг барихаар ямар нэг юм шидвэл ваар хагарах, цэцэг гэмтэх зэрэг үйл явдал өрнөж болох юм гэх мэтээр ургуулан бодоод зохиогоорой.



- б. Энэ цэцгийг эгч нь хайрлаж ургуулсан бол яах вэ?
- в. Цаашаа ямар үйл явдлыг өрнүүлэн бичих вэ?
- г. Үйл явдал ямар орчинд болох вэ? гэдгийг төсөөлнө үү.
- д. Үйл явдал болж байхад ямар дуу чимээ гарах вэ?
- е. Сэтгэлд тааламжтай, тааламжгүй ямар үйл явдал болохыг төсөөлөн бодоод төлөвлөгөө зохион бичээрэй.

2. Хөл дээрээ тэнцэж ядаж байгаа янзагандаа согоо хөхөө хөхүүлэв. Согоо янзагаа үнэрлэж, салхины аясаар эвгүй үнэр ирэхийг мэдэрч, чоно ойрхон ирж явна гэж бодов. Чоно согоог барихад бэлэн болжээ.



ӨГҮҮЛБЭРИЙГ ХУРААЖ, ДЭЛГЭРҮҮЛЭН НАЙРУУЛЪЯ

Өгүүлбэрт үгс яаж холбогддогийг мэдье.

1. Үгсийг зөв байрлуулан найруулж, өгүүлбэр болгож бичээрэй. Эхэд гарчиг өгнө үү.
 - а. цэлмэг, байлаа, өдөр, сайхан
 - б. оготно, унажээ, нүхэнд, хашаан, дотор
 - в. чадсангүй, нүхнээс, гарч, оготно, оролдоод, яаж ч
 - г. оготны, нүхэн дээр, час час, ирэв, дуугаар, муур
 - д. мяу мяу, унжуулна, сүүлээ, би, үзүүрээс нь, гараад, чи, зүүгдээд, гэж хэлэв
 - е. би, айж байна, танаас
 - ё. нүхний, үхсэнээс, азаа, ёроолд нь, үзье, бодоод, сүүлнээс, гарав, гэж, зүүгдэн
 - ж. муур, савлаа, хэд дахин, сүүлээ, газар, годгонуулах
 - з. оготно, гүйгээд, нүхний, орчихжээ, аман дээр, унаж, цааш

Д.Базаррагчаа
Ш.Оюунцэцэг нар, Монгол хэл 5, 2007

Өгүүлбэрийн доторх үгс хоорондоо нөхцөлөөр холбогдож болно. Жишээ нь: “ах, шугам” гэсэн хоёр үг харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож “ахын шугам” гэсэн холбоо үг бүтэж байна.

Бас хоёр үг шууд холбогдож болно. Жишээ нь: “зузаан, ном” гэсэн хоёр үг ямар нэг нөхцөлгүйгээр холбогдож “зузаан ном” гэсэн холбоо үг бүтэж байна. Ийм холбоо үгийг үндсээр холбогдсон үг гэнэ.

2. Дараах өгүүлбэрийн доторх үгс хоорондоо хэрхэн холбогдож байгааг зурж тэмдэглэн, тайлбарлаарай.
Үлгэрлэвэл:

1. *Ажлын сайнд амьдрал сайжирна.*

2. *Өвсний сайнд мал таргална*

<i>ажлын сайнд</i>	харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр
<i>амьдрал сайжрах</i>	нэрлэхийн тийн ялгалын нөхцөлөөр
<i>сайнд сайжрах</i>	өгөх-оршихын тийн ялгалын нөхцөлөөр

Ажиллах өгүүлбэр:

- Уудам талд наадмын аялгуу цуурайтна.
- Сайн морь харцага шувуунаас ч хурдан.
- Хээр хөдөөд мал сүрэг дураараа бэлчинэ.
- Сайн нөхөр чулуун хэрэмнээс ч бат.

3. Цэгийн оронд тохирох нөхцөл бичиж өгүүлбэр бүтээгээрэй. Дараа нь өгүүлбэр тус бүрийг дараах алхмаар задлан тайлбарлана уу.

- | | |
|-----------------------------------|--------------------------------|
| Ажил... сайн... амьдрал сайжирна. | Бие... хүч... нэг... дийлнэ. |
| Өвс... сайн... мал таргална. | Билэг... хүч... олон... ялна. |
| Гар... хүч... ганц... дийлнэ. | Аав... хүү алдар... гайхуулна. |
| Эрдэм... хүч... мянга... дийл... | Ээж... хүү эрдэм... гайхуулна. |

Алхам	Жишээ
1. Асуулт тавин, үгсийг утгаар нь холбож тэмдэглэнэ.	<p>хэзээний? юу? хаанаас? яана?</p> <p>Намрын салхи өмнөөс сэргижнэнэ.</p>
2. Холбоо үгээр задалж бичнэ.	өмнөөс сэргижнэх, салхи сэргижнэх, намрын салхи
3. Яаж холбогдсоныг тайлбарлана.	<p>- “өмнө, сэргижнэх” гэсэн хоёр үг гарахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож “өмнөөс сэргижнэх” гэсэн холбоо үг бүтэж байна.</p> <p>- “салхи, сэргижнэх” гэсэн хоёр үг нэрлэхийн тийн ялгалын нөхцөлөөр холбогдож “салхи сэргижнэх” гэсэн холбоо үг бүтэж байна.</p> <p>- “намар, салхи” гэсэн хоёр үг харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр холбогдож “намрын салхи” гэсэн холбоо үг бүтэж байна.</p>

Холбоо үг нийлж өгүүлбэр бүтдэгийг мэдье.

- Дараах холбоо үгийг нийлүүлж, өгүүлбэр зохиогоорой.
 - алсын салхи, жихүүн амьсгалаар, тас няс хийх, салхи тас няс хийх
 - алтан дэлхий, уул тал, мөнгөн хуяг, уул тал өмсөх, мөнгөн хуягийг өмсөх
 - өвлийн шөнө, тэнгэрийн одод, оч мэт гялалзах, одод гялалзах, шөнө гялалзах
 - уудам талд, жинчин хүн, хүний дуу, дуу сонсогдох, тодхон сонсогдох, талд сонсогдох (Д.Нацагдорж)

Үгс нийлж холбоо үг бүтээдэг бол хэд хэдэн холбоо үг нийлж, өгүүлбэр бүтээдэг. Үгс ийнхүү холбогдож, тодорхой санаа илэрхийлнэ. Жишээ нь: “Хүү уралдааны морио унав” гэсэн өгүүлбэр нь “хүү унах, уралдааны морь, морио унах” гэсэн холбоо үгээс бүтсэн байна.

- Эхэд нэр өгөөрэй. Эхийн санааг дэлгэрүүлж бичээрэй. Дараах өгүүлбэрээс холбоо үгийг олж, холбож зураад асуулт тавиарай.

.....

Гол горхи урсана. Цэцэг ногоо ургана. Тунгалаг гэрэл, ариун үнэр арван зүгтээ дэлгэрнэ. Дуу чимээ алслан түгнэ. Цэцэг ногоо жигдэрнэ. Салхи урьхнаар үлээнэ. Хүний зүрхэнд баяр гийнэ.

ӨГҮҮЛБЭРИЙН ЦӨМ БҮТЦИЙГ ТАНЬЯ

Эхийн утгыг ойлгоё.

1. Уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгээ тэмдэглээрэй.

Ээж



... Сар ч үгүй, үүл ч үгүй зуны шөнө. Ээж бид хоёр явган харьж явлаа.

Ээж: - Айж байна уу? гэж баруун чихэнд дуулдахын төдий хэлнэ.

Би: - Айгаагүй ээ гэж уруул хөдлөхийн төдий хариулна.

Ээж намайг зүүн гартаа хөтлөөд алхаагаа нэмнэ. Би ээжийн гараас улам улам чанга атгана. Ээж: - Айгаагүй биз, миний хүү? гэж зүүн чихэнд сонсдохын төдий хэлнэ. Би толгой сэгсэрнэ.

Ээж намайг дахиад л баруун гартаа хөтлөн алхтал нүдний үзүүрт зурсхийн, тэнгэрийн хаяа руу од харвав.

Ээж: - Миний од биш гээд нулим! гэв.

Би: - Та нулимахгүй юм уу?

Ээж: - Миний хүү урьдаар нулим! гэлээ.

Би нулимав. Ээж нулимаад, санаа алдав...

Д.Батбаяр, Аниргүйн эрвээхэй, 1983

а. Танил биш үгийнхээ утгыг таамаглан тайлбарлаарай.

б. Дараах асуултад хариулаарай.

- Ээж хүү хоёрын хоорондын харилцааны өнгө аяс ямар байна вэ?
- Ээж нь яагаад “Миний од биш гээд нулим!” гэж хэлсэн бэ?
- Ээж нь санаа алдсаны учир юу юм бол?
- Уг эхийг “Ээж” гэж нэрлэсний учир юу вэ?
- Дээрх эхийн сэдэв, гол санааг тайлбарлана уу.

Өгүүлбэрийн тухай ойлголтоо сэргээн ярилцъя.


1. Дараах хоёр эгнээ өгүүлбэрүүдийг ажиглаад ямар ялгаа байгааг тайлбарлаарай.

- Өгүүлбэр тус бүрд нь хэдэн үйл үг байна вэ?
- Хэдэн өгүүлбэрээс бүтсэн гэж бодож байна вэ?

Ээж бид хоёр явган харьж явлаа.	Ээж намайг зүүн гартаа хөтлөөд алхаагаа нэмнэ.
Би ээжийн гараас улам улам чанга атгана.	Ээж намайг дахиад л баруун гартаа хөтлөн алхтал нүдний үзүүрт зурсхийн, тэнгэрийн хаяа руу од харвав.
Би толгой сэгсэрнэ.	Ээж нулимаад, санаа алдав...
Би нулимав.	

2. Дараах бүдүүвчийг ажиглаад, өгүүлбэрийн бүтцийн талаар ярилцаарай.

Үйл үг бүр өгүүлбэр бүтээнэ. Иймд үйл үгийн тоогоор өгүүлбэр байна.



3. 1-р дасгалд байгаа хүснэгт дэх нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгож задлаарай. Жишээ нь:


Ээж намайг зүүн гартаа **хөтлөөд**, алхаагаа **нэмнэ**.

1. Ээж намайг зүүн гартаа **хөтлөв**.

2. Ээж алхаагаа **нэмэв**.

Өгүүлбэрийн гишүүний тухай мэдье.

1. Дараах онолын ойлголтыг уншаад, дэвтэртээ тэмдэглэж аваарай.



Өгүүлбэрийн цөм бүтцийг бүрдүүлдэг өгүүлэгдэхүүн (хэн?, юу?), шууд тусагдахуун (хэнийг?, юуг?), өгүүлэхүүн (яасан?, яав?) гишүүнийг өгүүлбэрийн гол гишүүд гэнэ. Жишээ нь: Би (хэн) атгана. (яана?)
Би (хэн?) толгой (юуг?) сэгсэрнэ. (яана?)

2. 3-р дасгалд задалсан энгийн өгүүлбэрийн гол гишүүдийн доогуур зураарай.

Асуулт	Хэн?	Юуг?	Яав?
Тэмдэг	_____	~~~~~	=====

Өгүүлбэрийн цөм бүтцийн тухай мэдье.

1. “Ээж” эхийн өгүүлбэр дэх үгсийг дараах асуултын дагуу ялгаарай.

хэн? юу?	хэнийг? юуг?	яав? яалаа? ...	Бүрэлдэхүүн
<u>Ээж бид хоёр</u>		<u>харьж явлаа</u>	2 бүрэлдэхүүнт
<u>Ээж</u>	<u>намайг</u>	<u>хөтөлнө.</u>	3 бүрэлдэхүүнт


2. Дараах онолын ойлголтыг уншаад цөм өгүүлбэрийн бүрэлдэхүүний тухай мэдээрэй.

Гол гишүүдээс бүтсэн өгүүлбэрийг цөм өгүүлбэр гэнэ. Жишээ нь: Би атгана.
Цөм өгүүлбэрийг үйл үгийнх нь тусах, эс тусах шинжээр нь 2 ба 3 бүрэлдэхүүнт гэж ангилна.

Өгүүлэхүүн нь тусах үйл үгээр илэрсэн цөм өгүүлбэрийг гурван бүрэлдэхүүнт, эс тусах үйл үгээр илэрсэн цөм өгүүлбэрийг хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр гэнэ. Жишээ нь: Ээж¹ намайг² зүүн гартаа хөтл³өв. Тэнгэрийн хаяа руу од¹ хар²вав.

Цөм өгүүлбэрийг хэрэглэж суръя.

1. Дараах зургийг сайтар ажиглаад цөм өгүүлбэр зохион бичээрэй.



Херлуф Бидструп "Юный художник"
<https://photochronograph.ru/2012/05/09/komiksy-xerlufa-bidstrupa/>

2. Ямар нэг эх сонгоод, үйл явдлыг төлөвлөхдөө цөм өгүүлбэр ашиглаарай.

ЦӨМ БУС ӨГҮҮЛБЭРИЙГ ТАНЬЯ

Цөм өгүүлбэрийг дэлгэрүүлье.

1. Цуврал зургийг ажиглаад, “Үнсгэлжин” үлгэрийн тайлбарыг дэлгэрүүлэн бичээрэй.

1	2	3	4	5
				
Үнсгэлжин амьдардаг байв.	Урилга ирэв.	Эгч нар нь явав.	Шидэт эх өгнө.	Үнсгэлжин бүжиглэв.
Хаана? Хэнтэй? Яаж?	Ямар?	Хаашаа?	Хэнд? Юу юуг?	Хэнтэй?

6	7	8	9	
				
Үнсгэлжин яаран гүйлээ.	Үнсгэлжин гээжээ.	Ханхүү зар тараана.	Шаахай яг таарав.	Ханхүү гэрлэжээ.
Хэзээ? Хаашаа?	Юуг?	Ямар?	Хэнд?	Хэнтэй?

2. Хүүхдийн зохиолч Ж.Дашдондогийн бичсэн “Сүү” шүлгээс гол гишүүдийг олж тайлбарлан, дэлгэрэнгүй өгүүлбэр болгож хувирган бичээрэй.

Үлгэрлэх нь:

Алтан нар цэлмэг тэнгэрт мандлаа. Зуны халуунд нуурын усан мандал халлаа.

Сүү

Нар
Нар мандлаа л
Нуур
Нуур халлаа л
Уур
Уур дэгдлээ л
Үүл
Үүл үүслээ л

Бороо
Бороо орлоо л
Ногоо
Ногоо гарлаа л
Үнээ
Үнээ идлээ л

Эмээ
Эмээ саалаа л
Гал
Гал аслаа л
Сүү
Сүү хөөрлөө л...

Ж.Дашдондог
Зуун хурга, 1979


3. Өгүүлбэрийн дэлгэрэнгүй бүтцийн талаар дүгнэн ярилцаарай.

Өгүүлэгдэхүүн, шууд тусагдахуун, өгүүлэхүүнээс бүрдсэн өгүүлбэрийг нэмэн дэлгэрүүлэгч бусад гишүүнээр дэлгэрүүлж болно.

Дэлгэрүүлэгч гишүүний тухай мэдье.

1. Дараах онолын ойлголтыг уншаад, дэвтэртээ тэмдэглэж аваарай.

Өгүүлбэрийн цөм бус бүтцийг бүрдүүлдэг тодотгол, шууд бус тусагдахуун, байц гишүүнийг өгүүлбэрийн дэлгэрүүлэгч гишүүд гэнэ.



Дэлгэрүүлэгч гишүүн	Ямар асуултад хариулагдах вэ?	Ямар утгатай вэ?	Ямар үгсийн аймгаар илрэх вэ?	Аль гишүүнд нь захирагдах вэ?
тодотгол	аль, ямар, хэд, хэчнээн, хэний, юуны, хаанахын, хэзээний	Тоо, шинж, хэний, юуны хамаатайг заана.	-тэмдэг нэр -тооны нэр -жинхэнэ нэр	Нэр үгтэй холбогдоно.
шууд бус тусагдахуун	хэнд, юунд, хэнээс, юунаас, хэнээр, юугаар, хэнтэй, юутай	Үйлэнд өртөж байгаа юмыг заана.	-жинхэнэ нэр	Үйл үгтэй холбогдоно.
байц	хэзээ, хаана, ямар учраас	Орон, цаг, зорилго, шалтгааны утга заана.	-орон цагийн нэр -жинхэнэ нэр	

Жишээ нь:

Чи минь ^{ямар?} торгон даашинзтай бүжиж байна.

Энэ өгүүлбэрт "торгон" гэсэн үг нь нэр үгээр илэрсэн гишүүнд захирагдан, ямар гэсэн асуултад хариулагдаж, тодотгол гишүүн болно.

^{хэнээс?} Таксины жолоочоос эхнэрийнх нь тухай асуухаа битгий мартаарай.

Энэ өгүүлбэрт "жолоочоос" гэсэн үг нь үйл үгээр илэрсэн гишүүнд захирагдан, хэнээс гэсэн асуултад хариулагдаж, шууд бус тусагдахуун гишүүн болно.

^{хаашаа?} Парис хотын зах руу явж өөр шигээ бүжигчдийг хар.

Энэ өгүүлбэрт "зах руу" гэсэн үг нь үйл үгээр илэрсэн гишүүнд захирагдан, хаашаа гэсэн асуултад хариулагдаж, байц гишүүн болно.

2. Дэлгэрүүлэгч гишүүнийг дараах алхмын дагуу тайлбарлаарай.

Алхам	Жишээ, тайлбар
1. Өгүүлбэрээ уншиж утгыг сайтар ойлгоно.	<i>Би чинийхээ ирээдүйг, чинийхээ мөрөөдлийг харж байсан.</i>
2. Өгүүлбэр дэх үгсийн холбоог олно.	Би харах, мөрөөдлийг харах, ирээдүйг харах, чиний мөрөөдөл, чиний ирээдүй
3. Эхлээд өгүүлэхүүнээ зурна.	"харж байсан" гэсэн үйл үг нь <i>яасан бэ?</i> гэсэн асуултад хариулагдаж өгүүлэхүүн гишүүн болно.
4. Өгүүлэхүүнээсээ ургуулан, асуулт тавьж өгүүлбэрийн гол гишүүдээ олно.	<i>Хэн? харж байсан</i> гэсэн асуулт тавиад <i>би</i> гэсэн үйлийн эзнийг олно. <i>Би юуг? харж байсан гэсэн асуултад хариулагдах "ирээдүйг, мөрөөдлийг"</i> гэсэн шууд тусагдахуун гишүүнийг олно.
5. Гол гишүүдийг нэмэн дэлгэрүүлж буй дэлгэрүүлэгч гишүүнд асуулт тавьж зурна.	<i>чинийхээ- хэний?</i> гэсэн асуултад хариулагдаж, хойшоо нэр үгтэй холбогдох тул тодотгол гишүүн болно.
	<p><i>хэн? хэний? юуг? хэний? юуг? яасан бэ?</i></p> <p><u>Би чинийхээ ирээдүйг, чинийхээ мөрөөдлийг харж байсан.</u></p>

Ажиллах өгүүлбэр:

- Аав нь олон үлгэр ярьж өгдөг байлаа.
- Чи минь торгон даашинзтай бүжиж байна.
- Гудамжны бүжигчдийн амьдралыг мэдэх учиртай.
- Аав нь циркэд олон жил ажилласан шүү дээ.

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

“Болжмор” эхийг уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Болжмор

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих час хийв. "Хэн юм шидчихэв ээ" гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. "Хүүе, өвөл яахаараа боргоцой байдаг билээ?" гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

- Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах:
- Хоёулаа үүр хийж өгье, өнөө орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа, талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан, үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа.

Davalгаа.mn, 2016

1. “шувууны найр” гэдэг үгийн утга аль нь вэ?
 - а. Найр наадам
 - б. Даарахгүй байгаа
 - в. Өвөл болохоор найрладаг
 - г. Хоёр хүүхэд шувуунд хайртай



2. Өгүүллэгийн түлхүүр үгсийг олж, доогуур нь зураарай.
3. Түлхүүр үгээ ашиглан, агуулгыг ойлгосноо тулгуур бичиглэлээр илэрхийлнэ үү.
4. Яагаад хоёр хүүхэд “Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа” гэж хэлсэн бэ?
5. “олон боргоцой” гэж юуг адилтгасан бэ?
6. “Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа... Хэн юм шидчихэв ээ... Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж, нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа.” гэсэн хэсгээс үйл үгийг ялган таньж тусах, эс тусах үйл үгийн аль нь болохыг тодорхойлж, өгүүлбэрийг бүрэлдэхүүнээр нь бүлэглээрэй.
7. Дараах өгүүлбэрүүдийг энгийн өгүүлбэр болгоод, цөм бүтцийг тэмдэглээрэй.

- Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа, талхны үртэс тавилаа.
- Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан, үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой.
- Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа.

Бичих даалгавар

1. Дараах зургийн үйл явдлаас сэдэвлэн эх зохион бичээрэй. Үгийн тоо 100-120 орчим
2. Зургийг үйл явдлын дагуу зөв байрлуулаарай.
3. Бичих зүйлдээ төлөвлөгөө зохионо уу.

Эхлэл хэсэгт


- Үйл явдал болох орчныг дүрслэн бичих
- Дүрүүдийг гадна талаас нь зураглан бичих
- Үйл явдлын зангилаа

Гол хэсэг

1-2 үйл явдал өрнүүлэх

Төгсгөл хэсэг

- Дүгнэн бичих.
- Юу юу нүдэнд харагдаж, чихэнд сонсогдож, сэтгэлд мэдрэгдсэнийг бичих



ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

“Зурагтай танилцсан минь” эхийг уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Зурагтай танилцсан минь

Жаалхүү гэдэг өвгөнийх олон хүүхэдтэй айл байв. Нэгэн өдөр тэдний хамгийн том хүүхэд гэрийнхээ гадаа завилж суугаад, өвөр дээрээ дөрвөлжин мод тавьж, ямар нэгэн юм хийж байхыг харлаа. Юу хийж байгааг нь үзэх сэн гэхээс тэсэж суух аргагүй болов. Ороо хонь барих гэж байгаа юм шиг сэм сэмхэн гэтсээр, тэр хүүхдийн ар талд очоод өнгийн харвал, онц сонин юм үзэв. Модон самбар дээр үнс түрхжээ. Нарийхан үзүүртэй савх модоор үнсэн дээгүүрээ нааш цааш зурж байгааг нь харахад гайхмаар ажээ. Даваасамбуу гэж тэр хүүг нэрлэдэг юм. Даваасамбуугийн гар нь нааш цааш уяхнаар хөдлөх бүрийд үнс түрхсэн самбар дээр дүрс гарч байлаа. **Саваг үсэндээ** дарагдсан сүртэй том **сарлагийн бух**ны дүрс гараад ирлээ. Бух урд хөлөөр газар цавчлан, хэлээ унжуулан, **туужуу** мэт сүүлээ **хондлой** дээрээ **агсжээ**... Модон дээр модоор тэгж сайхан зурж болдгийг анх удаа тийнхүү мэдэж авлаа. Гол нууц нь модон самбар дээр түрхсэн аргалын үнс гэдгийг нь би мэдлээ. Даваасамбуу гэв гэнэт нөгөөх зургаа үнс асган балласанд би харамсаж, “Хүүе, битгий” гэж дуу алдав. Даваасамбуу над руу эргэж харснаа ухасхийн босож гэрийн зүг одлоо.

Санамсаргүй нээж олсон нууцаа туршиж үзэхээр би гэрийн зүг салхи мэт дэгдэн одлоо. Гэрт орж ямар нэгэн дөрвөлжин мод хайж гарлаа. Гэрт хэн ч үгүй тул би дураараа загнах эрхтэй байлаа. Гай болоход гэрт нэг ч хавтгай мод байсангүй. Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос **нэвчсэн** бор мод **эргүүл** дээр байв. Хэсэг эргэлзсэний эцэст би тэр модыг олзлон авч **тулга**ны захаас аргалын цагаан үнс хайж олоод, дээр нь нунтаглан түрхэв. **Дөрвөлжтэй** түлээн дотроос бяцхан мод олж, хутгаар үзүүрлэв. Зурах ажилдаа орлоо. Сарлагийн бух зурж эхлэв. Даваасамбуу шиг уран зурах гэгч огт хялбар биш ажил байжээ. Хөлсөө гартал ноцолдоод, нэг бух зурсан чинь хөрш айлын доголлон халтар нохойтой адилхан амьтан болчихлоо. Эсрэг талд нь ахиад нэг бух зурах гэж улайран сууж байтал, гэв гэнэт хацар дээр халуу оргив.

-Чи яагаад өрөм хатаадаг мод бузарлав. Ээжид чинь хэлж турсагыг чинь хуулуулна даа! гэж загнах дуунаар өндийн үзвээс авга эгч зогсож байлаа...


-Айдаа, энийг хар аа, юу вэ? гэж би зурсан зургаа заалаа.

-Аль вэ, яагаав Донтор л байна гэж Айдаа хөхөрч гарав. Донтор гэж хөрш айлын доголлон халтар нохойны нэр л дээ.


-Донтор биш ээ. Ааяа Балдангийн халзан бухыг зурсан юм гэж би ярьсанд Айдаагийн инээд улам хүрч, бүр сүүлдээ эвхрэн ойчоод нүдний нь нулимс цувж, цээж нь хэрчигнэн хөхөрсөөр байлаа... Түүнийг хөхөрч хэвтэх хоорондуур би гарч зугтаалаа. Үнс түрхсэн самбараа аргал дотор нуув. Түүнээс хойш миний хийдэг юм зураг боллоо. Зун бол голын хөвөөний нойтон шавар, торгон элс, өвөл бол цасан дээр элдэв амьтны дүрс зурна. Заримдаа хөөтэй мод олж цагаан чулуу, байшингийн ханан дээр зурна...

Л.Түдэв. Бүтээлийн чуулган, 4-р боть, 2002

1. Тэмдэглэсэн үгийн утгыг хам сэдвийн хүрээнд таамаглан ярилцаарай. Дараа нь тайлбар толь бичгээс утгыг нь мэдэж тайлбарлаарай.
2. Асуултад хариулж, эхийн утга, бүтцийг тодорхойлоорой.
 - Дээрх эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - Болсон явдлыг дүрслэхэд чухал үүрэгтэй тулхүүр үгсийн доогуур зураарай.
 - Зурсан үгсээ ашиглан тулгуур бичиглэл хийж, эхийн гол санааг дүгнээрэй.
3. Дээрх эхэд дараах ойлголтууд байгаа эсэхийг шинжлээрэй. Байгаа бол (+), байхгүй бол (-) тэмдгийг өмнөх дугуйд тавьж, учрыг ярилцаарай.



4. Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг, өгүүлбэрийг бүлэглэн, тайлбарлаарай.
5. Чи энэ болсон явдлыг уншсанаар өөрийнхөө эргэн тойронд болсон ямар нэг явдлыг эргэн санасан уу? Яриарай.
6. Эхийн бүтцийг шинжлэхдээ дараах даалгаврыг гүйцэтгээрэй.



9. Дараах өгүүлбэр дэх үгс хоорондоо хэрхэн холбогдож байгааг зурж тэмдэглээд, асуулт тавиарай.

- Модон самбар дээр үнс түрхжээ.
- Гэрт орж ямар нэгэн дөрвөлжин мод хайж гарлаа.
- Дөрвөлжтэй түлээн дотроос бяцхан мод олж хутгаар үзүүрлэв.
- Сарлагийн бух зурж эхлэв.
- Үнс түрхсэн самбараа аргал дотор нуув.

10. Дараах өгүүлбэрийг уншаад, "боргилох", "төрөх" гэсэн үгэнд холбогдох үгийг нөхөж бичээрэй.

Аргалын утаа боргилсон малчны гэрт төрсөн, би.



11. Найруулж бичээрэй.

а. Дараах үгсийг холбон найруулж өгүүлбэрүүд бүтээгээрэй.

- Манай анги, зарим хүүхэд, марк, сонин, хайчилбар, цуглуулах
- Харин, би, тааралдсан, цуглуулдаг байх
- Тэгээд, тэд, өөр, амьд амьтан, цуглуулах, зоорь, амьтны хүрээлэн, болгохоор шийдэх
- Эхлээд, хүүхэд, хулгана гуйж авах, дараа нь жижигхэн хар, муур олох, зоорь хийх
- Удалгүй, нохой худалдаж авах, зоорь оруулах
- Тэгтэл

б. Бүтээсэн өгүүлбэрээ утгаар нь дараалуулж, эх бүтээж ярилцаарай. Эхэд гарчиг өгөөрэй.

в. Зохиосон өгүүлбэрт чинь нөхцөлөөр холбогдсон үгс, үндсээрээ холбогдсон үгсийн аль нь олон байгааг ажиглаарай.

г. Төгсгөлийг гүйцээн дэлгэрүүлж бичээрэй.

12. Дараах ойлголтыг гүйцээж бичнэ үү.

Хүний амьдрал бүхэлдээ болсон хэрэг явдлын талбар юм. Үүнээс хүнд сонин содон, мартагдашгүй хэрэг явдлыг нь “.....” хэмээн ялган хэлэлцэнэ. Болсон явдал нь өөрт буюу тохиолдсон хэрэг явдал байх бөгөөд аяллын тэмдэглэл, төрсөн сэтгэгдэл,, болон хувирна. Мөн домог, хууч яриа ч болсон үйл явдлаас сэдэвлэсэн байх нь олонтоо.

ТАВДУГААР БҮЛЭГ

ДҮРҮҮДИЙН ХАРИЛЦАН ЯРИА

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох
- Үйл явдалд харилцан яриа оруулж дэлгэрүүлэн бичих
- Харилцан ярианд цэг тэмдгийг зөв хэрэглэх

ЭХИЙН ДОТОРХ ХАРИЛЦАН ЯРИАНЫ ҮҮРГИЙГ ТОДОРХОЙЛЪЁ

Харилцан ярианы тухай мэдье.

1. Дараах хоёр эхийг уншаад, асуултад хариулаарай.

А эх

“Чи гал тогооны өрөөг хараад орхиоч, би гэрлээ унтрааж уу, үгүй юү?” гэж ээж нь Фэй Фэйд хэлэв. Фэй Фэй очоод “Ээж ээ, өрөөнд тас харанхуй, юу ч харагдахгүй юм байна шүү дээ” гэжээ.

Б эх

Туйл

- Гэрлээ асаах уу, аав аа?
- Харанхуй болохоор асаагаарай.
- Харанхуй болчхож шүү дээ.
- Бүр харанхуй болог доо, миний хүү
- Бүүр ийм үү?
- Аан тийм. Нүдээ ингээд тас анихаар юм харагдаж байна уу?
- Үгүй ээ.

Д.Батбаяр

- Дээрх 2 эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Эх тус бүрд хэдэн дүрийн хооронд яриа өрнөж байна вэ? Яагаад тэгж үзэв? Дүр тус бүрийг нэрлэнэ үү.
- Дүрүүдийн зан төрх мэдэгдэж байна уу? Дүр хоорондын харилцааны өнгө аяс ямар байх шиг байна? Яаж мэдэв?
- Дүрүүдийн хоорондын яриагаар болж буй үйл явдал тодорхой ойлгогдож байна уу?
- Ямар цэг тэмдэг хэрэглэсэн байна вэ? Ямар учиртай юм бол?
- Дээрх хоёр эхийг харилцан ярианы хэлбэрээр бичсэн гэдэгтэй санал нийлж байна уу? Яагаад?

Харилцан ярианы утга санааг ойлгоё.

1. Уншихдаа мэдэхгүй үгээ тэмдэглээд, утгыг тайлбарлаарай.

Бяцхан охин ээжийнхээ гараас хөтлөлцөн алхана.

Тэгээд гэнэт зог тусав. Түүний анхаарлыг татсан зүйл бол аавтайгаа дугуйн дээр сундалдан яваа нэгэн охин байлаа. Тэр охин дугуйны арын суудал дээр сууж, аавыгаа араас нь чанга гэгч нь тэвэрсэн байлаа. Тэд нэгэн зүйлийг ярилцаж инээн, нэлээд хөгжилтэй явцгаана.

Ээж нь үүнийг анзаараад “Гэрт чинь зөндөө тоглоом байхад чи бас л дугуйнаас нүдээ салгаж чадахгүй байна уу? Чи үнэхээр дугуйтай болмоор байгаа бол аавдаа хэлээд авхуулж болно шүү дээ” гэхэд бяцхан охин аяархнаар “Дугуй руу биш, охин руу харсан юм аа. Аав нь дугуй унаж байхдаа ч хүртэл үргэлж түүнтэй ярьж байсныг л” гэхэд ээж нь түүний малгайг засаад



“Найзууд чинь ийм хүйтэнд сургуульдаа алхаад л ирдэг шүү дээ. Харин чиний аав их ажилтай байдаг ч гэсэн чамайг машинаараа сургуульд чинь хүргэж өгдөг биз дээ” гэв. Бяцхан охин толгойгоо дохисон хэрнээ дугуй руу харсаар л байлаа. Ээж нь түүн рүү шоолонгуй хараад “Чи дугуйнд тийм дуртай юм бол аав чинь чамайг бас дугуйгаар хүргэж өгч болно шүү дээ” гэлээ. Охин нулимсаа арчаад “Тэгмээр л байна. Тэгвэл аавыгаа ядаж араас нь ч болов тэврэх юм байна” гэлээ.

- а. Эхийг дахин уншихгүйгээр агуулгаас санаанд орсон 5 үгийг бичнэ үү.
 - б. Тэдгээр үгээ оруулан 5 өгүүлбэр зохиогоорой.
 - в. Эхийн гол санааг 5-7 үгэнд багтаан бичээрэй.
2. Эхийг задлан шинжлээрэй.
- а. Түлхүүр үгийн доогуур зураарай.
 - б. Эх хэдэн догол мөрөөс бүтсэнийг тоолж, дугаарлана уу.
 - в. Догол мөр тус бүрийн санааг тодорхойлоорой.
 - г. Түлхүүр үгээ ашиглан эхийн гол санааг тодорхойлоорой.
 - д. Эхэд нэр өгөөд, гол санаатайгаа яаж холбогдохыг тайлбарлаарай.
3. Сэдвийг нэгтгэн дүгнээрэй.
- а. Түлхүүр үгээ ашиглан тулгуур бичиглэл хийгээрэй. Тулгуур бичиглэлээ найз нартаа ярьж, санал бодлоо солилцоно уу.
 - б. Эхийг уншаад юу мэдэрснээ, ямар сэтгэгдэл төрснөө бичээрэй.

Эхийн бүтэц, үйл явдлын дарааллыг ойлгоё.

1. Үйл явдлыг дарааллаар нь хүснэгтэд нөхөж бичээрэй.

Эхийн бүтцийн хэсэг	Үйл явдал
Эхлэл хэсэг	• Ээж охин хоёр хөтлөлцөн алхана.
Гол хэсэг	•
Төгсгөл хэсэг	•

2. Эхийг дахин уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.
- а. Доорх бүдүүвч дэх асуултад хариулаарай.



- б. Хэсэг тус бүрийн хаана нь харилцан яриа хэрэглэснийг ярилцаарай.

в. Ээж охин хоёрын харилцан яриагаар ямар ямар үйл явдал болсон нь тодорхой ойлгогдож байна уу? Ярилцаарай.

Дүрийн зан чанар, сэтгэл санааны байдлыг шинжилье.

1. Харилцан яриа бүхий хэсгийг зааглаж зураарай.
2. Дүр тус бүрийн яриаг өнгөөр ялган будаарай.
3. Ээж, охин хоёрын үг, үйлдлийг дараах хүснэгтэд нөхөж бичээрэй.

Ээжийн хэлсэн үг	Охины хэлсэн үг
<ul style="list-style-type: none"> • Гэрт чинь зөндөө тоглоом байхад чи бас л дугуйнаас нүдээ салгаж чадахгүй байна уу? Чи үнэхээр дугуйтай болмоор байвал аавдаа хэлээд авхуулж болно шүү дээ. • • 	<ul style="list-style-type: none"> • Дугуй руу биш, охин руу харсан юм аа. Аав нь дугуй унаж байхдаа ч хүртэл үргэлж түүнтэй ярьж байсныг л • •
Ээжийн хийсэн үйлдэл	Охины хийсэн үйлдэл
<ul style="list-style-type: none"> • Охиноо хөтөлсөн. • Охиноо анзаарсан. • • 	<ul style="list-style-type: none"> • Гэнэт зог тусав. • • • •

4. Дүрүүдийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс дүгнэлт гаргаарай.
 - а. Ээж охин хоёрын сэтгэл санааны байдал ямар байна вэ? Эхээс эш татан тайлбарлаарай.
 - б. Тэд ямар зан чанартай хүмүүс вэ? Жишээгээр батлан ярилцаарай.
 - в. Дүрийн зан чанар, сэтгэл санааны байдлыг харилцан ярианаас мэдэх боломжтой байна уу? Ярилцаарай.
5. 3-р дасгалын хүснэгтийг сайтар ажиглаад, асуултад хариулаарай.
 - Хэлсэн үг, хийсэн үйлдэл нь хэн хэний яриагаар илэрч байна вэ? Жишээгээр батлан тайлбарлаарай.

Дүр хоорондын харилцааны өнгө аясыг тодорхойлъя.

1. Тодруулсан үг, өгүүлбэрийн утга дээр тулгуурлан ээж охин хоёрын харилцааны өнгө аясыг тодорхойлоорой.

Жишээ нь: “Дугуй руу биш, охин руу харсан юм аа. Аав нь дугуй унаж байхдаа ч хүртэл үргэлж түүнтэй ярьж байсныг л” гэж хэлсэн охины “... харсан юм аа” гэснээс нэг л тийм аргадангуй өнгө аяс, “...байсныг л” гэж яриагаа дуусгаагүйгээс харахад ээжээсээ жаахан эмээсэн хандлагатай байна.



“Гэрт чинь зөндөө тоглоом байхад чи **бас** л дугуйнаас нүдээ салгаж чадахгүй байна уу? Чи **үнэхээр** дугуйтай болмоор байгаа бол аавдаа хэлээд **авхуулж болно шүү дээ.**



“Дугуй **руу биш**, охин **руу харсан юм аа.** Аав нь дугуй **унаж байхдаа ч хүртэл үргэлж түүнтэй ярьж байсныг л...**

Найзууд чинь **ийм** хүйтэнд сургуульдаа **алхаад л ирдэг шүү дээ.** Харин чиний аав **их ажилтай байдаг ч гэсэн** чамайг машинаараа сургуульд чинь **хүргэж өгдөг биз дээ.** Чи дугуйнд **тийм дуртай юм бол** аав чинь чамайг **бас** дугуйгаар **хүргэж өгч болно шүү дээ.**



“Тэгмээр л байна. Тэгвэл аавыгаа **ядаж араас нь ч болов тэврэх юм байна...**



Ойлголтоо нэгтгэн дүгнэе.

1. Дараах ойлголтыг гүйцээж бичээд, харилцан ярианы талаарх мэдлэгээ дүгнээрэй.

Хоёр болон түүнээс дээш хүмүүсийн хоорондын яриаг
 .. гэнэ. Харилцан яриа нь дүрийн сэтгэл санаа, болон тэдний
 хоорондын харилцааны, дүрийн зан чанар болон болсон үйл
 явдлын талаарх мэдээллийг нуршиж тайлбарлахгүйгээр уншигч, сонсогчдод
 дамжуулах үүрэгтэй.
 Харилцан яриа нь дүр хоорондын шууд яриагаар илрэхээс гадна өгүүлэгчийн
 болон хэн нэгний дам яриагаар илэрдэг байна.

ҮЙЛ ЯВДАЛД ХАРИЛЦАН ЯРИА ОРУУЛЖ ДЭЛГЭРҮҮЛЬЕ

Харилцан ярианы үүргийн талаарх ойлголтоо сэргээе.

- Дүр хоорондын харилцааны өнгө аясыг мэдэрч, үргэлжлүүлэн бичээрэй.

А: - Замын энэ хэсэг дээр болгоомжтой яваарай, миний найз! Наад гүүр болгон тавьсан чулуунууд чинь нурж мэднэ шүү. Чулуунуудын гол хэсэг дээр гишгэж яваарай. Надаас хоёр гараараа сайн бариарай. Маш анхааралтай явна шүү.

Б: - Өө баярлалаа. Миний бодлоор чиний зөвлөгөөгүйгээр би явчхаж чадна. Яагаад гэвэл энэ газрыг би арван хуруу шигээ мэднэ шүү дээ.

А: -

Б: -
- Дараах нөхцөл байдалд тохирсон харилцан яриа зохиогоорой.
 - Хаа сайгүй ил задгай хаясан хог нь байгальд хор учруулж байгаатай хоёр хүний нэг нь санал нэгдэж, нөгөө нь эс тоомсорлосон ч эцэс сүүлдээ ойлгож ухаарч байна.

Эхийн утга, бүтцийг задлан шинжилье.

- Дараах эхийг уншаад, утгыг ойлгоорой.
 - Уншихдаа утгыг мэдэхгүй үгээ тэмдэглээд, дараа нь тайлбарлаарай.

Гэмшил



Би арван настай байсан юм. Манайх тэр үед Сэлбэ голын хөвөөнд зусаж, би тэр хавийн хүүхдүүдтэй жараахай хөөцөлдөн тоглож өнждөг байлаа.

Тэгэхэд Алимаа гэдэг хоёр суга таягтай хазгар охин байж билээ. Алимаа голын эрэг дээр суучаад л усанд чулуу шидэн бидний барих гэж байгаа жараахайг зориуд үргээн, тачигнатал инээнэ. Тэгэхээр нь бид таягийг нь авч зугтаана. Уурлуулна. Тэгсээр байгаад бүр уйлуулчихна. Уйлчихаар нь бид аргадаж эхэлнэ. Алимаа эхэр татан хумсаараа газар маажин удтал тайтгарах ч үгүй, босох ч үгүй суучихна. Бид элдвээр аргадаж, инээхгүй болохоор нь циркийн алиалагчийг дуурайн худал ойчиж, уйлж маяглахаар гэнэт өөрийн эрхгүй инээд алдан, алиалсан хүүхдийг таягаар цохино. Цаадах нь унан тусан худлаа ёолон, газар өнхрөхөөр сая санаа алдан тайтгардаг сан.

Нэг өдөр бид Алимааг уйлуулдгаараа уйлуулчхав. Харин Алимаа бидний хэнийг ч, яаж ч алиалсан инээсэнгүй. Тэгэхээр нь бид Алимаад “Малгай дүүрэн эрвээхэй барьж өгье, тэгэх үү?” гэлээ. Алимаа толгой дохив. Бид баярлан хашхиралдаж,

эрвээхэй хөөн гүйлдэв. Эрвээхэй цэцгэн дээр суумагц наран талаас нь сэмээрхэн гэтэж очин, малгайгаараа даран авахад малгай дотор цэцгийн дэлбээ шиг өнгөлөг эрвээхэй байж байдаг сан. Бид барьсан эрвээхэйгээ Алимаад авчирч өгөн, өөр улам гоё эрвээхэй хөөн гүйнэ. Алимаа “Ямар гоё далавчтай юм бэ?” гэж өхөөрдөн цөмийг нь малгайд хийж, баруун гарынхаа суга таягны дунд бариултай цуг хумин атгачхаад, бидний араас суга таягаа тулж, урагшаа хурдан хурдан тэмүүлэн яваа харагдав. Бид бараг цэцгийн бүх өнгөтэй ижил өнгийн эрвээхэйнүүд барьж, эрвээхэйнүүдээ хаана хатаах тухай маргалдаж байтал Алимаа гэнэт малгайтай эрвээхэйнүүдийг цөмийг нь дээш цацчихав. Өнгө өнгийн эрвээхэй нэгэн мөчид агаарт цэцэг дэлгэрэх шиг алаглаж харагдсанаа зүг бүр тийшээ нисэлдэхэд бид дахиад л нэг нэг эрвээхэй хөөн хашхиралдан одов. Алимаа тээр хойно хоцорчихсон бидний хойноос дэгэнцэж харагдлаа.

Бид нэг хэсэг барьсан юмгүй баахан гүйлдэж яваад эргэж ирэхэд малгай дотор нэг улаан цоохор эрвээхэй үлдчихсэн байв. Түүнийг хэчнээн ч дээшээ шидсэн нисэхгүй болохоор нь бид нэг шар цэцгэн дээр тавиад орхиж билээ. Хөөрхий тэр эрвээхэй цэцгэн дээр үхсэн үү, нисээд явчихсан уу мэдэхгүй. Харин харьж явахдаа би хурууныхаа өндгөнд улаан хүрэн будаг шиг юм наалдчихсан байхыг үзээд дотор палхийн “Энэ лав нөгөө нисээгүй эрвээхэйн далавчных л байх” гэж бодогдон хуруугаа арчин арчин гэртээ оров. Аав ээжийн хэн нь ч мэдээгүй. Тэр ч байтугай хамт тоглодог хүүхдүүдээс нэг нь ч мэдээгүй гэдгийг мэдэж байгаа хэр нь тэр оройжин зүрх минь удтал түг түг цохилж билээ.

Тэр цагаас хойш хүмүүс бие биенийхээ жигүүрийг гэмтээчих болгонд сэтгэл минь эмзэглэн надаас болж Алимаа суга таягтай болсон мэт санагддаг юм.

*Д. Батбаяр,
Саахалтын нууранд ангир дуугарна,
1964 он*

- б. Эхийг дахин уншихгүйгээр агуулгаас санаанд орсон 5 үгийг бичнэ үү. Тэдгээр үгээ оруулан 5 өгүүлбэр зохиогоорой.
- в. Эхийн гол санааг 5-7 үгэнд багтаан бичээрэй.

2. Эхийг задлан шинжлээрэй.


- а. Эхийн түлхүүр үгийн доогуур зураарай.
- б. Эх хэдэн догол мөрөөс бүтсэнийг тоолж, дугаарлана уу.
- в. Догол мөр тус бүрийн санааг тодорхойлоорой.
- г. Түлхүүр үгээ ашиглан эхийн гол санааг тодорхойлоорой.
- д. Эхийн нэр гол санаатайгаа яаж холбогдож байгааг тайлбарлаарай.

3. Сэдвийг нэгтгэн дүгнээрэй.

- а. Түлхүүр үгээ ашиглан тулгуур бичиглэл хийгээрэй. Тулгуур бичиглэлээ найз нартаа ярьж, санал бодлоо солилцоно уу.
- б. Энэ эхийг уншаад юу мэдэрснээ, ямар сэтгэгдэл төрснөө бичээрэй.

Эхэд харилцан яриа оруулж бичье.

1. Эхэд юуны тухай өгүүлснийг эргэн санаж, ярилцаарай.
2. Эхэд харилцан яриа оруулах төлөвлөгөө гаргаарай.



Жишээ нь: Наадаг цаас ашиглан төлөвлөсөн нэгэн сурагчийн төлөвлөгөөг доор харууллаа. Үүнээс санаа авч болох юм.

1. Гол хэсгийн 2-р догол мөрөнд Алимаа болон хүүхдүүд хоорондын харилцаа өгүүлэгдэж байна. Энэ хэсэгт яриа оруулна.

2. Би баатар Алимааг аргадах арга чарга хайн бусадтайгаа ярьж байгаагаар зохионо.

4. Би баатрын өрөвч, зөөлөн, энэрэнгүй зан чанарыг илүү тодруулна.

Тэгэхэд Алимаа гэдэг хоёр суга таягтай хазгар охин байж билээ. Алимаа голын эрэг дээр суучаад л усанд чулуу шидэн бидний барих гэж байгаа жараахайг зориуд үргээн тачигнатал инээнэ. Тэгэхээр нь бид таягийг нь авч зугтаана. Уурлуулна. Тэгсээр байгаад бүр уйлуулчихна. Уйлчихаар нь бид аргадаж эхэлнэ. Алимаа эхэр татан хумсаараа газар маажин удтал тайтгарах ч үгүй, босох ч үгүй суучихна. Бид нэг удаа элдвээр аргадсан ч, инээхгүй болохоор нь

циркийн алиалагчийг дуурайн худал ойчиж, уйлж маяглахаар (-нгуут) гэнэт өөрийн эрхгүй инээд алдан, алиалсан хүүхдийг таягаар цохинө (-в). Цаадах нь унан тусан худлаа ёолон, газар өнхрөхөөр (-төл) сая нэг юм санаа алдан тайтгардаг сан. (-ч билээ.)

3. Би баатар түүнийг өрөвдөн, тайтгаруулах, санал гаргана. Зарим нь зөвшөөрч, зарим нь эс тоомсорлож байсан ч түүнийг үл тоож, бараг маргалдах нь холгүй байж Алимааг инээлгэх аргыг олж байгаагаар зохионо.

- Төлөвлөгөөгөө найз нартаа ярьж, санал зөвлөгөөг нь аваарай.
- Найз нарынхаа өгсөн санал, зөвлөгөөний дагуу төлөвлөгөөгөө сайжруулаарай.

3. Төлөвлөгөөний дагуу яриагаа ноороглоорой.

- Бичихийн өмнө сурагчийн бичсэн харилцан ярианы эхлэл хэсгийг уншаад, аль хувилбар нь илүү сайн болсныг шүүн ярилцаарай.
- Бичсэн арга хэлбэр, цэг тэмдгийг сайн ажиглаарай.
 - Аль арга хэлбэрээр харилцан яриа зохиож оруулахаа сонгосны дараа бичиж эхлээрэй.
 - Дүр хоорондын харилцааны өнгө аяс, дүрийн зан чанарыг тодруулахуйц яриа үүсгэхийн тулд үгээ зөв сонгоорой.

Би баатар түүнийг өрөвдөн, тайтгаруулах, санал гаргана. Зарим нь зөвшөөрч, зарим нь эс тоомсорлож байсан ч түүнийг үл тоож, бараг маргалдах нь холгүй байж Алимааг инээлгэх аргыг олж байгаагаар зохионо.

А хувилбар: Дүр хоорондын шууд яриа

Би: - Хүүе. Манайхаан! Алимааг яаж инээлгэх вэ? Уг нь тэгсхийж байгаад л тайтгардаг юм сан. Өнөөдөр яасан юм бол оо?

Бат: - За яавал гэж! Дандаа л Ингэж байдаг биз дээ? Би л лав явлаа.

Би: - Тайтгарвал тайтгарахаар л хугацаа өнгөрлөө шүү дээ, та минь ээ?

Аз: - Харин тийм ээ. Нэг арга олъё оо.

Би: - Тэгье. Харин ямар?

Аз: -

.....

Би: -

.....

Б хувилбар: Өгүүлэгчтэй яриа

...миний санаа зовниж, "Хүүхдүүд ээ! Алимааг яаж инээлгэх вэ? Уг нь тэгж байгаад л тайтгарчихдаг юм сан" гэж аяархан хэлээд, доош хартал:

Бат "За яавал гэж! Дандаа л ингэж байдаг биз дээ." гээд духаа үрчийлгэн, амаа мушилзуулаад, Алимаагийн зүг толгойгоороо дохин ёжтой инээснээ босоод явчихлаа. Харин Гэрэл "

.....

.....







.....

.....

.....

.....

4. Ноороглноо дараах шалгуурын дагуу хянаж, сайжруулаарай.

	<p>1. Унших</p> <ul style="list-style-type: none"> • Харилцан яриагаа сонгосон хэсэгтээ оруулж уншсан уу? • Харилцан яриагаар үйл явдал тодорхой болсон уу? • Уншихад утга санаа ойлгомжтой байна уу? 	
<p>2. Хянах</p>	<ul style="list-style-type: none"> • Хэмжээний хувьд нуршуу биш болсон уу? • Харилцан яриандаа дүрийн сэтгэл хөдлөл, үйлдэл хөдөлгөөнийг харуулсан үг, цэг тэмдэг хэрэглэсэн үү? 	
	<p>3. Оруулах, солих</p> <ul style="list-style-type: none"> • Яриа оруулсан хэсгийн өмнө хойно нь шаардлагатай зарим нэг үг нэмсэн үү? • Харилцан ярианы өмнө, хойно байгаа өгүүлбэрийн төгсгөлүүдийг өөрчилсөн үү? 	
<p>4. Байр шилжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Харилцан яриа нь үйл явдлын дарааллын хувьд зөв байна уу? • Үг, өгүүлбэрийн байр зөв байна уу? 	
	<p>5. Хасах</p> <ul style="list-style-type: none"> • Онц шаардлагагүй үг, зарим нэгний яриа байна уу? • Нэг үг, бүтээвэр ойр ойрхон олон давтагдсан байна уу? 	
<p>6. Шалгах</p>	<ul style="list-style-type: none"> • Харилцан ярианы бичлэгийн арга хэлбэр, цэг тэмдгээ шалгасан уу? • Зөв бичих дүрмийн алдаагаа зассан уу? 	

5. Сайжруулснаа найзуудтайгаа ярилцаж, зөвлөгөө аваарай.

Найзын нэр	Өгсөн зөвлөгөө	Зөвлөгөөг тусгасан эсэх

6. Бичсэнээ эхэд оруулан, сийрүүлж бичээрэй.

ХАРИЛЦАН ЯРИАНД ЦЭГ ТЭМДГИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ

Эхийг уншиж, ойлгоё.

1. Эхийг уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгээ тэмдэглээрэй.

Сүсэглэл

- Ээж ээ, ээж ээ!
- Юу гэв, миний хүү?
- Би шээзгийгээ дүүргэчихлээ.
- Өө, ёстой сайн хүү. Ямар шалмаг хүүхэд вэ?
- Ээж ээ!
- Юу вэ, миний хүү?
- Өвөө үнэртээд байна.
- Миний хүү дуугүй бай! Өвөө чинь бурхан болсон шүү дээ.
- Бурхан болоогүй ээ, ээж ээ! Энэ хавьд л яваад байна даа. Яг үнэртээд байна. Үнэр нь мөн байна.
- Энэ чинь агь ганга, цэцэг навчсын үнэр шүү дээ.
- Үгүй дээ, өвөөгийн үнэр мөн байна даа.
- Ээ бурхан гончигсүм! Миний хүү тэгж ярьж болдоггүй юм.



... Өвөө бид хоёр уул хадаар явж, янз бүрийн цэцэг түүдэг. Түүгээрээ өвөө эм хийдэг сэн. Нүдэж, нунтаглаж суухдаа бүр ч сайхан зантай байдаг юм. Улсууд миний өвөөгөөс их л тан авдаг даа. Аав ээж хоёр өвөөг “Бурхан болчихсон” гэх юм. Бурхан дотор алга л байсан даа. Цэцэг түүх гээд явсныг нь мэдээгүй байх аа даа. Ээжийг эргээд харахад нь өвөөгөө олчихсон байх юм сан. Яг л үнэр нь гараад байгаа юм даа.

... Ээж арагтай аргалаа газар тавьчихаад, залбиран зогсож байв. Өвөөгийн үнэр улам ойртоно.

Дан. Нямаа, Нарны алга, 2012

2. Сайн мэдэхгүй үгийнхээ утгыг таамаглан ярилцаарай.

3. Дараах асуултад хариулж, тайлбарлаарай.

- Ээж хүү хоёр юуны тухай ярилцсан бэ?
- Гол дүрийн хүү ухаан суугаагүй, томоогүй гэдгийг юугаар батлах вэ?
- Хүү яагаад “Өвөөгийн үнэр мөн байна” гэж хэлсэн бэ?
- Яагаад энэ яриаг “Сүсэглэл” гэж нэрлэсэн бэ?

Харилцан ярианы цэг тэмдгийн тухай мэдье.

1. Дээрх эхэд байгаа цэг тэмдгүүдийг байраар нь бүлэглэж бичээрэй.

Өгүүлбэрийн эхэнд	Өгүүлбэрийн дунд	Өгүүлбэрийн төгсгөлд

2. Дараах хүснэгт дэх ойлголтыг уншаарай. Цэг тэмдгүүдийг ямар ямар зорилгоор хэрэглэдгийг мэдэж аваарай. "Сүсэглэл" эхээс тохирох жишээг олж батлаарай.

<ul style="list-style-type: none"> Хандаж хэлсэн үед Анхаарал татахаар Анхааруулж сануулсан Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үед 	!	Асууж, тодруулах үед	Том үсэг	<ul style="list-style-type: none"> Өгүүлбэр эхэлж байгаа үед Ярилцаж буй хүмүүсийн нэрийг бичих үед
Үргэлжлэл байгааг илэрхийлэх үед	...	?	-	Харилцан яриа болохыг ялгахын тулд
<ul style="list-style-type: none"> Тоочсон үед Нийлмэл өгүүлбэрийн дунд 	,	Энгийн хүүрнэсэн үед	"..."	Бусдын хэлсэн үгийг ялгахын тулд

Харилцан ярианы цэг тэмдгийг зөв хэрэглэе.

1. Харилцан яриаг үргэлжлүүлэн зохиогоорой. Дүрүүдийн зан чанарыг тодорхойлоорой. Жишээ нь:

Шоргоолж - сайхан сэтгэлтэй, юмыг байгаагаар нь хүлээж авдаг гэдэг нь "ямар гоё" гэсэн үгнээс харагдаж байна.

Аалз-.....



Д.Батбаяр

Шоргоолж: - Ямар гоё далавчтай юм бэ?
 Аалз: - Хн! Тэр муу далавчинд нь идэх юм ямар байх биш.
 Шоргоолж: -
 Аалз: -



2. Зохиосон эхээ уншиж үзүүлээрэй.

- Дүрийн шинж, сэтгэлийн өнгө аясад тохируулах
- Харилцан ярилцаж байгаа үеийн дүр хоорондын харилцааны өнгө аясыг мэдрэх
- Цэг тэмдгийг анхаарах

3. Дараах сэдвээс сонгон харилцан яриа зохиогоорой.

- | | |
|------------------------------------|-----------------------------------|
| <input type="checkbox"/> Аялал | <input type="checkbox"/> Сонирхол |
| <input type="checkbox"/> Цаг агаар | <input type="checkbox"/> Хоол |
| <input type="checkbox"/> Ном | |
| <input type="checkbox"/> Кино | |

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

1. Эхийн утгыг ойлгоё.

- Уншихдаа мэдэхгүй үгээ тэмдэглээд, утгыг тайлбарлаарай.

**Аав**

Чөдөр хаяжээ, би. Чимээгүйхэн гэгч нь аав ширтэнэ. Харц нь намайг ороолгоно.

Б.Лхагвасүрэн

2. Үгийн сангаа баяжуулъя.

- Эхийг дахин уншихгүйгээр агуулгаас санаанд орсон 3 үгийг бичнэ үү.
- Тэдгээр үгээ оруулан 3 өгүүлбэр зохиогоорой.
- Эхийн гол санааг 5-7 үгэнд багтаан бичээрэй.

3. Эхийг задлан шинжилье.

- Түлхүүр үгийн доогуур зураарай.
- Түлхүүр үгээ ашиглан, эхийн гол санааг тодорхойлоорой.
- Эхийн нэр, гол санаатайгаа яаж холбогдож байгааг тайлбарлаарай.

4. Сэдвийг нэгтгэн дүгнэе.

- Түлхүүр үгээ ашиглан тулгуур бичиглэл хийгээрэй. Тулгуур бичиглэлээ найз нартаа ярьж, санал бодлоо солилцоно уу.
- Эхийг уншаад юу мэдэрснээ, ямар сэтгэгдэл төрснөө бичээрэй.

5. Эхэд харилцан яриа оруулж дэлгэрүүлье.

- Сэдэв: Аавын хайр халамжийн тухай
- Гол санаа: Эцэг хүн үр хүүхдээ үг, үйлдлээрээ заан сургадаг гэсэн санаанд тохируулах
- Хүү аав хоёрын харилцааны өнгө аясыг бие биедээ хүндэтгэлтэй хандаж байгаагаар харуулах
- Дүрийн зан чанар, сэтгэл хөдлөлийг тодорхой гаргаарай.

6. Харилцан ярианы цэг тэмдгийн дүрмийг бататгаарай.
 а. Дараах харилцан яриаг уншаад, цэгийн оронд тохирох тэмдэг тавьж, зөв хэлбэрт оруулж бичээрэй.

Дэлхийн дулаарлын талаар бид юу мэддэг вэ?

Наран: ...Бат аа... Дэлхийн дулаарлын нөлөөг хамгийн их амсаж байгаа нутаг бол төв Азийн гол хэсэгт орших орнууд юм байна... Чи энэ талаар юу мэдэж байна вэ...

Бат: ...Харин тийм ээ... Энэ орнуудын нэг манай Монгол орон болоод байгаа шүү дээ... Үүний талаар би уншсан...Үнэхээр сэтгэл өвдөж байна...

Наран: ...Дулаарна гэхээр маш халуун болно гэсэн үг үү... Тэгээд л манай нутагт зундаа маш их халуун болоод байгаа юм байх л даа... Халуун болоод бороо ч орохгүй ногоо ч ургахгүй уйтгартай юм аа...

Бат: ...Уйтгартай байх юу ч биш ээ. Манай аавын яриаг сонсвол НҮБ-ын судалгаанд “Монгол орон ирэх хэдхэн жилд газар нутгийн 80% нь цөлжилтөд шилжиж энэ нь усны хомсдолын гол шалтгаан болно” гэж бичсэн байна гэсэн...

Наран: ... Ус бол амьдралыг тэтгэх чандмана эрдэнэ гэдэг шүү дээ. Усны хомсдолд орно гэдэг чинь амьдрал байхгүй болно гэдэгтэй адилхан сонсогдож байна даа...

Бат: ...Манай нэрт зохиолч Д. Нацагдорж ...Зуны найртай улиралд цэцэг, навч дэлгэрээд Жигүүртэн шувуу холоос ирж гангар гунгар донгодсон орон ... гэж бичсэн... Одоо Монгол орон минь ийм байж чадахаа болих нь ээ...

Наран: ...Энэ чинь өөрөө л ийм болоод байгаа юмыг бид яах ёстой юм... Бидэнд хийх зүйл байгаа юм уу...

- б. Дараах ойлголтыг гүйцээгээрэй.

1. Өгүүлбэрийн эцэст цэг, асуултын тэмдэг, анхаарлын тэмдгийг хэрэглэнэ.

- а. Хэлэх зорилгыг тодорхойлох зорилгоор
- б. Сэтгэл хөдлөлийг харуулах зорилгоор
- в. Үйлийн эзнийг ялгах зорилгоор
- г. Үргэлжлэл байгааг харуулах зорилгоор

2. Харилцан ярианы эхэнд тэмдэг тавина.

- а. Дугуй хаалт
- б. Хашилт
- в. Богино зураас
- г. Цуваа гурван цэг

3. Бусдын хэлсэн үг, бодсон бодлыг хийж тэмдэглэнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ҮЙЛ ЯВДЛЫН ЦАГИЙН ДАРААЛАЛ

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар

- Эхээс гол мэдээллийг ялгаж унших
- Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлэх
- Эхийн найруулгыг судалж, алдааг таньж, сайжруулах

Утгыг ойлгоё.

1. Эхийг анхааралтай уншина уу. Унших явцдаа танил биш, утгыг нь сайн ойлгохгүй үг байвал доогуур нь зурж тэмдэглээрэй.

Цэндийн Дамдинсүрэн

(1908-1986)



Цэндийн Дамдинсүрэн 1908 онд **одоогийн** Дорнод аймгийн Матад сумын нутагт Цэнд бичээчийн хоёрдугаар хүү болж төрсөн, жинхэнэ халх, малчин гаралтай хүн байжээ. (1)

Бага насандаа эцэг Цэндээр бичиг үсэг заалгаж, уншиж бичиж сурсан байна. 1933-1938 онд Ленинград хотод Дорно дахиныг судлах институтэд суралцаж төгссөн, 1946-1950 онд тус институтэд аспирант болж, “Гэсэрийн туужийн түүхт үндэс” гэдэг ном бичин, дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. (2)

1936 онд Л.В.Зевинятай гэрлэсэн. Эхнэр нь **Дорно** дахиныг судлах институтийн монгол хэлний ангийг төгссөн ажээ. Тэд 4 хүүхэдтэй болжээ. (3)

1938 онд Улаанбаатар хотод буцаж ирсний дараахан Дотоод Яаманд баригдан жил гаруй хоригдож байгаад, 1940 онд цагаадан суллагдсан байна. 1942-1945 онд “Үнэн” сонины эрхлэгчээр, 1945-1950 онд Шинжлэх ухааны хүрээлэнд ажилласан. Энэ хугацаанд “Нууц товчоо”-г орчуулж дуусган, шинэ үсгийн цагаан толгой зохиожээ. (4)

Ц.Дамдинсүрэн нь 1950-1952 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирал, 1952-1955 онд Зохиолчдын Эвлэлийн Хорооны дарга, 1955-1959 онд Улсын Их Сургуульд багш, 1959-1963 онд Хэл зохиолын хүрээлэнгийн захирлаар тус тус ажиллажээ. Энэ хугацаанд судалгааны ажлаа дагнан хийх зорилгоор даргын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг удаа дараа гаргаж байжээ. Тэрбээр “... чөлөө гуйж байгаа зорилго маань бол шинжилгээний ажлыг хийх бололцоог олж авах явдал болов. Эх орондоо би энэ ажил дээр л үр бүтээлийг гаргаж чадмаар байлаа. ... Монголын өв соёлыг судлах чухал бөгөөд тун ховор байлаа” гэсэн байдаг. [Ц.Дамдинсүрэн, Намтрын хуудсаас, УБ, 1990, 13-р тал] (5)

Тэрбээр судалгааны ажлаа үргэлжлүүлж, 1969 онд “Орос-монгол толь бичиг” зохиосон. 1971, 1973 онд Дорно дахиныг судлах институт, 1979-1981 онд Гумбольдтын нэрэмжит их сургуулийн урилгаар Ленинград, Берлинд очиж ажиллажээ.

1982 оноос ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд төвөд судлалын тасгийг бий болгож эрхлэгчээр нь ажиллаж байв. (6)

Ц.Дамдинсүрэн нь амьдралынхаа нэгээхэн хэсгийг монголын эртний уран зохиол судлалд зориулж, судалгааны олон бүтээл, ном зохиол хэвлүүлсэн. Тухайн үед түүнийг үндсэрхэг үзэлтэн хэмээн хавчин гадуурхаж байв. Гэтэл **өнөөдөр** түүний судалгааны бүтээлүүд нь дэлхийн үе үеийн монгол судлаач эрдэмтдийн ашигладаг тулгуур бүтээл болсон хэвээр байна. (7)

Ц.Дамдинсүрэн судалгааны ажлаас гадна олон сайхан зохиол бичиж, хэвлүүлсэн байдаг. 1928 онд “Өчүүхэн дөрвөн үлгэр” өгүүллэгээр зохиол бичих гараагаа эхэлсэн бол “Буурал ээж минь”, “Зугаацахаар мордсон нь”, “Наалинхай хоёр нүд”, “Усан дагина” зэрэг яруу найргийн бүтээл, “Гологдсон хүүхэн” тууж, “Солийг сольсон нь”, “Хоёр цагаан юм”, “Багш шавь хоёр”, “Хэлдэг гурав хийдэг ганц”, “Хачин хурим”, “Чөтгөр”, “Чемодантай юм” зэрэг өгүүллэг бичжээ. Мөн “Алтан загасны үлгэр”, “Олег цэцний дуулал” зэрэг олон бүтээлийг орчуулсан байна. (8)

Түүний бүтээлийг нь үнэлж, 1945 онд “Маршал Чойбалсангийн 50 насны ойд зориулсан ерөөл”-д нь, 1947 онд “Нууц товчоо” зохиолыг хөрвүүлсэнд нь, 1950 онд “БНМАУ-ын төрийн дуулал”-ын үгийг зохиосонд нь төрийн шагналыг тус тус олгожээ. Монголын шинэ үеийн уран зохиолыг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлэн, 1986 онд “Ардын уран зохиолч” цолыг анх хүртээсэн. (9)

Эрдэмтэн зохиолч, соён гэгээрүүлэгч Ц.Дамдинсүрэн 1986 оны зургаадугаар сарын 5-нд таалал төгсжээ. (10)

1. Өөрсдийн тэмдэглэсэн үгсээс 5-ыг сонгож, утгыг нь эхийн хам бүтцээс таамаглан бичнэ үү. Дараа нь Монгол хэлний тайлбар толь бичгээс уг үгэнд тохирох тайлбарыг олно уу. Жишээ нь:

Танил биш үг	Миний таамагласнаар	Толь бичиг дэх утгын тайлбар
хошуу		

2. Ц.Дамдинсүрэн гуайн намтраас үзэхэд таван удаа “ажлаасаа халагдсан” байдаг. Үүний шалтгааныг илэрхийлсэн хэсгийг намтраас олж ярилцана уу.

Эхийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэе.


1. Эхээс түлхүүр үгийг олж доогуур нь зурна уу. Түлхүүр үг гэж эхийн гол санааг гаргахад чухал үүрэгтэй, эхэд олон давтамжтай хэрэглэгдсэн жинхэнэ нэрээр илэрнэ.

Хамгийн олон давтамжтай хэрэглэсэн үг: он, Дамдинсүрэн (ил ба далд хэлбэрээр өгүүлбэр бүрд, зарим тохиолдолд түүнийг, тэрбээр, түүний гэх мэт төлөөний үгээр), дарга, эсвэл захирал

1. Намтрыг дахин уншаад, дараах асуултын дагуу ярилцаарай.
 -Намтрыг бичихдээ ямар ямар баримт ашигласан байна вэ?
 -Намтрыг бичигч өөрийн үзэл бодол, дүгнэлтийг яаж илэрхийлсэн байна вэ?
2. Намтраас сонгосон дараах хоёр хэсгийг харьцуулаад ямар ялгаа байгааг ярилцаарай. Аль хэсэгт болсон хэрэг явдлыг тоочсон, алинд нь хүүрнэж тайлбарласан байна вэ?



3. Намтраас аль нэг догол мөрийг сонгон, гол мэдээллийг ялган бичээрэй.
4. Ялгасан мэдээлийг яаж дэлгэрүүлснийг асуулт тавин тодорхойлж ярилцаарай.
5. Дараах хоёр өгүүлбэрээс аль нэгийг нь сонгон дэлгэрүүлж бичээрэй.



Гол мэдээлэл

Би ... онд сургуульд орсон.

Дэлгэрүүлсэн мэдээлэл

Хаана? Аль сургуульд орсон бэ? Багшийн нэр хэн бэ? Хэдэн хүүхэдтэй анги вэ? Сургуульд орох ямар санагдсан бэ? г.м

1. “Хүний намтар гэдэг дотоод сэтгэлийн намтар. Хүн хүсэл мөрөөдлийнхөө төлөө явж, амьдралын амтыг таашаан эдэлж цаашлаад баталгаат замаар өөрийгөө авч явахыг намтар гэх бөгөөд өөрийнхөө тухай хожим ярих дурсамж” гэж нэгэн ухаантан бичжээ. Ц.Дамдинсүрэнгийн намтраас дээрх өгүүлбэрийн санаатай тохирох хэсгийг олж, учрыг тайлбарлана уу.
2. Догол мөр тус бүрээс ялгасан гол мэдээллийг дахин уншаад намтрыг товчоолж бичнэ үү.

Догол мөр	Он	Үйл явдал
(1)	1908	Төрсөн.
(2)	багадаа	Уншиж бичиж сурсан.
(2)	1933-1938	Ленинград хотод суралцсан.
(3)	1936	Гэрлэсэн.
(4)	1938-1940 1942-1945	Дотоод Яаманд баригдаж, хоригдсон, суллагдсан Үнэн сонины эрхлэгч болсон.
(2)	1946-1950	Ленинград хотод аспирант, дэд эрдэмтэн болсон.
(5)	1050-1952	Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргаар ажилласан.
(5)	1052-1955	Зохиолчдын Эвлэлийн Хорооны даргаар ажилласан.
(5)	1955-1959	Улсын Их Сургуулийн багшаар ажилласан.
(5)	1959-1963	Хэл зохиолын хүрээлэнгийн захирлаар ажилласан.
(6)	1969	Орос монгол хэлний толь бичиг зохиосон.
(6)	1971, 1973	Ленинградад урилгаар ажилласан.
(6)	1979-1981	Германд урилгаар ажилласан.
(6)	1982 1945, 1947, 1950, 1986	Хэл зохиолын хүрээлэнд төвөд судлалын тасгийн эрхлэгчээр ажилласан. Шагнуулсан.
(10)	1986	Таалал төгссөн.

1. Намтрын агуулгын зураглалыг ажиглаад, дараах мэдээлэл намтарт яагаад чухал байдгийг дүгнэн ярилц.



Намтрын хэл, найруулгыг судалъя.

1. Намтраас авсан дараах хэсгийг уншаад намтар бичигч болон Ц.Дамдинсүрэн өөрөө бичсэн хэсгийг зааглан тэмдэглээрэй.

Ц.Дамдинсүрэн нь 1950-1952 онд Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн захирал, 1952-1955 онд Зохиолчдын Эвлэлийн Хорооны дарга, 1955-1959 онд Улсын Их Сургуульд багш, 1959-1963 онд Хэл Зохиолын Хүрээлэнгийн захирлаар тус тус ажиллажээ. Энэ хугацаанд судалгааны ажлаа дагнан хийх зорилгоор даргын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг удаа дараа гаргаж байжээ. Тэрбээр "... чөлөө гуйж байгаа зорилго маань бол шинжилгээний ажлыг хийх бололцоог олж авах явдал болов. Эх орондоо би энэ ажил дээр л үр бүтээлийг гаргаж чадмаар байлаа. ... Монголын өв соёлыг судлах чухал бөгөөд тун ховор байлаа" гэсэн байдаг. [Ц.Дамдинсүрэн, Намтрын хуудсаас, Уб, 1990, 13-р тал]

2. Бичлэгийн хувьд ямар ялгаа байна вэ? харьцуулан тайлбарлаарай.
3. "Намтрын хэлний онцлог"-ийг уншаад тохирох 1-2 жишээг намтраас олж бичээрэй.
- а. Үйл үг ямар хэлбэрээр төгссөн байна вэ?
- б. Цаг хугацааны дарааллыг ямар ямар үгээр илэрхийлсэн байна вэ?

Намтрын хэлний онцлог:

Үйл үгийг ихэвчлэн өнгөрсөн цагаар хэлбэржүүлдэг.

- Бичигч тухайн хүний амьдралд тохиолдсон үйл явдлыг бичихдээ ихэвчлэн өнгөрсөн цагийн нөхцөлөөр хэлбэржүүлдэг. Жишээ нь: –даг⁴ байжээ, –даг⁴/байсан, –даг⁴ байлаа, –даг⁴ байв, –сан⁴ байна, сан⁴ ажээ, –жээ, –чээ зэрэг
- Тухайн хүний талаарх шууд бусаар олсон мэдээллийг оруулж бичихдээ “–даг⁴ байсан гэдэг”
- Зарим тохиолдолд бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн дагаврыг “томилогдсон, халагдсан” гэх мэтээр хэрэглэдэг.

Цаг хугацааны дарааллыг илтгэх олон арга байна. Үүнд:

- Тооны нэрээр: ... он, ... сар, ... өдөр, ... нас, ... жил
- Цагийн нэрээр: дараа нь, үүнээс хойш, хожим, өнөөдөр
- Дараалал заасан холбох үгээр : эхлээд, дараа нь, хойш
- Цагийн утгатай өгүүлбэрээр: Багадаа, сургуульд ороходоо, насанд хүрсний дараа

4. Зохиолчийн намтрыг уншаад, төрсөн сэтгэгдлээ бичээрэй.

Товч намтрыг дэлгэрүүлж бичье.

1. Дараах асуултын дагуу намтар бичих ойлголтоо нэгтгээрэй.
 - Намтарт тухайн хүний амьдралаас юуг заавал оруулан бичдэг вэ?
 - Тухайн хүнийг тодорхойлох ямар баримт оруулах шаардлагатай вэ?
 - Намтрыг ямар дарааллаар бичдэг вэ?
 - Бичигч өөрийн болон тухайн хүний бодол, хандлага, үнэлэлт дүгнэлтийг яаж бичдэг вэ?
2. Д.Нацагдоржийн намтрын товчоог, уншаад, дэлгэрүүлж бичнэ үү.



1906	Төрсөн.
Багадаа	Гэрийн боловсрол эзэмшсэн.
1921-1924	Цэргийн Яаманд бичээч, нарийн бичгийн дарга
1925	Бүх Монголын пионерийн товчооны дарга
1925-1926	ЗХУ-ын Ленинград хотод Улс төрийн академийн сонсогч
1926-1929	Германы Берлин, Лейпциг хотод оюутан
1929-1930	Төмрийн үйлдвэрт орчуулагч,
1930-1934	“Залуучуудын үнэн” сонинд утга зохиолын ажилтан
1931-1934	Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан
1934-1936	Мөн хүрээлэнд түүхийн ба дуун ухааны тасгийн эрхлэгч
1937	Төв театрт мэргэжлийн зохиолч
1937	Таалал төгссөн.

Д.Нацагдорж ЗХУ, Герман улсад хэдэн жил суралцаж, өрнөдийн соёлын шилдэг өв сантай гүнзгий танилцжээ.

Уран бүтээл

- “Ушаандар”, “Сандо амбаны харгис явдал” жүжиг,
- “Учиртай гурван толгой” дуурь,
- “Миний нутаг”, “Од”, “Октябрь” зэрэг олон арван шүлэг,
- “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс”, “Харанхуй хад”

ТОВЧ МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБООТОЙ БАРИМТААР ДЭЛГЭРҮҮЛБЭ

Алхам 1. Хэний намтрыг бичих вэ?

- Хэн хэний намтрыг бичиж болох талаар бодоод, нэг цаасан дээр жагсаан бичнэ үү. Энэ хүн олны танил алдартай хүн байж болно. Эсвэл та нарын гэр бүлийн гишүүд, хамаатан садан, найз нөхөд хэн ч байж болно. Ийнхүү сонгохдоо дараах асуултад хариулаарай.
 - Яагаад энэ хүнийг сонгов?
 - Энэ хүний талаар юу юу мэдэх билээ?
 - Энэ хүний талаар мэдээлэл олж авах ямар ямар эх сурвалжууд байна вэ?
- Эдгээр асуултыг эргэцүүлэн бодсоны дараа хэнийг нь бичихээ сонгоорой.

Алхам 2. Мэдээлэл цуглуулах - Мэдээллийг хаанаас эрж хайх вэ?

Намтрыг нь бичихээр сонгосон хүнийхээ талаар мэдээллийг дараах эх сурвалжаас эрж хайгаарай.




Алхам 3. Цуглуулсан мэдээллийг бүлэглэх, цэгцлэх

Намтрыг нь бичихээр сонгосон хүний талаар цуглуулсан мэдээллээ бүлэглэнэ.

- Төрсөн тухай мэдээлэл, түүнтэй холбогдох түүх, баримтууд (огноо, газар, хэний хэд дэх хүүхэд, гарал угсаа)
- Бага насны амьдралын түүх
- Гэр бүлийн байдал, түүнтэй холбоотой түүх (Гэртээ хэдүүл амьдардаг, тэд юу хийдэг гэх мэт)
- Эзэмшсэн боловсрол, мэргэжил
- Сонирхол, хүсэл мөрөөдөл
- Ажлын гараа, эрхэлсэн ажил, гаргасан амжилтын түүх
- Түүний талаарх бусдын үнэлэлт дүгнэлт
- Сонин содон мэдээлэл

Алхам 4. Бичих намтрыг төлөвлөх

Сонгосон хүнийхээ намтрыг бичих төлөвлөгөө гаргана. Намтар бичихэд эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй байна. Цуглуулсан мэдээллээс алийг нь эхлэл, гол, төгсгөл хэсэгт байрлуулахыг шийднэ. Чухал биш гэж үзсэн мэдээллийг үлдээж болно.



Алхам 5. Ноороглон бичих

Төлөвлөсний дагуу бичнэ. Гэхдээ гол хэсгийг бичихэд их анхаарах хэрэгтэй. Үүний тулд:

1. *Товч намтар бичнэ.* Товч намтрыг бичихдээ тухайн хүний төрснөөс эхлэн өнөөдрийг хүртэл тухайн хүний амьдралд тохиолдсон гол үйл явдал хэзээ болсныг товчоолж бичнэ.
2. *Товч намтрыг дэлгэрүүлж бичнэ.* Хэзээ?, хаана?, ямар?, хэд хэчнээн? гэсэн асуултаар дэлгэрүүлж бичээрэй. Бичихдээ зарим мэдээллийг шууд хуулж бичих бол заримыг нь засаж сайжруулан бичнэ. Намтар бичихэд тухайн хүний амьдралыг цаг хугацааны дарааллаар бичихийг чухалчилдаг гэдгийг анхаарна уу.

Алхам 5. Сайжруулах

Ноороглон бичсэнээ уншиж үзээд дараах шалгуураар үнэлээрэй. Дараа нь ангийн сурагчдадаа уншиж өгөөд, саналыг нь сонсож, тусгаарай.

- Төлөвлөсний дагуу бичсэн үү? Намтрын эхлэл, гол, төгсгөл хэсэг хоорондоо уялдаа холбоотой байна уу?
- Намтрыг цаг хугацааны дарааллаар бичсэн байна уу?
- Тухайн хүний онцлог байдал харагдаж байна уу?
- Намтарт сонгосон баримтууд оновчтой болж чадсан уу?
- Бичигч хүний санаа ялгарч байна уу?
- Санаагаа тодорхой оруулж чадсан байна уу?
- Зөв бичих дүрмийн алдаа, найруулгын алдаа байна уу? Ноороглосон эх дээр алдааг зассан тэмдэглэл хийгээрэй.

ЭХИЙН НАЙРУУЛГЫН АЛДААГ ТАНЬЖ, САЙЖРУУЛЪЯ

Нэгэн сурагчийн эмээгийнхээ тухай бичсэн намтрыг уншаарай. Намтрыг шинэ цаасан дээр хуулж бичихдээ алдаа мэдгийг засаж бичээрэй.

Миний элэнц эмээгийн намтар*Сурагчийн бичсэн эх*

Миний элэнц эмээг Навааны Энэбиш гэдэг. Эмээ маань 1936 зун Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Налих багийн нутагт ард Шууз, Дүгэр нарын охин болж төрсөн. Эмээгийн маань аав лам хүн байсан. 1937 онд хувьсгалын эсэргүү гэгдэн баригдаж, буудуулсан гэдэг. Ийм учраас эмээ маань өнөөг хүртэл нагац ах Наваанаар овоглож ирсэн.

Эмээ минь 1956 онд манай өвөөтэй гэр бүл болж, хоёр охин төрүүлж өсгөсөн. 1952 онд Барилгын түр курст сурч, барилгын техникч мэргэжил эзэмшсэн. 1961 онд МАХН-д элссэн.

1954-1956 онд Улаанбаатар хотын Барилгын зургийн институт, Баянхонгор аймгийн захиргаанд бичээч, 1960-1966 онд Дундговь аймгийн Барилга конторт техникч, 1966-1976 онд Өмнөговь аймгийн Барилга конторт намын үүрийн дарга, 1976-1986 онд Улаанбаатар хотын барилга трестэд техникч, хөдөлмөр хамгаалалтын байцаагчаар тус тус ажиллаж байсан.

Эмээгийн маань 30 гаруй жил барилгын салбарт үр дүнтэй ажиллаж хөдөлмөрлөснийг өндрөөр үнэлж, тав, зургаадугаар “Таван жилийн гавшгайч” цол тэмдэг, Ардын хувьсгалын 50, 60 жилийн ойн медаль, Барилгын Яамны хүндэт жуух бичгээр шагнасан байдаг. Эмээ маань 1985 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан. Тэтгэвэрт гараад эмээ маань зүгээр суугаагүй, арваад жил лангуу ажиллуулж, хувиараа хөдөлмөр эрхэлж байсан.

Манай эмээ “Миний аав Шууз лам хүн байсан. 1937 онд аав маань гэртээ намайг тэврээд сууж байхад буутай хоёр хүн ирж аваад явсан гэдэг. Би тэр үед ой гарантай байсан. Түүнээс хойш аав маань буцаж ирээгүй. Сүүлд сонсоход, тэр үед баригдсан хүмүүсийг аймгийн төвөөс хойш Баруунсайханы зүүн талд тэмээ шиг тууж авч яваад жалганд буудсан гэх яриа байдаг” гэж ярьсан юм. Эмээгийн маань хүсэл бол аавынхаа нэр төрийг сэргээлгэж, үр хүүхэд, ач зээ нартаа үнэн зөвөөр ойлгуулахыг хүсдэг.

Элэнц эмээ маань өнөөдөр үр хүүхэд, зээ, зээнцэр бидэнтэйгээ энх тунх амьдарч байна.

Н.Дөлгөөн

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

Аваргатай өдөр буюу Найдангийн Түвшинбаярын тухай

2008 оны наймдугаар сарын 14 дөтлөн гэрэлтсээр авай. Нуур ногоо хальсан, намрын энэ өдөр Монгол улс олимпын аваргатай болсон дэлхийн 92 дахь орон хэмээн бөмбөрцөг даяар цуурайлж байв.

Зуны спортын хорин ес дэх буюу “Бээжин-2008” олимпын жүдо бөхийн дэвжээн дээр Найдангийн Түвшинбаяр өвдөг шороодолгүй магнайлж олимпын анхны монгол аварга төрснөөр дээрх дуулианыг дэгдээсэн бөлгөө.

Монголчууд хүн төрөлхтний цэнгэлийн манлай олимпын дэвжээнд олон барилдсан, олон ялж байсан. Медаль авч байсан. Гэхдээ түрүүлж байсан нь үгүй. Ялагдалгүй, гагцхүү нэг ч ялагдалгүй босоо үлдэн түрүүлэх нь Чингисийн цусныхны, алтан хялгана долгилсон тал нутгийнхны бүхэл бүтэн чилийсэн дөчин дөрвөн жилийн хүлээлт, мөрөөдөл байлаа.

Тэрхүү их хүлээлтийн хэрмийг цууртал цахисан гялбаа, мөрөөдлийн цангааг тайлж асгарсан их аадар нь Булган аймгийн Сайхан сумын “унаган” Түвшинбаяр.

Сайхан уул өгүүлэх инү:

Наян дөрвөн оны зургадугаар сарын нэгний хүүхдийн баяраар шүү дээ. Хүүтэй боллоо гэж Найдан сумаас гэр рүүгээ бэлийн минь салхийг үймүүлэн давхиж байж билээ. Цэнд-Аюуш тэр хоёр их л бэлгэ дэмбэрэл бодож удалгүй хүүдээ Түвшинбаяр гэсэн сайхан нэр хайрласан даг. Тэр сумандаа дунд анги, аймгийн төвд аравдугаар ангиа дүүргээд л холын хотыг зорьсон доо. Тэр чинь 2002 оны намар.

Хулжийн гол өгүүлэх инү:

Даага, шүдлэнгийн “ам хагалж”, хөвөөгөөр минь үеийнхэнтэйгээ дарвин чавхдаж, ус үсчүүлэн намайг хөндлөн гулд гатчиж өссөн юм. Уснаас минь амсах гэж өвдөг сөхрөн тонгойдог юм.

Олимпын аваргын алтан медаль хүзүүндээ зүүх гэж тонгойж байгаа харагдсан. Ариун уснаас минь амсах, алтан медаль зүүх хоёрт л тонгойхоос бусдад гудайхгүй, эх орныхоо нэрийг ч тонгойлгохгүй сайн хүү.

Аав нь хэлэх инү:

Багын л миний хүү чинь их бага гэлтгүй орсон гарсантай ноцолдож явдаг хүү байв. Сургуульд байхдаа бодвол уншсан юм байгаа биз. “Халхын домогт Намхай аваргын үүзэл суухай мэхийг хийдэг бөх болно” гэж ярьдаг байсан юм.

Өгүүлэх нь:

2012 оны Лондонгийн олимпоор Н.Түвшинбаяр аварга бахтай сайхан барилдаж мөнгөн медаль хүртсэнээр олимпийн хос медальт анхны монгол болж суу алдраа дахин мандуулсан болой.

Ц.Галбадрах, Монголын цуут номоос

Унших даалгавар

1. Дараах үгсийн утгыг тайлбарлаарай.
 - Өвдөг шороодох
 - Магнайлах
 - Босоо үлдэх
 - Хүлээлтийн хэрэм
 - Хялгана
2. Түвшинбаярыг “Их хүлээлтийн хэрмийг цууртал цахисан гялбаа, мөрөөдлийн цангааг тайлж асгарсан их аадар” гэж яагаад дүрсэлсэн бэ?
3. Сайхан уул, Хулжийн гол Түвшинбаярын түүхийг ярьж буйгаар дүрсэлсэн нь ямар учиртайг тайлбарлаарай.
4. Намтраас гол мэдээллийг ялгаж, товчлоорой.
 - Төрсөн тухай мэдээлэл
 - Бага нас
 - Ерөнхий боловсрол
 - Сонирхол
 - Амжилт
5. Өөрсдийн уншсан, хамгийн дуртай зохиолынхоо нэг баатрыг сонгож, намтрыг нь бичээрэй. Намтар бичихэд шаардагдах мэдээлэл зохиолд байхгүй бол өөрсдөө нэмээд бичиж болно.
6. Дараах өгүүлбэрүүдийн найруулгыг засаж бичээрэй.
 - Долоо хоногийн хулгана өдөр бүр энэ ажлыг зохион байгуулна.
 - 12 дугаар сарын 22 нд идэр ес эхэлнэ.
 - Танай бусад хамтлагийн гишүүд чинь гэртээ харьчихсан юм уу?
 - Урилга борлогдоод дуусчихсан.
 - Одоогоор уг тамирчин маань 13 барилдахаас 8 ялж, 7 ялагдсан бөгөөд одоо 2 даваа үлджээ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

БИЧИГЧИЙН СЭТГЭЛИЙН ӨНГӨ АЯС

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах
- Хэлц ашиглан, мэдрэмж сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө дүрслэн бичих
- Баймж үг, бүтээврийг таньж, зөв хэрэглэх

ЗОХИОГЧИЙН СЭТГЭЛИЙН ӨНГӨ АЯСЫГ ТАЙЛБАРЛАЯ

Эхийн утгыг ойлгоё.

1. Эхийг уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.

1943 оны долоодугаар сарын 26. Даваа гараг

Хайрт Китти минь!

Өчигдөр ганц ч агшин тайван байсангүй. Бүгд л сэтгэл түгшиж өнжив. “Ингэхэд ер нь айж сандрахгүй өдөр гэж та нарт байна уу?” гэж чи гайхаж байна уу?

Дөнгөж цайгаа уух гээд сууцгаатал түгшүүрийн урьдчилсан дохио хангинаад явчихлаа. Энэ нь дайсны онгоц тэнгисийн эрэгт ойртож явааг дохиолох тул бид нэг их сандарсангүй. Миний толгой өвдөөд байхаар нь өглөөний цайны дараа хэсэг дугхийгээд дараа нь доош буув...

Цаг хоёр хагас болж байлаа. Биднийг дээш гараад таван минут болов уу үгүй юу, хүмүүс гадаа сандран бужигналдаж гарлаа. Бид ч бөмбөгдөлтөөс зугтан хонгил руу орж хоргодлоо. Байшин доргиж, дэргэд бөмбөг тэсрэх сонсогдов. Би ч “Зугтах хэрэг гарч магад” гээд ойр зуурын юм чихсэн цүнхэрхүү юмаа тэврэн суув. Гэвч бид зугтаад ч хаачих юм билээ. Гадаа гудамжинд гарах нь бөмбөгдөлтөөс долоон дор аюултай юм чинь. Бөмбөгдөлт өнгөрөөгөөд хагас цаг болсны дараа биднийг дээш гарахад “ИЕ” хэмээгч Амстердамын боомт зогсоолоос бөөн утаа олгойдон, уугьж харагдсанаа төдөлгүй түймрийн утааны үнэрээр солигдон, хот нэлдээ гүн хар утаанд умбав. Тийм их түймэр гэдэг сонирхоод баймаар юм биш аж.

Оройн хоолны үеэр бас л агаараас түгшүүр. Хоол үнэхээр сайхан байсан ч түгшүүрийн дохионы ёнгинооноос болоод юу ч хоолой давдаггүй. Дөчин таван минут хэртэй чимээгүй байснаа дахиад л агаараас эсэргүүцэх буунууд нижигнэн, сав суулга угааж дуусав уу, үгүй юү дахиад л түгшүүрийн дохио хангинаж, дээгүүр онгоцууд дүнгэнэж гарав. Бид тэгэхэд “Бурхан минь! Битгий л галзуурчхаж үзээсэй” гэж залбирч суулаа. Мэдээж залбирал өчүүхэн ч тус болсонгүй. Бөмбөг бороо шиг асган, англичуудын түрүүнд нь мэдээлж байснаар Амстердамын “Шипол” нисэх онгоцны буудал руу мөндөр мэт цутгав. Нисгэгчид онгоцтойгоо нэг шумбан, нэг хөөрөн нэг хэсэг шүршин буудалцах нь тэр чигээрээ тэнгэр буцлах мэт. Эгшин бүрд л “Тэдний нэг нь дээрээс уначих вий” гэж айхдаа зүрх дэлссэнийг хэлээд яахав. Орой 9 цагт хажуулахад бараг хоёр хөл дээрээ тогтож чадахааргүй ядарчихсан байснаа чамд хэлье.

Шөнө дөлөөр бас л сэргэж, 12 цагийн хэрд мөн л “Онгоц!” гэгцгээв. Эхний бөмбөгдөлтөөр л орноосоо огло үсэрсэн дээ. Хоёр цаг хэртэй онгоц дүнгэнэв. Тэгтэл буудалцаан ч зогсож өрөө рүүгээ буцах болов. Хоёр хагас хэртэйд унтах санаатай хажуулав.

Өглөөний долоон цаг болж байв. Бас л чимээ гарахаар нь айж сандран аав дээр очвол Даан гуай ирчихсэн сууна. Даан гуай өчнөөн сарын турш сонсоогүй чихэнд чимэгтэй мэдээ хэлэх гэж явсан юмсанж. Муссолини огцорч, Италийн ван дахин засгийн эрхийг авч гэнэ. Бид хөөрөн баярлацгаав. Өчигдрөөс эхлэн үнхэлцгээ хагартал айж сандарсны дараа ингэж сайхан мэдээ сонсож, амьдрах итгэл олж авах гэж! Муу юм цаашилж, сайн юм наашлах зөн шүү!

Дараа шөнө бас л түгшүүрийн дохио, дахиад л онгоцны дүнгэнээн. Түгшүүрийн дохионоос сэтгэл хямран унтаж ч, ажиллаж ч чадахгүй боллоо. Харин “Муу юм төгсөнө” гэсэн итгэл л биднийг зоригжуулна гэж горьдож байна даа.

Анне Франкийн өдрийн тэмдэглэл, 2011

2. Сайн мэдэхгүй үгийнхээ утгыг хам сэдвийн хүрээнд таамаглан тайлбарлаарай.

Тайлбарлах үг	Таамагласан утга	Шалтгаан
агшин	хугацаа заасан үг байх	нэг ч... тайван байсангүй гэсэн үгтэй холбогдож байгаа тул

3. Эхийн сэдэв, утга санааг ойлгоорой.

- Энэ тэмдэглэлд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Дайны үеийн нөхцөл байдлыг дүрсэлсэн хэсгийг ялгаж бичээрэй
- Дайны үеийн нөхцөл байдлыг дүрслэхэд чухал үүрэгтэй түлхүүр үгсийн доогуур зураарай.
- Зурсан үгсээ ашиглан тулгуур бичиглэл хийж, эхийн гол санааг дүгнээрэй.

Өдрийн тэмдэглэлийн бүтэц, үйл явдлын дарааллыг шинжилье.

1. Өдрийн тэмдэглэлийн бүтцийн тухай өмнөх ангид үзсэнээ сэргээн ярилцаад, дараах ойлголтыг гүйцээж бичнэ үү.

Өдрийн тэмдэглэлд болсон үйл явдлыг цагт бичнэ. Харин өөрийн сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөл, үнэлгээ дүгнэлт зэргийг цагт бичнэ. Өөрийн бодол сэтгэгдэл, өөрт тохиолдсон явдлаа бичиж байгаа учраас “би, надад, миний” гэх мэт ашиглан, биеэс бичнэ. Бүтцийн хувьд эхлэл,, –тэй байна.

2. Аннегийн өдрийн тэмдэглэлийн бүтэц, дарааллыг дараах шалгуураар батлан тайлбарлаарай.

Бүтцийг шалгая.

- Эхлэл хэсэгт огноо, тухайн өдрийн нөхцөл байдлыг бичсэн
- Гол хэсэгт онцлох үйл явдлыг нүдэнд харагдтал дүрсэлсэн
- Таван мэдрэхүйгээр мэдэрснээ бичсэн
- Сэтгэл хөдлөл, сэтгэгдлээ илэрхийлсэн
- Төгсгөл хэсэгт дүгнэлт, зорилгоо бичсэн

Хэлийг судалъя.

- Нэгдүгээр биеэс бичсэн
- Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн
- Өнгөрсөн цагийн нөхцөлөөр өгүүлбэрийг төгсгөсөн
- Бичигчийн хандлага, сэтгэлийн өнгө аяс илэрсэн

Бичигчийн сэтгэл хөдлөлийг тодорхойлъё.

1. Аннегийн сэтгэл хөдлөлийг илрүүлэхдээ доорх загварын дагуу ажиллаарай.

Цаг хугацааны дараалал	Сэтгэл санааны байдал	Нотолгоо	Дүгнэлт
Өглөө	тайвандуу	... нэг их сандарсангүй, толгой өвдөөд байхаар нь хэсэг дугхийгээд	Аннегийн сэтгэл санаа нэг л таагүй, тогтворгүй хэвийн бус байна.
	хямралтай		
Өдөр	түгшүүртэй	зугтах хэрэг гарч магад гээд, цүнхэрхүү юмаа тэврэн, гэвч зугтаад ч хаачих юм билээ.	
	залхсан аргаа барсан		
Орой

- а. Сэтгэл санааны байдал гэсэн багана дахь үгсийг ажиглаарай.
- б. Сэтгэл хөдлөлийг тодорхойлоход ямар асуултад хариулагдах үг ихэвчлэн хэрэглэгдэж байна вэ? Жишээгээр батлан тайлбарлаарай.

2. Дараах 2 эгнээ үгсийн утгыг тайлбарлаарай.

- а. Нэмэлт утга илэрхийлж байгаа үг, бүтээврийг тодруулж будаарай.
 - 1. ганц **ч**, би **ч**, бүгд **л**, бид **ч**, зугтаад **ч**, бас **л**, юу **ч**, дахиад **л**, эгшин бүрд **л**, мөн **л**, бас **л**, буудалцаан **ч**, бөмбөгдөлтөөр **л**, бас **л**, дахиад **л**, унтаж **ч**, ажиллаж **ч** чадахгүй, итгэл **л**, огло үсэрсэн дээ, горьдож байна даа, дуусав уу, үгүй юу, уначих вий, хэлээд яах вэ
 - 2. тийм **их**, **гүн** хар, **бөөн** утаа, тэр чигээрээ, нэлдээ, хоол **үнэхээр** сайхан **ч**, өчнөөн сарын турш сонсоогүй
- б. Тодруулсан үг бүтээврийг хасаж уншаарай. Утгад ямар өөрчлөлт гарч байгааг ярилцаарай.
- в. Эдгээр нэмэлт утга илэрхийлж буй үг, бүтээврүүд Аннегийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд нөлөөлж байна уу? Тайлбарлаарай.

3. Дараах өгүүлбэрт байгаа цэг тэмдгийг ажиглаарай.


- Өчигдөр ганц ч агшин тайван байсангүй. Бүгд л сэтгэл түгшиж өнжив.
- “Ингэхэд ер нь айж сандрахгүй өдөр гэж та нарт байна уу” гэж чи гайхаж байна уу?
- Бурхан минь! Битгий л галзуурчхаж үзээсэй.
- Өчигдрөөс эхлэн үнхэлцгээ хагартал айж сандарсны дараа ингэж сайхан мэдээ сонсож, амьдрах итгэл олж авах гэж! Муу юм цаашилж, сайн юм наашлах зөн шүү!

- Эдгээр тэмдгүүд Аннегийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд нөлөөлж байна уу? Тайлбарлаарай.

Бичигчийн хийсэн үйлдлийг шинжилье.

1. Дараах бүдүүвчийг ажиглаад, дүгнэлт бичээрэй.

- а. Аннегийн сэтгэл хөдлөл бүрийн үед хийсэн үйлдэл хөдөлгөөнийг эхээс олоорой.
- б. Хүний үйлдлээс болж сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөлөөс болж үйлдэл өөрчлөгдөж болох уу? Учрыг жишээгээр батлан тайлбарлаарай.
- в. Сэтгэл хөдлөл, үйлдэл хоёрын холбоо хамаарлыг чи хэрхэн ойлгож байна вэ?



г. Үйлдэл хөдөлгөөнийг ямар аймгийн үгээр илэрхийлж байна вэ? Ярилцаарай.

Бичигчийн мэдрэмж, сэтгэгдлийг тодорхойлъё.

1. Анне дайны үеийн дуу чимээ, дүр байдлыг яаж мэдэрснийг дараах зураглалын дагуу эхээс ялган бичнэ үү.

Дохио хангинаад, -----

Хүмүүс сандран бужигналдаж, утаа уугьж, -----

Байшин доргиж, -----

2. Мэдрэмж гэж юу юм бол? Бодлоо хуваалцаарай.

Биед мэдрэгдсэн зүйл+Сэтгэлд хүртэгдсэн зүйл=Мэдрэмж


3. Аннегийн мэдрэмжээ илэрхийлсэн бас нэг арга нь юу болохыг ярилцаарай.

Бөмбөг мөндөр мэт
цутгах

Буудалцах нь тэнгэр
буцлах мэт

Бөмбөг бороо шиг асгах

4. Үгийн сүлжээг бөглөөрэй.



Хөндлөнгөөр

Аннегийн мэдрэмжийг
илэрхийлсэн хэлцийг доор
харуулав. Эдгээр хэлцийн
ойролцоо утгат хэлцийг эхээс
олж нөхөөрэй.

1. Чих баярламаар
2. Гол харлах
3. Нүдний хор гаргах
4. Сүнс зайлах
5. Цааш орохгүй
6. Зүрх чичрэх
7. Шургаж унах шахах

Босоогоор

Аннегийн бодол сэтгэгдлийг доор
үзүүлэв. Өгүүлбэр тус бүрээс түүний
сэтгэл хөдлөлийг тодорхойлж
бичээрэй.

1. Бурхан минь! Битгий л галзуурчхаж
үзээсэй.
2. Харин муу юм төгсөнө.
3. ... ингэж сайхан мэдээ сонсож,
амьдрах итгэл олж авах гэж!
4. Тийм их түймэр гэдэг сонирхоод
баймаар юм биш аж.
5. Өчигдөр ганц ч агшин тайван
байсангүй.
6. Гудамжинд гарах нь бөмбөгдөлтөөс
долоон дор аюултай юм чинь.

5. Мэдрэмж, сэтгэгдлийн ялгааг ярилцаж, ойлголтоо нэгтгээрэй.
- Чиний бодлоор мэдрэмж, сэтгэгдэл гэж юу вэ?
 - Ямар ижил тал байна вэ?
 - Мэдрэмж хаана үүсэж, сэтгэгдэл хаана бий болж байна вэ?
 - Мэдрэмж, сэтгэгдлийг ямар үгээр илэрхийлж болохоор байна вэ?

Бичигчийн хандлага, сэтгэлийн өнгө аясыг дүгнэе.

1. Ойлголтоо нэгтгэн дүгнээрэй.

а. Аннегийн сэтгэл хөдлөл, үйлдэл, сэтгэгдэл, мэдрэмжийг тодорхойлсон дасгалуудаа дахин хараад, доорх хүснэгтийг гүйцээгээрэй.

Аннегийн өгүүлж байгаа юм: Дайн байлдаан			
Сэтгэл хөдлөл	Үйлдэл	Мэдрэмж	Сэтгэгдэл
Айдас түгшүүртэй
.....
.....
.....

Сэтгэлийн өнгө аяс : Дайнаас болоод түүний бие сэтгэл нь тун таагүй байгаа ч “Муу юм (дайн) төгсөнө” гэдэгт итгэж, горьдлого тээсээр байжээ.

б. Сэтгэлийн өнгө аяс, хандлагыг илэрхийлэхэд ямар утгатай үгийг хэрэглэж байна вэ? Хүснэгтийг гүйцээгээрэй.

Сэтгэлийн өнгө аяс, хандлага		Илэрхийлсэн үг, хэллэг цэг тэмдэг	Жишээ
Бичигчийн	сэтгэл хөдлөл	Тэмдэг нэр	Жаргалтай, амгалан тайван, уйтгартай
		Үйл үг
	үйлдэл
	
	
мэдрэмж, сэтгэгдэл	Нэмэлт утга илэрхийлсэн үг	

в. Тодорхойлолтыг гүйцээж, хэрхэн ойлгосноо шалгаарай.

- Үйл явдал, хүн, юм, үзэгдлийн талаарх хувь хүний таатай болон таагүй сэтгэгдэл,,, ерөнхий чигийг хандлага гэнэ.
- Бичигчээс өгүүлж байгаа зүйлдээ хандах өнгө аяс гэнэ.

ХЭЛЦ АШИГЛАН, МЭДРЭМЖ СЭТГЭГДЛЭЭ ДҮРСЛЭН БИЧЬЕ

Өдрийн тэмдэглэл бичихийн ач тусыг ойлгоё.

1. Дараах бүдүүвчийг ажиглаад, ач холбогдол тус бүрийг тайлбарлаарай.

Сэтгэл хөдлөлөө
гүнзгий мэдэрнэ.

Хувьсал өөрчлөлтөө мэдэрнэ.

Сэтгэлийн өнгө аяс,
хандлагаа илэрхийлж сурна.

Хойч үедээ өөрийн амьдралын
туршлагаа өвлүүлнэ.

Сэтгэлгээгээ хөгжүүлнэ.

Дурсамжаа сэргээнэ.

2. Та нар өдрийн тэмдэглэл бичдэг үү? Ямар зорилгоор бичдэг вэ? Энэ тухай бусадтайгаа хуваалцаарай.

Өдрийн тэмдэглэл бичье.

1. Өдрийн тэмдэглэл бичихдээ дараах алхмын дагуу ажиллана уу.
а. Бичих сэдвээ сонгоорой.

Өөрт тохиолдсон онцгой содон үйл явдлаа жагсаан бич. Түүнээсээ хамгийн тодоор сэтгэлд үлдсэн үйл явдлыг сонгоорой.

Дараах сэдвээс санаа авч болно.

- Хичээл, сургууль дээр болсон сонирхолтой үйл явдал
- Сэтгэлд хоногшсон баярт үйл явдал
- Өөрт тохиолдсон хөгтэй явдал
- Амралтын үеэ хэрхэн өнгөрөөсөн тухай

Сэдвээ сонгохдоо дараах асуултыг өөрөөсөө асууж, хариулаарай. Энэ бүх асуултад хариулагдахаар мэдээлэл байгаа бол дараагийн алхам руу шилжинэ үү.

- Хэзээ ямар өдөр байсан бэ?
- Юу хийхийг хүсэж байсан бэ?
- Ямар үйл явдал тохиолдсон бэ?
- Тухайн үйл явдлаас юуг мэдэрсэн бэ?
- Ямар бодол сэтгэгдэл төрсөн бэ?
- Тухайн өдөр юуг сурч мэдэж, ухаарсан бэ?


б. Бичих төлөвлөгөө гаргаарай. Сонгосон сэдвийн хүрээнд үйл явдал, сэтгэл хөдлөл, мэдрэмж, сэтгэгдлээ товч жагсаан бичнэ үү. Наадаг цаас ашиглаж болно. Үлгэрлэвэл:

Эхлэл хэсэг
Огноо: 2012 оны 9-р сарын 1. **Цаг агаар:** Дулаан, тогтуун, сэрүүн
Үйл явдал болсон газрын нөхцөл байдал: хөөр баяраар дүүрэн, цагаан цэнхэр өнгөөр жигдэрсэн олон хүүхэд цугларсан, цэцэг навч алаглаж, хөгжим эгшиглэсэн газар


<p>Сэтгэл хөдлөл</p> <ul style="list-style-type: none"> • Хөөрч догдолсон • Цовоо цолгиун <p>-----</p> <p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>	<p>Гол хэсэгт (үйл явдлын дараалал)</p> <p>Хичээлийн нээлт. -----</p> <p>Анхны хичээл-----</p> <p>Завсарлагаа -----</p> <p>-----</p> <p>Сэтгэгдэл</p> <p>Олон найзтай болох -----</p> <p>Багш шигээ гоё бичих -----</p>	<p>Мэдрэмж</p> <ul style="list-style-type: none"> • Зүрх түг түг цохилсон, • Жихүүдэс хүрээд байгаа юм шиг----- <p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>
--	---	---

<p>Мэдрэмж</p> <p>Хөл газар хүрэхгүй -----</p> <p>-----</p>	<p>Төгсгөл хэсэг</p> <p>-----</p> <p>-----</p>	<p>Сэтгэгдэл</p> <p>Аав ээжээ баярлуулах -----</p> <p>-----</p>
--	---	--


в. Сэтгэл хөдлөлөө тодорхой илэрхийлэхийн тулд дараах бүдүүвч дэх үгсээс ашиглаарай.



г. Төлөвлөгөөний дагуу ноороглохдоо дараах алхмын дагуу ажиллаарай.



д. Бичсэнээ сайжруулаарай. Дараах зөвлөмжийн дагуу ажиллана уу.



е. Сэтгэл хөдлөл, мэдрэмж илэрхийлсэн зарим үгээ утга тохирох хэлц үгээр солин найруулаарай.

- Өөрийн сэтгэл хөдлөлтэй холбоотой хэлц бүхий хэсгийг тэмдэглээрэй.
- Тухайн сэтгэл хөдлөлтэй холбоотой хэлц үгсийн утгыг таамаглах, толь бичиг ашиглах, бусдаас асуух зэргээр мэдээрэй.
- Хэлцүүдээс аль нь мэдрэмж илэрхийлсэн, аль нь сэтгэл хөдлөл илэрхийлсэн байна вэ? гэдгийг сайн бод. Бусдаас асуугаарай.
- Эхэд байгаа үгээ (\neg) тэмдэг ашиглан, хэлцээр сольж бичээрэй.

Баяр хөөртэй	хөл газар хүрэхгүй, магнай тэнийх, элэг авах, аз шовойх, аз гозолзох, азын тэнгэр гийх, алга загатнах, ам тосдох, амны хишигтэй, баярын нар гарах, гуяа алгадах, дуу шуутай болох, зүрх булгилах, зүрхэнд асах, нар барих, нүүр дүүрэн, тэнгэрээс од шүүрэх, хөл дэгдэх, хөл хөнгөрөх, хөл хөөрцөг болох, царай өгөх, цээж дүүрэн, инээд ханиад болох, сэтгэлд хур буух
Тайван амгалан	өр нимгэн, чих зөөлөнтэй, зүү орох зайгүй, сүү шиг сэтгэлтэй, хайлсан тугалга шиг, айдгийгаа авдартаа хийх, алтан аяганаас ус уух, амьсгаа авах, бүдүүн өвс багтамгүй, зоо тэнийх, наашаа элэгтэй, нүүр тал өгөх, хэлсэн үгэндээ эзэн болох, чих амар болох, чих зөөлөн, цээж тэнийх, цээж уужрах, эв нь таарсан мод шиг, элэг дэвтэх, элэг нимгэн, яс амрах
Аз жаргалтай	од гялалзах, шавай ханах, сэтгэл дүүрэн, сэтгэл онгойх, зовхи өөдөө амьтан, ихийн шийр барих, нүд уран болох, нүүр баатар, хүй бөхтэй, тосонд умбаж, торгонд хөлбөрөх, элэг бүтэн, элэг зүрхний угаас
Айдас түгшүүртэй	сэтгэл хирдхийх, дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу, сүнс зайлах, нуруугаар хүйт даах, зүрх чичрэх, ааг амьсгаагүй, зүрхээ авхуулах, адис хүртэх, адсага шиг талхигдаж, адуу шиг унгалдах, айсан хүн адуу туух, нүд үзүүрлэгдэх, зүрх алдах, санаа алдах, алийг нь алдуулах, амьтан болох, аргаа барах, арга тасрах, ацан шалаанд орох, бор зүрх бол бол хийж, богино хавирга шир шир хийх, толгойн үс босох, сүүдрээсээ айх
Уйтгар гунигтай	сэтгэл гундуу, сэтгэл шимшрэх, элэг эмтрэх, сэтгэл хоосрох, зүрх шимшрэх, гол гонсойх, азын тэнгэр буруулах, аманд орсон шар тосыг хэлээрээ түлхэх, бялзуухай зүрхтэй, гол зурах, гол өөд хүйт оргих, толгой ганзагалах, гуяа тэврэх, дотор харлах, дээлтэйгээ хатах, шар махтайгаа хатах, зүрх өвдөх, мөс залгисан юм шиг мөлийх, нурам царайлах, нүд хуурайгүй, өнчин хайлаас шиг, саднаасаа салж саруулаасаа төөрөх, толгой гудайх, дуугаа хураах, хөлс чийхрах, уруу царайлах
Ууртай ширүүн	аагаа багтааж ядах, уур буцлах, цөс ихтэй, бууж алдах, дээлэндээ багтахгүй байх, аянга буулгах, нударга буулгах, галзуурахад ганц хуруу дутах, довтлох шонхрын нүд гаргах, дотор буцлах, царай борлуулах, өвчүү дэлдэх, хор шар буцлах, хорхойд жад барих, хөмсөг зангидах, хөмхий зуух, цөс нь хавиргаа дэлсэх, шар хөөрөх

ё. Бичсэнээ сольж уншаад, дараах шалгуураар үнэлж, санал зөвлөгөө аваарай.

Шалгуур	Өөрийн үнэлгээ	Найзын үнэлгээ	Багшийн үнэлгээ
Бүтэц болон дарааллаа зөв гаргах	☺ ☹ ☹		
Үйл явдал, орон цагийг тодорхой дүрслэх			
Бодол сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх			
Хэлц үг оруулсан байх			
Сэтгэлийн өнгө аяс, хандлага нь тодорхой илрэх			

- ж. Санал зөвлөгөөний дагуу дахин сайжруулаарай.
 з. Засаж сайжруулснаа дэвтэртээ сийрүүлэн бичээрэй.

БАЙМЖ ҮГ, БҮТЭЭВРИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭЭ

Эхийн утгыг ойлгоё.

1. Утгыг нь мэдэхгүй үгийг тэмдэглэж уншаарай.

1942 оны зургаадугаар сарын 14. Ням гараг

Би баасан гарагийн өглөө зургаан цагт сэрэв. Төрсөн өдөр минь байсан болохоор эрт сэрэлгүй яахав. Долоо болгоод аав ээжтэйгээ төрсөн өдрийн бэлгийг хамтдаа задлахаар зочдын өрөөнд оров. Тэгэхэд л би тэмдэглэлийн дэвтэр чамайгаа эхэлж харсан шүү дээ. Миний төрсөн өдрийн хамгийн сайхан бэлэг л чи минь байлаа...

Тэмдэглэлийн дэвтэр чамтай болсондоо хязгааргүй баяртай байна.

1943 оны арваннэгдүгээр сарын 11. Пүрэв гараг

Хамгийн үнэтэй эд зүйл юу вэ гэвэл миний хувьд үзэг минь л байв. Үрлэн хошуутай үзгээ би маш их хайрладаг. Учир нь би ийм сонин үзгээр л арай гайгүй бичдэг.

Тэр маань бас нэлээн намтартай. Есөн настайдаа хөвөнд нямбайлан ороосон боодолтой үзэг минь надтай учран золгосон юм. Тэр үед Аахин хотод байдаг хайрт эмээ минь харамгүй сэтгэлээр энэ үзгийг надад бэлэглэсэн юм даа. Арав хүрэхэд минь аав, ээж хоёр тэр гоё үзгээ сургуульдаа авч явахыг зөвшөөрч, багш маань "Түүгээр хичээлээ бичиж болно" гэв. Дараагийнх нь жилээс энэ эрдэнээ би гэртээ орхиж явах болсон. Дараа нь арван хоёр хүрч, еврейчүүдийн гимназид орохдоо үзгэндээ зориулж харандаатай хамтад нь авч явах цахилгаантай шинэ гэр авсан. Арван гурав хүрэхэд үзэг минь надтайгаа хамт энд бүгж, намайг чамтай хэл залгуулахад шударгаар зүтгэж, зогсоо завгүй ажиллаж эхэлсэн. Тэгээд арван дөрөвтэйд минь надтай сүүлчийн жилээ өнгөрөөсөн минь энэ...

Тав дөчин тавд би шалаа шүүрдэж, шалны давирхайдсан хүрэн тосны үлдэгдлийг хогтой хамт пийшинд хийв. Би ширээндээ сууж юм бичихээр болов. Гэтэл үзэг минь олддоггүй. Би нэлээн ултай эрэлд гарав. Маргот тусаллаа. Ээж ч эрэлцлээ. Аав, Дуссел эмч хоёр ч бас эрэлцэв. Миний үнэнч анд болсон үзэг минь ул мөргүй алга болжээ. Шөнө болтол эрээд олоогүй болохоор тэр лав галд оржээ. Маргааш өглөө нь аав үзэгний минь сэгийг үнсэн дундаас олж тэр эмгэнэлт явдлыг нотоллоо. Алтанхан үзэгнээс минь өрөвдмөөр өчүүхэн юм үлджээ. Аав "Ихэнх нь хайлчихсан байна" гэв. Үзэг минь чандарлуулжээ...

Анне



Асар богинохон хугацаанд утга төгөлдөр амьдарч болохыг харуулж чадсан охин бол 15 насандаа нацист Германы хорих лагерьт нас барсан Анне Франк хэмээх еврей охин юм. Түүний бичиж үлдээсэн өдрийн тэмдэглэл нь фашизмын гамшиг, дэлхийн хоёрдугаар дайны үеэр еврейчүүдийн туулсан зовлон, амьдрах хүсэл тэмүүллийн гайхамшигт гэрч болон үлджээ.

2. Дараах асуултад хариулж, эхийн утгыг ярилцаарай.

- Аннегийн төрсөн өдөр хэзээ вэ? Ямар бэлэг авсан бэ?
- Анне дээрх тэмдэглэлүүддээ юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Аннегийн үзэгний түүхийг дараах хүснэгтэд нөхөөрэй.

Цагийн дараалал	9 настайдаа	10 настайдаа	11 настайдаа	12 настайдаа	13 настайдаа	14 настайдаа
Үзэгний түүх	Эмээ нь бэлэглэсэн.					


3. Эхийн утга санааг өөрийн амьдралтай холбон яриарай.

- Чиний авч байсан хамгийн гоё бэлэг юу вэ?
- Тэр одоо чамд байгаа юу? Байгаа бол яаж хайрладаг вэ?
- Яагаад тэр чамд тийм эрхэм байдаг вэ?

Баймж үг, бүтээврийн утга, үүргийг мэдье.

1. Дараах бүдүүвчийг гүйцээгээрэй.

- Аннегийн сэтгэл хөдлөлийг тодорхойлно уу.
- Аннегийн сэтгэл хөдлөлийг илүү тодорхой болгож буй үгсийг эхээс олж бичээд, тодруулж будаарай.



2. Тодруулсан үг, бүтээврээ өгүүлбэрээс хасаж уншаарай.
 - Өгүүлбэрийн утгад ямар өөрчлөлт гарч байна вэ?
 - Эх, өгүүлбэрийн утгад ямар үүрэгтэй гэж дүгнэж байна вэ?
3. Дараах онолын ойлголтыг уншаад, дэвтэртээ тэмдэглэж аваарай.

Өгүүлэгчийн харилцах орчин, нөхцөл байдал, зорилгоос хамаараад сэтгэлийн өнгө аяс, хандлага нь өөр өөр байдаг. Энэ хүсэл, сэтгэгдэл, хандлагыг илтгэсэн үг, бүтээврийг баймж гэнэ. Энэ нь өгүүлбэрт нэмэлт утга оруулдаг.

Баймж, үг бүтээврийг таньж, зөв хэрэглэе.

1. Аннегийн тэмдэглэлээс дараах утгад тохирох баймжийг олж бичээрэй.
 - Онцолж лавшруулсан:
 - Дурсан санасан:
 - Эрчимжүүлсэн:
 - Баталж нотолсон:
2. Дараах өгүүлбэрийн өнгө аясыг өөрчилж бичээрэй.
Хайрт эмээ минь энэ үзгийг надад бэлэглэсэн юм.

Өнгө аяс	Өгүүлбэр
Дурсан санасан	Хайрт эмээ минь энэ үзгийг надад бэлэглэж байсан юм даа.
Баталж нотолсон
Таамагласан
Лавшруулсан
Эргэлзсэн
Хүссэн

3. Дараах баймж, үг бүтээврээс сонгон, 10 өгүүлбэр зохиогоорой.
4. Бусдадаа уншиж үзүүлээрэй. Өнгө аясыг дууныхаа өнгөөр ялгаж харуулна уу.

үнэндээ, нээрээ, мөн, мэдээж, чухам, ер нь, угаасаа, яав ч, зайлбаргүй, гарцаагүй, өөрийн эрхгүй, -маар, ёсгүй, -лгүй яахав, -мхай, -аач, -х сөгөөгүй, ядахдаа, л, ч, эс, нэг л биш, гэж үү, ямар бол доо, -х байлгүй, -схий, шүү, дээ, вий, шив, ч, -мсаг, -х санаатай, -ууштай, даг, бүү, ашгүй, тэгэхээс дээ, арга байж уу дээ, -чихтай болох, -нцар, -гчаа аядах, -рхуу

5. Өмнөх үгээс нь тусдаа бичдэг баймж үг, бүтээврийн зөв бичих дүрмийг багштайгаа хамтран судалж, дүрмийн лавлах хийгээрэй.

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ



Жүгдэрдэмидийн Гүррагчаа нь Монгол Улсаас сансарт ниссэн анхны, дэлхийн 101 дэх, Ази тивийн хоёр дахь хүн юм. Гүррагчаа 1947 онд Булган аймгийн Гурванбулаг суманд Жүгдэрдэмидийн том хүү болон төржээ.

1981 оны 3-р сарын 22-нд Байконурын сансрын буудлаас ЗХУ-ын сансрын нисэгч Владимир Жанибековын хамт “Союз-39” хөлгөөр сансарт хөөрчээ. Тэд сансарт 7 хоног, 20 цаг 42 минутыг өнгөрүүлж, дэлхийг 124 удаа тойрсны дараа эх дэлхийдээ амжилттай газарджээ.

1. Сансрын нисэгч Ж.Гүррагчаагийн өдрийн тэмдэглэлийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

1981 оны гуравдугаар сарын 22. Бүтэн сайн өдөр

... Москвагийн цагаар 17 цаг 58 минут 59 секундэд “Союз-39” хөлөг хөөрлөө. Тойрог замд ортол 360 орчим секундын хугацаа байлаа... Сансрын хөлөг тойрог замд орж, бие даасан нислэг эхэллээ. Энэ үед бид номхон дөлгөөн далай дээгүүр гарч, мандах нар биднийг угтлаа. Шинэ орчинд, шинэ өдөртэй золголоо. Монголчуудын түүхэнд ч бас нэг багаахан шиг шинэ хуудас нээгдлээ...

Сансрын хөлөг маань секундэд 8 километр замыг туулсаар дэлхийг тойрч явна. Наян хэдхэн минутад дэлхийг тойрно гэдэг үнэхээр санаанд багтамгүй. “Хүний ухаан хүрсэн газарт гар нь хүрнэ” гэж манай настнуудын ярьдаг ортой ажээ. Нүдэнд харагдах түмэн одны 88 орд дундуур, тэнгэрийн цагаан зүйдлийг огтлон гялбалзах одон хөлгийн жолоо барилцаад явж байхад юутай бахархалтай. Дөчин таван минутын дараа үүр цайж эхлэх нь тэр. Хөлөг маань өдөр шөнийн заагийг давангуут газрын хяргийн улаан шаргал өнгө шингэн цэнхэр өнгөөр солигдлоо. Үүнийг хараад л “Цэнхэрхэн дэлхий минь” гэж уулга алдаж билээ.

1981 оны гуравдугаар сарын 24.

Станцын таазанд ор засаж өглөө. Хэвийн сайн унтаж хонолоо. Шөнийн цагаар нуруу өвдөхийг эс тооцвол бие маань сайн байна.

Өглөө 8 цагт босож, ажлын өдөр эхэллээ. Анх цонхоор харсныг бодвол газар дээрх зүйлсийг ялгах нь дээрдэж байна. Газар дэлхий маань гайхам үзэсгэлэнтэй харагдах юм аа. Аргагүй л хайр, бахдал төрмөөр. “Уяхан замбуутив” гэж монголчууд яаж онож хэлэв ээ. Өвөг дээдэс маань урд нь арай сансраас эх дэлхийгээ харж байсан юм биш байгаа даа. Харсан хүн л ингэж хэлж чадах байх гэсэн бодол үргэлж төрж байлаа.

Ер нь хүмүүсийг л биширч явлаа даа. Хүний оюун ухаан гэдэг ямар аугаа их хүч чадал вэ?! Тэр л оюун ухаанаар бүтсэн сансрын хөлөг, багаж хэрэглэлийн тусламжтайгаар эх дэлхийгээ харах боломж бидэнд олдлоо. Дэлхийн хоймор гэмээр тэр л тэгш хавтгай монголчуудад заяагджээ. Төвөдийн “Платформа” гэж нэрлэгддэг аяганы ширээ шиг өндөрлөг байх юм. Түүнээс цааш үргэжлүүлэн нэг хэсэг зай өнгөрсний дараа Монголын өргөн тал нутаг гэрийн хоймор мэт харагдана.



Сансраас харахад улс орны хил хязгаар гэж байх биш дээ. Байгал нуур, Далай нуур, Алтайн уулсын хооронд манай нутаг багтаж харагдах юм. Хаанаас ч тодорч харагдах баримжаа бол Хөвсгөл нуур, Их нууруудын хотгор, Алтайн цуваа уулс, Буйр нуур юм.

Зөвхөн дэлхийн гадаргууг ажиглаад зогсохгүй, сансрын удам гэдэг өөрөө их олон сонин үзэгдлүүдээр баян юм. Бас нар, сар, од гараг гээд... Газар дээрх зүйлс нарны

байрлалаас шалтгаалж янз бүрээр харагдах юм. Нар мандах, шингэх гээд хараад хараад ханашгүй олон үзэгдлүүд байна...

Х.Цэвэлээ, Сэтгэлийн өчил, 2004

1. Эхийн утга бүтцийг тодорхойлоорой.
 - Дээрх эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - Сансарт нисэж байгаа үеийн нөхцөл байдлыг дүрсэлсэн хэсгийг ялган уншаад:
 - Чамд юу төсөөлөгдөж байна?
 - Ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байгаагаа бичээрэй.
 - Эхээс түлхүүр үгсийг олоод, тулгуур бичиглэл хийгээрэй.
 - Тулгуур бичиглэлээ ашиглан эхийн гол санааг дүгнээрэй.
2. Бичигчийн хандлага, сэтгэлийн өнгө аясыг тодорхойлоорой.
 - Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг, хэллэг, дүрслэлийг олоорой.
 - Гүррагчаагийн сэтгэл санааны байдлыг дүгнээрэй.
 - Бичигчийн сансарт нисэж байх үеийн мэдрэмж, сэтгэгдлийг ялгаад бичигчийг сэтгэлийн өнгө аясыг тодорхойлоорой.
3. Дараах сэдвээс сонгон, сэтгэлийн өнгө аяс, мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй.
 - Үзсэн кино, уншсан ном, өөрт тохиолдсон явдал, өнөөгийн байгаль, нийгмийн өөрчлөлтөөс санаа авч зөгнөлт тэмдэглэл бичих
 - Амьдралдаа тохиолдсон хамгийн сэтгэлд үлдсэн үйл явдлаа дурсан бичих
 - Бага насандаа тоглодог байсан тоглоом, тэжээдэг амьтан, уншиж байсан ном, эсвэл хийх дуртай зүйл чинь чамд яаж нөлөөлсөн талаар тэмдэглэл бичих

НАЙМДУГААР БҮЛЭГ

БИЧИГЧИЙН САНАА

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах
- Санаагаа оруулан дэлгэрүүлж бичих
- Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих

ЧУХАЛ ХЭСГИЙГ ОЛЖ, БИЧИГЧИЙН САНААГ ТАЙЛБАРЛАЯ

Чаплины охиндоо илгээсэн захидал

Чарли Чаплин 12 хүүхэдтэй байсан бөгөөд 1965 онд 76 настай байхдаа Парист бүжигчнээр ажиллаж байсан 21 настай охин Жеральдинадаа энэхүү захидлыг бичжээ.



Charlie Chaplin



Охин минь, өнөөдөр зул сарын баяр. Дүү нар чинь аль хэдийнээ унтчихсан. Ээж чинь ч унтжээ. (1)

Надаас хэдий хол байвч дүр төрх чинь үргэлж хажууд минь байх юм. Чи минь Парисын театрын тайзнаа бүжиглэж байгаа ч хөлийн чинь чимээг сонсож, нүүр царайг чинь шөнийн оддын дундаас олж харах шиг болдог. (2)

Чи минь Татарын хаанд богтлогдсон Персийн гүнжийн дүрд хувиран бүжиглэж буйг би мэднэ ээ. Гоо үзэсгэлэнгээ гайхуулан бүжиглэ, охин минь. Од болон гялалз, охин минь. Тэгэвч үзэгчдийн алга ташилт, уухайн дуунд мансуурч, цэцэгсийн үнэрт толгой чинь эргэж эхэлбэл эцгийнхээ захидлыг уншиж зүрх сэтгэлээ сонсоорой. (3)

Би бол чиний эцэг, би бол Чарли, Чарли Чаплин. Балчирхан байхад чинь олон олон шөнө орны чинь дэргэд сууж, үлгэр ярин унтуулахдаа нойроо үлдэн хөөж байлаа. Би чинийхээ ирээдүйг, чинийхээ мөрөөдлийг харж байсан. Чамайгаа бүжиглэж байгаагаар төсөөлдөг байлаа. Үзэгчид “Энэ чинь хөгшин алиалагч Чарлигийн охин шүү дээ!” хэмээн уулга алдаж байсан. Тийм ээ, өдгөө аав нь хөгширчээ. Өнөөдөр чиний үе ирж. Бүжиглэ, охин минь! Аав нь уранхай, өргөн өмдтэй бүжиглэж байсан бол чи минь торгон даашинзтай бүжиж байна. Чиний бүжиг, үзэгчдийн алга ташилт чамайг тэнгэрт дүүлэн нисгэх болно. Дүүлэн нис, охин минь! Гэхдээ газарт бас буухаа мартуузай! Хүмүүсийн амьдралыг мэдэж байх учиртай шүү. Чи минь өлсөж ундаасан даарч бээрсэн гудамжны бүжигчдийн амьдралыг мэдэх учиртай. Би яг л тэдэн шиг байсан. Унтахад чинь аав нь олон үлгэр ярьж өгдөг байсан боловч өөрийнхөө үлгэрийг өгүүлж явсангүй. Энэ бол Лондонгийн гудамжинд дуулж бүжиглэж явсан, өлссөн алиалагчийн тухай үлгэр юм. Би өлсөхийн зовлон, орох оронгүйн зовлонг амссан. Түүгээр ч барахгүй бардам сэтгэл минь хүмүүсийн шидэх зоосонд дарагдаж, өр өвдөж явсан. Гэсэн ч би амьд үлдсэн юм шүү. (4)

Аав нь Чаплин нэрээрээ хүмүүсийг 40 гаран жил инээлгэлээ. Гэвч тэдний инээснээс илүүтэй би уйлж явсан. Охин минь, энэ хорвоод дуу бүжгээс өөр зүйл бас байдаг юм шүү! Үдэш тайзнаасаа буухдаа чинээлэг шүтэн бишрэгчдээ мартаж болох ч гэрт чинь хүргэж өгөх таксины жолоочоос эхнэрийнх нь тухай асуухаа битгий мартаарай. Эхнэр нь жирэмсэн, хүүхдийн живхний мөнгөгүй бол халаасанд нь мөнгө хийгээрэй. Харин бусад хүмүүстэй яс тооцоо хийж бай. Хааяа ч гэсэн хотоор алхалж ядуу зүдүү, тарчиг амьдралтай хүмүүсийг харж бай. Урлаг хүнд дүүлэн нисэх даль жигүүр хайрладаг хэрнээ хөлийг нь хугалж хаядаг жамтай. Охин минь, өөрийгөө үзэгчдээс дээгүүр мэт санасан тэр өдрөө тайзаа орхиорой. Парис хотын зах руу явж өөр шигээ бүжигчдийг хар. Тэдэн дунд чамаас илүү авьяастай нь ч таарна. Өөрийгөө бүү хуур. (5)

Аав нь чамд чекийн дэвтрээ явууллаа. "Чамайгаа хангалуун амьдраасай" гэж хүсэж байна. Гэхдээ охин минь, 2 франкийг өөртөө, 3 дахийг нь бусдад зориулж байгаарай. Аав нь циркэд олон жил ажилласан шүү дээ. Олсон дээр явагчдын өмнөөс их л санаа зовдог байлаа. Гэхдээ хүмүүс олсон дээр явагчдаас илүү газраар явахдаа хөл алддаг даа. Сайхан харагдсан очир эрдэнэ рүү тэмүүлэхдээ чи эгээтэй л ямар ч туршлагагүй олсон дээр явагч шиг болно. Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр бүү соль. (6)

Аавынхаа бичсэн болгоныг миний охин ойлгоно байх аа. Чарли өвгөрчээ. Хэзээ нэгэн цагт энэ хорвоог орхин одно. Охин минь, толинд харахдаа чи аавынхаа дүр төрхийг харах болно. Чиний судсаар миний цус гүйж байгаа. Би сахиусан тэнгэр шиг ариун байгаагүй ээ. Гэхдээ би хүний энтэй хүн байх сан гэж хичээж амьдарсан. Чи минь ч бас ийм байхыг хичээгээрэй. (7)

Үнсье, охин минь. 1965 оны 12-р сар.

(Хөрвүүлсэн Б.Гэрэл)
<https://news.mn/r/701948/>

Уншаад утгыг ойлгоё.

1. Эхийг уншихдаа утгыг нь сайн мэдэхгүй үгийг тэмдэглээрэй.
2. Тэмдэглэсэн үгийн өмнөх хойдох үгийг ажиглаад, ямар утгатай болохыг тайлбарлаарай.

Чекийн дэвтэр-Банкнаас мөнгө авах эрхийн дэвтрийг хэлжээ.

Тайлбарлах үгс: гүнж, живх, франк, цирк, алиалагч, зоос, театрын тайз, зул сарын баяр

3. Асуултад хариулж, эхийн утга санааг ойлгоорой.
 - а. Энэ захидалд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - б. Яагаад энэ захидлыг бичих болсон бэ?
 - в. Чаплины өөрийнхөө амьдралаар жишээлэн сургамжилсан хэсгүүдийг ялган уншаад, дараах асуултын дагуу дүрслэн яриарай.
 - Чи аав, охин хоёрын амьдралыг яаж төсөөлж байна вэ? Саналаа солилцоорой.
 - Чаплины амьдралаас юуг ойлгож ухаарав?
 - Чаплин ямар аав бэ? Дүгнээрэй.

- г. Захидлын түлхүүр үгийн доогуур зураарай.
- д. Зурсан үгсээ ашиглан тулгуур бичиглэл хийж, эхийн гол санааг дүгнээрэй.

4. Эхийг эхлэл, гол, төгсгөл хэсгээр зааглаж, догол мөрийн дугаарыг тавиарай.

Эхийн аль хэсэг		Догол мөрийн дугаар
Эхлэл хэсэг	Мэнд мэдэж, захидлын зорилгоо дурдан сануулсан байна.	(1)-(3)
Гол хэсэг		
Төгсгөл хэсэг	Бичсэнээ нэгтгэн дүгнэсэн хэсэг	

Бичигчийн санааг ойлгоё.

1. Чаплины захидалдаа бичсэн дараах хоёр өгүүлбэрийг харьцуулаад, ялгааг нь тайлбарлаарай.

Охин минь, өнөөдөр зул сарын баяр. Дүү нар чинь аль хэдийнээ унтчихсан. Ээж чинь ч унтжээ.

Чиний бүжиг, үзэгчдийн алга ташилт чамайг тэнгэрт дүүлэн нисгэх болно. Дүүлэн нис, охин минь! Гэхдээ газарт бас буухаа мартуузай!

2. Чаплины охиндоо захиж сургасан хэсгүүдийг ялгаж, дараах асуултын дагуу шинжлээрэй.

а. Чаплины охиндоо хэлсэн захиасуудыг олж, тайлбарлаарай.

Жишээ нь:	Сондор ойлгосноо тайлбарласан нь:
Гоо үзэсгэлэнгээ гайхуулан бүжиглэ , охин минь. Од болон гялалз , охин минь.	“Улам сайн хичээ. “сайхан байна, мундаг байна” гэж зогсож болохгүй, тэр тусам нь ихэд мэрий” гэсэн санаа.

Тайлбарлах өгүүлбэр:

- Урлаг хүнд дүүлэн нисэх даль жигүүр хайрладаг хэрнээ хөлийг нь хугалж хаядаг жамтай.
 - Дүүлэн нис, охин минь! Гэхдээ газарт бас буухаа мартуузай!
 - Хүмүүсийн амьдралыг мэдэж байх учиртай шүү.
 - Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр бүү соль.
- б. Догол мөр бүрд давтсан үг, өгүүлбэрийг тодруулж будна уу. Давтсан үг, өгүүлбэрийг ямар учиртай хэрэглэсэн бэ?

Жишээ нь:	Давтсан үг нь:
Би бол чиний эцэг, би бол Чарли, Чарли Чаплин. Би чинийхээ ирээдүйг, чинийхээ мөрөөдлийг харж байсан.	Хэлэх гэсэн санаагаа онцолж, лавшруулсан.

в. Өөр өөр догол мөрт давтаж холбосон үг, өгүүлбэр байна уу? Хэрэв давтсан бол учрыг тайлбарлаарай.

Жишээ нь:

Догол мөрийн дугаар	Давтсан үг, өгүүлбэр:	Тайлбар:
(3)	Гоо үзэсгэлэнгээ гайхуулан <u>бүжиглэ, охин минь</u> . Од болон гялалз, <u>охин минь</u> .	3, 4-р догол мөрийг “бүжиглэ, охин минь”, “охин минь” гэсэн өгүүлбэрээр давтан холбож, санаагаа лавшруулсан.
(4)	<u>Бүжиглэ, охин минь!</u> Дүүлэн нис, <u>охин минь!</u>	

г. Нэмэлт утга илэрхийлж байгаа үг, бүтээврийг тодруулж будаарай. Дараа нь эдгээр үг, бүтээврүүд Чаплины санаагаа илэрхийлэхэд хэрхэн нөлөөлж байгааг ярилцаарай.

Жишээ нь	Тодруулсан үгс нь
Аав нь циркэд олон жил ажилласан шүү дээ . Олсон дээр явагчдын өмнөөс их л санаа зовдог байлаа. Гэхдээ хүмүүс олсон дээр явагчдаас илүү газраар явахдаа хөл алддаг даа .	шүү дээ - анхааруулж сануулсан их л -хүч нэмэгдүүлэн эрчимжүүлсэн даа -баталж нотолсон

д. Чаплин охиндоо захиж сургасан ихэнх өгүүлбэрээ дараах байдлаар төгсгөжээ. Эдгээр өгүүлбэрийн төгсгөл ямар утга илтгэж байна вэ? Ярилцаарай.

- Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр бүү **соль**.
- Гэхдээ газарт бас буухаа **мартуузай!**
- Охин минь, өөрийгөө үзэгчдээс дээгүүр мэт санасан тэр өдрөө тайзаа **орхиорой**.

е. Анхаарлын тэмдэг хэрэглэсэн өгүүлбэрүүдийг түүж бичээрэй. Анхаарлын тэмдэг хэрэглэснээр бичигч ямар санааг илэрхийлэх гэсэн юм бол?

3. Задлан шинжилснээ нэгтгэн дүгнээрэй.

- Чаплины охиндоо хэлсэн захиасуудын гол санаа юу вэ?
- Чаплин эдгээр захиасаар охиндоо юуг ойлгуулах гэсэн бэ? Энэ санаагаа аль өгүүлбэрт илэрхийлсэн бэ?
- Чаплины “Би хүний энтэй хүн байх сан гэж хичээж амьдарсан” гэснийг юу гэж ойлгож байна вэ? Охиндоо хэлэх гэсэн гол санаа нь мөн үү? Ярилцаарай.

4. Дараах ойлголтыг гүйцээж бичээд, бичигчийн санааны талаарх мэдлэгээ дүгнээрэй.

Бичигчийн санаа гэдэг нь-д бичигч хэрхэн хандаж байгааг хэлнэ. Бичигчийн санааг нэмэлт утга илэрхийлж байгаа үг, бүтээвэр, гэхчлэн хэлний хэрэглүүрээр мэдэж болно.

Бичигч санаагаа илэрхийлэхдээ ямар арга хэрэглэснийг шинжилье.

1. Бичигч санаагаа илэрхийлэхдээ эсрэгцүүллийг ашиглажээ. Эдгээр эсрэгцүүлэл тус бүрийг эхээс дараах загварын дагуу түүж бичээрэй.

Өгүүлбэр	Эсрэг утгатай үг, өгүүлбэр	Ямар санааг илэрхийлсэн бэ?
Надаас хэдий хол байвч дүр төрх чинь үргэлж хажууд минь байх юм.	хол ↔ хажууд	“Бие нь хол ч гэсэн сэтгэл нь ойр” гэсэн санааг илэрхийлжээ.

2. Дараах холбох үг ямар утгатай байна вэ? Дүгнэлт гаргаарай.

I	Холбох хэрэглүүр	II
Од болон гялалз, охин минь.	Тэгэвч	Үзэгчдийн алга ташилт, уухайн дуунд мансуурч, цэцэгсийн үнэрт толгой чинь эргэж эхэлбэл эцгийнхээ захидлыг уншиж зүрх сэтгэлээ сонсоорой.
Дүүлэн нис, охин минь!	Гэхдээ	Газарт бас буухаа мартуузай!
Аав нь уранхай, өргөн өмдтэй бүжиглэж байсан.	бол	Чи минь торгон даашинзтай бүжиж байна.
Унтахад чинь аав нь олон үлгэр ярьж өгдөг байсан.	боловч	Өөрийнхөө үлгэрийг өгүүлж явсангүй.
Аав нь Чаплин нэрээрээ хүмүүсийг 40 гаран жил инээлгэлээ.	Гэвч	Тэдний инээснээс илүүтэй би уйлж явсан.
Би өлсөхийн зовлон, орох оронгүйн зовлонг амссан. Түүгээр ч барахгүй бардам сэтгэл минь хүмүүсийн шидэх зоосонд дарагдаж, өр өвдөж явсан.	Гэсэн ч	Би амьд үлдсэн юм шүү.

3. Чаплины охиндоо бичсэн захидлын онцлогийг дараах асуултын дагуу шинжлээрэй.

- Ямар холбох хэрэглүүрийг олон удаа хэрэглэсэн байна вэ? Яагаад?
- Өгүүлбэрийн төгсгөлд ямар нөхцөлийг олон удаа хэрэглэсэн байна вэ? Захидал бичиж байгаа зорилготой хэрхэн холбогдох вэ?

САНААГАА ОРУУЛЖ ДЭЛГЭРҮҮЛЭН БИЧЬЕ

Эхийн утга, бүтцийг задлан шинжилье.

1. Дараах эхийг уншаад, утгыг ойлгоорой.
 - а. Бичигчийн санаа илэрсэн хэсгийг олж тэмдэглээрэй.

Ээжийн захидал

Хичээлдээ тааруухан, сэтгэлийн тэнхээгээр сул дорой хүүхэдтэй нэгэн ээж байжээ. Ээж нь цаг ямагт хүүдээ амжилт гаргаж чадна гэсэн итгэлийг төрүүлдэг байлаа. Хүү ч гэсэн ээжийнхээ итгэлийг алдахгүйн тулд хичээдэг байв.

Хүүгээ дайнд явахын өмнө ээж нь хүү дээрээ ирээд хүмүүсийн юу гэхийг тоохгүйгээр “Миний хүү дайнд хамгийн шилдэг нисгэгч болно” гэж чангаар хэлжээ. Гурван жил хагасын турш үргэлжилсэн дайнд хүү нь эрэлхгээр тулалджээ. Түүнд хүч зориг өгч байсан зүйл бол түүний ээжийн тасралтгүй илгээдэг байсан захидлууд байлаа. “Миний бахархал болсон хүү минь” гэж эхэлсэн ээжийнх нь захидлууд цаг өнгөрөх тусам агуулга нь багасаж, хурдан таталган бичсэн юм шиг харагдах болсон тул эрүүл байна гэж бичдэг ээжийнхээ үгэнд хүү нь эргэлздэг байлаа.

Дайн дуусахын үед нэг захидал хүлээн авчээ. Захидалд “Хайрт хүү минь, одоо баттай зогс. Хүчирхэг бол” гэжээ. Энэ богинохон захидал яагаад ч юм хүүгийн сэтгэлд хоногшин үлджээ. Дайн ч дуусаж, хүү нь Францын элчин сайдын газар ажиллахаар томилогдов. Хүү нь энэ баярт мэдээг юуны өмнө ээждээ дуулгахаар очсон боловч ээж нь аль хэдийн нас барсан байлаа. Ээж нь гурван жилийн өмнө өөрийн нас барахыг тааварлан мэдээд, хүүгээ хүч тэнхээтэй байлгах гэж нэгэн арга сийлжээ.

Энэ нь бурхан болохынхоо өмнө долоо хоногийн турш чичигнэж салганасан гараараа 25 захидал бичиж, түүнийгээ өөрийн найзад өгч, хүүдээ нэг нэгээр нь явуулж байхыг хүссэн байжээ.

- б. Урам хайрласан үг хэллэгийг ялгаж тэмдэглэнэ үү.
 - в. Ээж нь ямар учраас хүүдээ захидал бичсэн юм бол?
 - г. “Хайрт хүү минь, одоо баттай зогс. Хүчирхэг бол” гэсний учир юу вэ?
 - д. Эхийг дахин уншихгүйгээр агуулгаас санаанд орсон 5 үгийг бичнэ үү. Тэдгээр үгээ оруулан 5 өгүүлбэр зохиогоорой.
 - е. Эхийн гол санааг 5-7 үгэнд багтаан бичээрэй.
2. Эхийг задлан шинжлээрэй.
 - а. Эхийн түлхүүр үгийн доогуур зураарай.
 - б. Эх хэдэн догол мөрөөс бүтсэнийг тоолж, дугаарлана уу.
 - в. Догол мөр тус бүрийн санааг тодорхойлоорой.
 - г. Түлхүүр үгээ ашиглан эхийн гол санааг тодорхойлоорой.
 - д. Эхэд гарчиг өгөөд, гол санаатайгаа яаж холбогдож байгааг тайлбарлаарай.

3. Сэдвийг нэгтгэн дүгнээрэй.

- а. Түлхүүр үгээ ашиглан тулгуур бичиглэл хийгээрэй. Тулгуур бичиглэлээ найз нартаа ярьж, санал бодлоо солилцоно уу.
- б. Энэ эхийг уншаад юуг ухаарав?

Эхэд санаагаа оруулан дэлгэрүүлж бичье.

1. Эхэд юуны тухай өгүүлснийг эргэн санаж, ярилцаарай.
2. Дараах урам хайрласан үг хэллэгүүдийн утгыг ярилцаарай. Эдгээрээс сонгон ашиглаж болно.

Амьдралдаа хүсэж байгаа зүйлдээ хүрэхийн тулд хийх эхний бөгөөд зайлшгүй хэрэгцээтэй алхам бол “Юу хүсэж байгаагаа тодорхой болгох” (Бен Стейн)

1

Хайрт хүү минь. Ямар ч бэрхшээлийг даван туулах ухаан, зориг хүч чамд бий. Эрдэм ухааны их оргил өөд тэмүүлнэ гэдэгт тань итгэж байна.

2

Хүү минь ээ!
Хамгийн том баялаг бол Ухаан.
Хамгийн хүчтэй зэвсэг бол Тэвчээр.
Хамгийн аюулгүй байдал бол Итгэл.
Хамгийн эрч хүчтэй зүйл бол Инээд.
Хамгийн гайхалтай нь энэ бүгд үнэгүй юм.

3

Бахархмаар сайн хүү минь ээ,
Ухаантай сайн хүү минь ээ,
Чамайг маш сайн байгаа гэдэгт
ээж нь эргэлзэхгүй байна.

4

Жилийг биш, өдөр бүрийг
чухалчлан үзэх ёстой гэж би
боддог. (Генри Моор)

5

Амьдралаас хүссэн зүйлээ олж авах
хамгийн шилдэг арга бол түүнийг бий
болгоход шаардагдах зүйлийг эхнээс нь
хийж эхлэх чухал гэдгийг санаж яваарай.
Өөр яаж ч мөрөөдөж сүслээд мөргөж
залбираад тус болохгүй.

6

3. Ээжийн өмнөөс хүүд хандаж захидал бичье. Эхэд санаагаа оруулах төлөвлөгөө гаргаарай.

Урам хайрласан үг
хэллэгээс сонгож,
дэлгэрүүлснээ
яаж холбон
найруулахаа бод.

Чаплины охиндоо
бичсэн захидалд
тулгуурлан ямар
санаа, захиас
оруулахаа шийд.

Дэлгэрүүлэн бичсэн
цогцолбороо хаана нь
оруулбал учир зүйн
болоод найруулгын
хувьд зөв байх вэ?

- Дараах бүтцийн дагуу төлөвлөж бичээрэй.

	Бичих агуулга
Эхлэл хэсэгт	Хэнд хандаж байгаагаа бичнэ.
Гол хэсэгт	Одоо болон өнгөрсөн хэрэг явдал, чин сэтгэлийн үг, талархал, сургамж, захиасаа бичнэ.
Төгсгөл хэсэгт	Хүндэтгэл илэрхийлж, гарын үсгээ зурж, он сараа бичнэ.

Жишээ нь: Нэгэн сурагчийн төлөвлөгөөг доор харууллаа. Үүнээс санаа авч болох юм.

Миний бахархал болсон хүү минь

1. Эхлэл хэсэгт

2. Гол хэсэгт

3. Төгсгөл хэсэгт

4. Захидлын доор

- Дээрх урам хайрласан үгсээс (1), (6)-г сонгоно. “...” гэж Бен Стейн хэлсэн байдаг. Тиймээс миний хүү...

- Чаплины охиндоо бичсэн захидлаас “Хүмүүсийн амьдралыг мэдэж байх учиртай шүү.”, “Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр бүү соль” гэсэн захиасыг оруулна.

Хүн чанарын тухай, амьдралын зорилгодоо хүрэхийн тулд хүний энтэй хүн байх тухай санааг эхийн төгсгөл хэсэгт оруулна.

Үнсье, хүү минь. ...оны 5-р сар.

- Төлөвлөгөөг найз нартаа ярьж, санал зөвлөгөөг аваарай.
- Найз нарынхаа өгсөн санал, зөвлөгөөний дагуу төлөвлөгөөгөө сайжруулаарай.


4. Ноороглноо дараах шалгуурын дагуу үнэлж, сайжруулаарай

Шалгуур	Үнэлгээ (☺ ☹ ☹)
Урам өгсөн үг хэллэгийг оновчтой сонгосон байх	
Санаа бодлоо тусгасан байх	
Захиж сургасан өгүүлбэрүүдийн төгсгөлийг өөрчилсөн байх	
Нэмэлт утга илэрхийлэх үг, бүтээвэр оруулсан байх	
Холбох үгийг оновчтой сонгосон байх	
Дэлгэрүүлснээ зөв холбон найруулсан байх	
Найруулгын алдаагүй байх	
Зөв бичих дүрмийн алдааг хянасан байх	

БҮТЭЭВРИЙН НИЙЛЦИЙГ ЗӨВ БИЧЬЕ

Үгийн бүтцийн мэдлэгээ сэргээн саная.

1. Дараах бүдүүвчийг тайлбарлаарай.
 - а. Утгат хэсгийн тухай ярилцана уу.



Жинхэнэ нэр = Язгуур + Тоо + Тийн ялгал + Хамаатуулах

Үйл үг = Язгуур + Үндэс үүсгэх дагавар + Нөхцөл

Холбох

Төгсгөх

2. Дараах өгүүлбэрт орсон үгсийг бүтцээр задлаад, язгуур тус бүрээс төрөл үг бүтээнэ үү.

Ёстныг хүндэл, настныг баярлуул

Ачтанаа өргө, бачтанаас зайл

3. Бүтээсэн төрөл үг тус бүрийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

Зөв бичих дүрмийг бататгая

1. Гээгдэх эгшгийн тухай мэдлэгээ бататгаарай.
 - а. Тулгуур бичиглэлийг уншаад, дүрмийг өгүүлбэрээр илэрхийлж бичээрэй.
 - б. Дүрэм бүрд тохирох жишээ тав тавыг олж бичээрэй.

- ГЭ + ЭЭ = ГЭЭ
- ГЭГ + Г = ГГЭГ
- ЭГ + ЭЭ = ГЭЭ

2. Нөхцөлөөр хувилгаж бичээрэй.

а. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаад, дүрмийг тайлбарлаарай.

хавар, нуга, цэцэг

б. Үйл үгийг дараах нөхцөлүүд (-х, -аарай⁴, -аад⁴, -аач⁴, -аасай⁴)-ээр хувилгаад, дүрмийг тайлбарлана уу.

авар, үсэр, өөрчил, хосол

3. Доогуур нь зурсан үгсэд нөхцөл залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.

- “Өлс+х+д өлөн бугын эвэр зөөлөн, цад+х+д цагаан хурганы сүүл гологд+но” гэгчээр гэдэс нь наашил+х+ын хэрээр өвс нэг л сул амтагдаж хөндий уруудаад очих тариалангийн талбай бодогдоод яв+чих+в.
- Горим+ын дагуу хоног+ийн хэм нь оршин суугаа нутгийнхаа байдлаас болж үргэлж өөрчлөгдөж байдаг.
- Монгол оронд тархсан туулайтны ангилал зүйн зүйлийн доторх ангилбар+ын талаар судлаачид өөр өөрийн байр суурьтай байдаг юм билээ.

Саяхан нэг орой манай нутгийн анчин Дармаа Модот+ын шил дээр урьд өмнө үзээгүй хоёр том амьтантай гэнэт тулгарчээ.

4. Гээгдэхгүй эгшгийн дүрмийг уншаад, тулгуур бичиглэл хийгээрэй.

1. Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээдэггүй. (Дондогийн, Сүхбаатарын)
2. Эгшигт гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй. (үзвэрийн, үйлдвэрлэлийн)
3. Заримдаг гийгүүлэгчийн дараа орсон заримдаг гийгүүлэгч эгшиггүйдэхэд хүрвэл балархай эгшгийг гээхгүй. (санагдсанаар, асдагийг)
4. Үгийн дунд орсон хэлний үзүүрийн “н”, хоолойн “г”-ийн ялгах эгшгийг гээхгүй. (хоногоор, байгалийн)
5. Зөөлрүүлэх үүргээр орсон “и” эгшгийг гээхгүй. (янгирыг, барилаас)
6. Дараалан орсон 3 гийгүүлэгчийн гурав дахь нь хэлний үзүүрийн “н”, хоолойн “г” байвал өмнөх балархай эгшгийг гээхгүй. (хундагаар, эрдэнийн)
7. Тодотгон холбохын “-х”-ийн өмнөх балархай эгшгийг гээхгүй. бодохоор, амрахыг

5. Дараах дүрмийг жишээтэй нь зөв харгалзуулаарай.

л, м, н, в-ээр төгссөн үгэнд “б”, бусад гийгүүлэгчээр төгссөн үгэнд “в” –ээр эхэлсэн залгавар бичнэ.

хүргэ-хүрэг, төгсгө- төгсөг,
унага- унаг

Адил дуудагддаг бусдаар үйлдүүлэх хэвийн –га, биеэр төгсгөхийн –г нөхцөлүүдийг ялгаж бичнэ.

дараах, манайх, өмнөх, доорх

Үйл үндсэнд –хуун, -хүүн дагаврыг залгахдаа эгшиг жийрэгланэ Учир нь “х+vvн”-ны нийлэмж гэж үзлэг

чадавх, идэвх

-вх дагаврын ард “и” эгшиг бичихгүй. Учир нь монгол бичигт “вхи” гэж бичдэг боловч “и” нь зөөлрүүлэх үүрэггүй учир хасаж бичнэ.

тусагдахуун, судлагдахуун,
шатахvvн, бүтээгдэхvvн

Орон цагийн нэр, төлөөний үгэнд хамааруулах vtгатай –х гийгүүлэгчийг шvvд залгана.

авьяас, гавьяа, томьёо, завьяа,
харьяа

Зөөлөрсөн гийгүүлэгч бүхий үгийн язгуурт “ь” бичнэ. Учир нь зөөлрүүлэх үүргээр орж байгаа.

хэлбэл, хамбал, авбал, хэн бэ?,
хийсвэл. хэр вэ?

6. Дараах үгсийг ажиглаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

а. Хоёр эгнээ үгийг харьцуулан тайлбарлаарай.

- Ямар гийгүүлэгчийн дараа “и”, ямар гийгүүлэгчийн дараа “ь” орсон бэ?
- Эр эм үгийн аль нь байна вэ?
- “и”, “ь” ямар үүрэгтэй орсон байна вэ?
 1. савхи, холхи, сорви, анги, болхи, занги
 2. Барь, соль, завь, шавь, захь, бохь, сорь

б. Жишээн дээр тулгуурлан зөөлөрсөн гийгүүлэгчийн дүрмийг бичээрэй.

в. Дараах үгсэд “и”, “ь”-ийн тохирохыг нөхөөрэй.

салх..., бэлх..., зох..., хулх..., хал..., борв..., бах..., сөх...,
танх..., буур..., хуул..., тарх..., бурх..., зовх..., тах..., там..р,
гур...л, хонг...л, танх...м

ЭНЭ БҮЛГИЙН ХҮРЭЭНД СУРСНАА ШАЛГАЯ

1. Эхийн утгыг ойлгоё.

- Уншихдаа мэдэхгүй үгээ тэмдэглэж уншаарай.

(А) эх

Сайн байна уу?

Хайрт Бандрууш аа. Ээж нь охиноо маш их санаж байна, ямар дуусдаггүй юм бэ? Одоо 40 хоног үлдлээ. Өглөө босоод л төд хоног үлдлээ гээд тоолох юм.

Миний охин яаж байна? Хичээл ном чинь хүнд байна уу? Сурч байна уу? Сурсан сураагүй яах вэ, ээждээ түргэн ирж үз. Ээж нь муу бор охиноо маш их санаж бас шөнө бүр шахуу л зүүдлэх юм байна шүү. Миний охин даарч байна уу? Айлд өлсөж байна уу? Хоолой чинь өвдөж байна уу? Ноосон өмдөө өмсөөрэй. Чамайг явсаар энэ өдөр сар их удаан өнгөрч байна.

Ээж нь охиндоо мөдхөн очиж өвөртөлж унтана. Чи минь нялх амьтан шүү дээ, ээждээ. Эрх охиноо үнсье, үнсье, үнсье... 100 төгрөг, 3 кг боорцог өгч явуулав. Удахгүй ээж нь тэтгэврийн мөнгөө авна. Тэгэхээр бүгдийг нь явуулъя. Нөгөө ирисээ авч иднэ биз. Дарханд ямар ч чихэр алга...

Түр баяртай. Удахгүй уулзах өдрийг тэсэн ядан хүлээж байна.

Ээж нь. 1991 он

(Б) эх

Энэ захиаг унших бүр хоолой дээр нэг юм тээглэхээд байдаг юм. Би 18 нас хүртлээ ээжийнхээ өвөрт унтсан билээ. Миний ээж их “хачин” хүн. Биднийг ямар ч юм хүснэ, үл хориглоно, юуг л гуйна авч өгнө, ямар ч алдаа гаргасан үл зэмлэн, зөвхөн өөртөө бурууг өгнө. Би хэзээ ч ээжийнхээ амнаас “Тэгж болохгүй, ингэж болохгүй” гэсэн үг сонсож байгаагүй. Дандаа л “Ээж нь охиндоо итгэж байна” гэнэ. Тэгээд л болоо. Өөрийн бодолтой байх, юунд ч бусдынхаар үл хандах, бие даан шийдвэр зориг гаргах, хэнд ч биш, гагц өөртөө найдаж амьдрах ТЭМҮҮЛЛИЙГ ээжийнхээ энэ их итгэлээс л олж авсан шиг санагддаг. Алдсан ч оносон ч өөрийнхөөрөө.

...Амьдралд уруудсан ч, өндөрт гарсан ч өөртөө болоод өрөөлд үргэлж чин шударгаар хандах, мөрөөдөлдөө хүрэх замыг шударгаар туулж барах сан гэж хүсдэг. Яг л ээж шигээ.

Л.Өлзийтөгс

- (А) эхийн гол санааг 5-7 үгэнд багтаан бичээрэй
- Дээрх 2 эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
- Эхээс урам өгсөн үг хэллэг, захиасыг ялган, тайлбарлаарай.
- Ээж нь ямар учраас охиндоо захидал бичсэн юм бол?
- Ээж нь ямар хүн бэ? Яагаад?
- Энэ 2 эхийг уншаад юуг ухаарав?

2. Бичигчийн санааг задлан шинжилье.

- а. (А) Эхээс нэмэлт утга илэрхийлж байгаа үг, бүтээврийг тодруулж будаарай.

- б. Эдгээр үг, бүтээврүүд санаагаа илэрхийлэхэд хэрхэн нөлөөлж байна вэ?
 в. (Б) Эхээс урам өгсөн үг хэллэгийг олоорой.
3. Охинд нь төрсөн сэтгэгдлээс санаа авч, ээжийн захидлыг дэлгэрүүлж бичье.
- а. Төрсөн сэтгэгдлийг дахин уншиж, ярилцана.
 б. Эхэд санаагаа оруулах төлөвлөгөө гаргаарай.

(Б) Эх дэх урам өгсөн өгүүлбэрийг дэлгэрүүлснээ яаж холбон найруулахаа бод.

(Б) Эхээс санаа авч, ямар захиас оруулахаа шийд.

Дэлгэрүүлэн бичсэн цогцолбороо хаана нь оруулахаа тэмдэглэ.

Эхлэл хэсэг	Гол хэсэг	Төгсгөл хэсэг
Сайн байна уу? Хайрт Бандрууш аа.		Ээж нь. 1991 он

- в. Ноороглноо хянаж, сайжруулна.
- Үг хэллэгээ оновчтой сонгож чадсан уу?
 - Захидал очих хүнийхээ сэтгэлийг хөдөлгөж чадсан уу?
4. Хэл зүйн ойлголтоо давтъя.
- Гээгдэх эгшгийн 3 тохиолдол тус бүрд тохирох жишээ тав тавыг олж бичээрэй.
 - Гээгдэхгүй эгшгийн 7 тохиолдол тус бүрд тохирох нэг нэг жишээг дээрх эхээс олж бичээрэй.
 - Дараах 3 эгнээ үгс дан ба давхар зөөлөрсөн гийгүүлэгчийн аль дүрмээр бичигдсэнийг тайлбарлаарай.

ангирын	тамираар	тургихыг
хонгилын	тахилаас	цалгихаар
зарлигийг	солироор	талхихыг
гортигоос	танилаас	талхихыг
хандиваас	танилаас	горхины

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ЯВДЛЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Энэ бүлгийн хүрээнд эзэмших мэдлэг, чадвар:

- Үйл явдлын мэдээ мэдээллийг нэгтгэн дүгнэж унших
- Үйл явдлыг зургаан асуултын дагуу мэдээлж бичих
- Хэлний зүйн мэдлэгээ бататгах

МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙГ НЭГТГЭН ДҮГНЭЭ

Эхийг унших явцдаа мөрийн хажуугийн зайд дараах тэмдэглэл хийнэ үү.

Сайн мэддэг бол (✓), шинэ мэдээлэл бол (+), эргэлзэж байгаа бол (?), буруу гэж үзвэл (-) гэж тэмдэглээрэй.

Цөлжилт

Хэн нэгэн танаас цөлжилтийн талаар асуувал та юу гэж хариулах вэ?

Энгийн ард иргэдийн дийлэнх нь цөлжилт гэдгийг цаг уурын таагүй нөхцөлөөс болж говийн бүс нутгаар бий болсон байгалийн үзэгдэл гэсэн ойлголттой байдаг. Гэтэл цөлжих үзэгдэл хаана ч тохиолдож болох бөгөөд "Ургамлаар бүрхэгдэж байсан газар нь үржил шимгүй болж доройтохыг хэлдэг" хэмээн эрдэмтэд тайлбарлаж байна. (1)

Одоогийн байдлаар Монгол орны газар нутгийн 76.8 хувь нь цөлжсөн гэсэн судалгааг эрдэмтэд гаргажээ. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцээс "Монгол улс дахь нийт цөлжилтийн 13 хувь нь байгалийн, 87 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас болж байна" гэж мэдээлжээ. (2) Цөлжилт үүсэх шалтгааныг байгалийн болон зохиомол гэж хоёр ангилдаг ажээ.

Монгол орны хувьд ургамлын ургалт өсөлтөд хамгийн их нөлөөтэй хур тунадасны хэмжээ буурч, цөөхөн үзэгдэх хур тунадас нь аадар бороо болж байна. Хүчтэй бороо, үерийн ус нь хөрсний үржил шимтэй өнгөн хэсгийг урсган ургамал ургах нөхцөлийг алдагдуулах нэг шалтгаан болдог байна. Үүнийг шинжлэх ухаанд хөрсний алдагдал гэж нэрлэдэг. Хуурайшиж, ус шингээх чадвар буурсан хөрсөн дээр ширүүн бороо орсноор үер болох нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ бол байгалийн хүчин зүйл юм. (3)

Хэдийгээр цөлжих үйл явцад байгалийн таагүй уур амьсгалын нөлөө их боловч хүний буруу үйл ажиллагаа асар их нөлөөлж байна. Хүний буруу үйл ажиллагаанаас шууд хамааралтай цөлжилт үүсэхийг зохиомол хүчин зүйл гэдэг. Үүнд мал аж ахуй гол нөлөө үзүүлдэг. Мал сүргийн тоо 1920-оод онд 10 сая орчим байсан бол 2010 он гэхэд 43 сая болж, даруй дөрөв дахин нэмэгдсэн байна. Ийм олон мал сүрэг нь бэлчээрийг талхлан доройтуулдаг. Ийнхүү газрын доройтлоос үүдэн бэлчээрийн талбай багасаж, төв болон баруун бүсэд даац улам хэтэрсэн байна. Газрын хөрсийг ихээр талхалдаг ямааны тоо эрс нэмэгдсэн. Ямаа нь өвс ногоог үндсээр нь зулгааж иддэг тул ургамлын бүрхэвч устахад гол нөлөө үзүүлдэг юм. Тариалангийн газрыг атаршуулан хаях, уул уурхайн малталтын дараагаар нөхөн сэргээлт хийхгүй байх, авто замын сүлжээ буюу шороон зам гаргах, ойн түймэр зэргээс шалтгаалан хөрс бохирдож, үржил шимээ алдаж байна. (4)

Уншигч та цөлжилтийн эсрэг хувь нэмрээ оруулахад бэлэн үү? Магадгүй та "яаж?" гэж бодож байгаа байх. Энгийн бүхнийг өөрөөсөө эхэлье. Мод тарихгүй юм аа гэхэд мод усалъя. Ургаж байгааг нь хугалж гэмтээхгүй, тайрч хорогдуулахгүй байя. Усны хэрэглээгээ зөв зохицуулж хэвшье. Та усаа гүйцэд хаасан уу? Хогоо зориулалтын саванд нь хийсэн үү? Энэ мэт амьдралын энгийн дадал хэвшил нь байгаль дэлхийг маань цөлжих аюулаас хамгаалахад нэмэр болж чадна. Энэ нь та өөрийгөө, ирээдүйгээ хамгаалж буй хэрэг юм. (5)

Цөлжилтийн эсрэг тэмцье гэвэл эхлээд хүн бүр тархин дахь "цөлжилттэйгөө" тэмцье гэсэн уриагаар өгүүллээ төгсгөө. (6)

Багшийн ном, Монгол хэл уран зохиол, 2014

Эхийн утгыг ойлгоё

- Эхээс дараах үгсийг олж, эхийн хам бүтцээс утгыг нь тайлбарлаарай.
 - хүний хүчин зүйл
 - зохиомол хүчин зүйл
 - хөрсний алдагдал
 - хөрсний үржилтэй өнгөц хэсэг
 - газар доройтох
 - газрыг атаршуулах
 - нөхөн сэргээлт хийх
- Дараах зургуудыг ажиглаад, зураг бүр "Цөлжилт" эхийн аль хэсэгтэй холбоотойг ярилцана уу. Эдгээр нь эхийн агуулгыг ойлгоход ямар дэмжлэг үзүүлж байна вэ? Тохирох догол мөрийн дугаарыг дугуйлж тэмдэглээрэй.



1 2 3 4 5 6




1 2 3 4 5 6



1 2 3 4 5 6



1 2 3 4 5 6



1 2 3 4 5 6

1 2 3 4 5 6



1 2 3 4 5 6

1 2 3 4 5 6

3. Догол мөр бүрээс гол санаа илэрхийлсэн хэсгийг ялгаж бичнэ үү. Дараа нь тухайн догол мөрийн санааг түлхүүр үгээр илэрхийлж бичээрэй.


Догол мөр	Догол мөрийн гол санаа илэрхийлсэн хэсэг	Догол мөрийн нэр
1	<i>Цөлжилтийн талаар асуувал та юу гэж хариулах вэ? Цөлжих үзэгдэл хаана ч тохиолдож болно. Ургамлаар бүрхэгдэж байсан газар нь үржил шимгүй болж доройтохыг цөлжилт гэдэг.</i>	Цөлжилт
2		
3		
4		
5		
6		

4. Дараах асуултын дагуу ярилцаарай.

- Та нараас “Цөлжилт гэж юу вэ?” хэмээн асуувал юу гэж хариулах вэ?
- Эхэд дэвшүүлсэн ямар санаатай та санал нэгдэж байна вэ? Яагаад?
- Цөлжилтийг бууруулахад бид юу хийж болох вэ? Ямар хувь нэмэр оруулж чадах вэ?
- Зохиогч яагаад “Цөлжилтийн эсрэг тэмцье” гэвэл эхлээд хүн бүр тархин дахь “цөлжилттэйгөө” тэмцье гэж уриалсан бэ?

Мэдээллийг задлан шинжилье.

1. Эхийн агуулгыг харуулсан зураглалыг гүйцээгээрэй. Зураглалаа ашиглан эхийн гол санааг тайлбарлан ярина уу.



2. Дээрх бүдүүвч зураг дээр тулгуурлан 10, 20 жилийн дараах байгалийн байдлыг төсөөлөн зураарай.

- Аль хүчин зүйл давамгайлж байгааг ажиглана уу.
- Тархины цөлжилттэйгөө тэмцэж чадвал, эс чадвал байгаль ямар болсон байхыг төсөөлж ярилцана уу.

3. Дараах асуултын дагуу эргэцүүлэн бодоод эхлээд товч хариулна уу. Дараа нь яагаад ийм хариулт өгсөн шалтгаанаа тайлбарлаарай.

Эхийг ямар хүн бичсэн гэж бодож байна вэ?

Эхийг хэнд зориулж бичсэн бэ?

Ямар хэлбэрээр бичсэн бэ?

Ямар зорилгоор бичсэн бэ?

Эхийг хурааж бичье.

1. Хоёр хэсгийг харьцуулаад, яаж хурааж бичсэнийг дүгнээрэй.

Эхийн догол мөр	Хураасан нь
"Одоогийн байдлаар Монгол орны газар нутгийн 76.8 хувь нь цөлжсөн" гэсэн судалгааг эрдэмтэд гаргажээ. НҮБ-ын "Цөлжилттэй тэмцэх конвенц"-ээс Монгол улс дахь нийт цөлжилтийн 13 хувь нь байгалийн, 87 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас болж байна гэж мэдээлжээ. (2)	Монгол орны газар нутгийн 76.8 хувь нь цөлжсөн. Нийт цөлжилтийн 13 хувь нь байгалийн, 87 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас болжээ. (2)

Тайлбар: Энэ догол мөрд Монгол орны газар нутгийн ихэнх цөлжсөн, энэ нь юунаас болсон гэдгийг мэдээлэх зорилго агуулсан тул батлах тоо чухал гэж үзээд баримтуудыг үлдээсэн байна.

- Эхээс аль нэг догол мөрийг сонгоод дээрх загварын дагуу хураан бичиж, учрыг тайлбарлаарай.
- Эхийн бусад догол мөрийг энэ маягаар хурааж бичээрэй.
- Дараа нь бичсэн хэсгүүдийг нийлүүлэн, нэг товч эх болгон найруулж бичээрэй.
- Хурааж бичсэн эхээ дараах шалгуураар шалгаарай.

1. Догол мөр бүрийн гол санаа алдагдаагүй байна.
2. Түлхүүр үг, өгүүлбэрийг үлдээсэн байна.
3. Догол мөрүүдийн дэс дарааллыг алдагдуулж болохгүй
4. Өгүүлбэрүүд хоорондоо уялдаа холбоотой байна.

2. Дараах бичвэрийг хүснэгтэн мэдээлэлтэй харьцуулан ажиглаарай.

1970-аад оноос говийн бүсийн хүмүүс төв суурин газрын түлшний хэрэгцээнд заг модыг их хэмжээгээр хавтгайруулан бэлтгэдэг болсноос 125 мянган га газрын заг бүрэн устсан.(1) Одоо 370 гаруй мянган га газрын заг байгалийн аясаар сэргэн ургах чадвараа алджээ.(2) Мөн авто машинууд олон салаа зам гаргаж, газрыг уул уурхайн зориулалтаар ухаж сэндийчиж, тариалангийн талбайг элэгдэл эвдрэлд оруулах зэргээр хүний буруутай үйл ажиллагаанаас цөлжилт эрчимжиж байна.(3)

Асуулт	1-р өгүүлбэр	2-р өгүүлбэр	3-р өгүүлбэр
Хэзээ?	1970-аад оноос	Одоо	
Хаана?	говийн бүсийн	370 гаруй мянган га газрын	
Хэн? Юу?	хүмүүс	заг	Цөлжилт
Хэнийг? Юуг?	заг модыг		
Ягаад? (Шалтгаан)	түлшний хэрэгцээнд хавтгайруулан бэлтгэдэг болсноос		<ul style="list-style-type: none"> • авто машинаар олон салаа зам гаргаж • газрыг уул уурхайн зориулалтаар ухаж сэндийчиж • тариалангийн талбайг элэгдэл эвдрэлд оруулснаас
Яав? (үр дүн)	125 мянган га газрын заг бүрэн устсан.	байгалийн аясаар сэргэн ургах чадвараа алджээ.	эрчимжиж байна.

3. Дээрх хүснэгтэн мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлт бичээрэй.

- Цөлжилтийн явцыг цаг хугацааны дарааллаар харуулжээ. Цөлжих явц хэр хурдацтай явагдаж байна вэ?
- Цөлжилт үүсгэгч гол хүчин зүйл нь юу вэ?
- Цөлжилтийн үр дүнгээс хэнд хандаж, юуг хэлмээр байна вэ?

Үйл явдлын мэдээний онцлогийг судалъя.

1. Үйл явдлын мэдээний агуулгыг “Цөлжилт” эхтэй холбон ярилцаарай.
2. Мэдээг дахин уншаад дараах асуултад хариулахад бэлтгээрэй.
 - Мэдээг ямар зорилгоор, хэнд зориулж бичсэн бэ?
 - Мэдээнд аль цагт болсон үйл явдлыг өгүүлсэн байна вэ? Үүнийг яаж мэдсэн бэ?
 - Мэдээнд өгүүлсэн үйл явдлууд яаж холбогдож байна вэ? Цаг хугацааны дарааллыг харгалзсан байна уу?

Эко сургуулиуд үзэсгэлэн гаргана

Олонулсын Эко сургууль хөтөлбөрийн “Хүрэл гэрэгэ” өргөмжлөл гардуулах ёслол маргааш тавдугаар сарын 5-ны 13 цагт Соёлын төв өргөөний Монголын Уран зургийн галерейд болно. Ёслолын үеэр “Хүрэл гэрэгэ” өргөмжлөлийн болзол хангасан ерөнхий боловсролын 41 сургууль өөрсдийн туршлагаа танилцуулж, сурагчид үзэсгэлэнгээ дэлгэх юм. ...



“Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” төрийн бус байгууллага нь олон улсын “Эко сургууль хөтөлбөр”-ийг 2007 оноос эхлэн Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хот, хөдөөгийн 65 сургуульд амжилттай туршиж, 2011 оноос Дэлхийн байгаль орчны боловсролын сангийн албан ёсны эрхтэйгээр хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрт дэлхийн 64 орны нийт 49000 гаруй сургууль нэгдсэн байна. Өдгөө “Эко сургууль хөтөлбөр”-ийн сүлжээнд орон нутаг, нийслэлийн нийт 200 гаруй ерөнхий боловсролын сургууль хамрагджээ.

Энэ удаагийн ёслолын арга хэмжээг Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, “Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” хамтран зохион байгуулах юм.

Эх сурвалж: БОАЖЯ, mne.mn, 2017

3. Дараах даалгаврыг гүйцэтгэж, мэдээ бичихэд юу анхаарах ёстойг дүгнэн ярилцана уу.
- Бичигчийн уншигчдад хүргэх гэсэн гол мэдээлэл аль хэсэгт байна вэ? Бусад хэсэг ямар үүрэгтэй гэж бодож байна вэ?
 - Мэдээнд ямар ямар баримт ашигласан байна вэ?
 - Мэдээнд бичигчийн үзэл бодлоо илэрхийлсэн хэсэг байна уу?
 - Мэдээ хэн?, хаана? хэзээ?, юуг? (хэнийг?), яагаад?, яав? гэсэн зургаан асуултад хариулт бүрэн өгч чадаж байна уу? Дараах хүснэгтэд байгаа асуултад хариулагдах хэсгийг догол мөр бүрээс олоорой.

	Догол мөр 1	Догол мөр 2	Догол мөр 3
Хэзээ?			
Хаана?			
Хэн?			
Яагаад?			
Юуг? Хэнийг?			
Яав? (үр дүн)			

4. Дараах мэдээг дахин уншаад асуултад хариулж бичээрэй.
- Мэдээг ямар зорилгоор, хэнд зориулж бичсэнийг ярилцаарай.
 - Мэдээнд аль цагт болсон үйл явдлыг өгүүлсэн байна вэ? Өмнөх мэдээнээс ямар ялгаатай байна вэ?
 - Мэдээнд өгүүлсэн үйл явдлууд яаж холбогдож байна вэ?
 - Цаг хугацааны дарааллыг харгалзсан байна уу?

Монгол Улсад Хүүхдийн байгууллага үүсэж, хөгжсөний 93 жилийн ойг тэмдэглэв.

МОНГОЛЫН МЭДЭЭ | БОЛОВСРОЛ



Ж.Болор
bolor@montsame.mn
2018-05-08 11:56:57

Like 0 Share Tweet



Улаанбаатар /МОНЦАМЭ/. Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 93 жилийн ойн өдөр өнөөдөр тохиож байна. Эл өдрийг тохиолдуулан хүүхдийн байгууллагын төлөөлөл болон ахмад пионерууд тус байгууллагыг үндэслэгч, их зохиолч Д.Нацагдоржийн хөшөөнд хүндэтгэлийн цэцэг өргөв.

1959 оны ахмад пионер н.Цасчихэр, “Монгол улсыг хүүхэд залуусын орон гэдэг. Улсын нийслэлийн түүхэнд хүүхдийн байгууллагын оруулсан хувь нэмэр их. Бидний үеийн пионерууд Улаанбаатар хотод барилга байгууламж барих, мод суулгах, зүлэг тарихад оролцож, “Зүлгэн дээр битгий гишгэ” гэж ахмад үедээ ёсолж, хүндэтгэл үзүүлдэг байсан. Хүүхэд залуус та бүхэн улам сайн суралцаж, эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, дэлхийн жишигт нийцсэн хот болоход үлгэрлэн оролцохыг хүсэж байна” хэмээн сэтгэгдлээ хуваалцав. Энэ үеэр улаан бүч зүүсэн ахмад пионерууд “Бүхий олон багачууд” дуугаа дуулж эгшиглүүлсэн юм.

Эл тэмдэглэлт өдрийн хүрээнд хүүхдийн байгууллагын түүхийг харуулсан “Хүүхдийн амьдрал түүх бүтээдэг” гэрэл зургийн үзэсгэлэнг Монголын хүүхдийн ордны үзэсгэлэнгийн танхимд нээлээ. Үзэсгэлэнд анхны Хүүхдийн байгууллага үүссэн 1925 оноос хойших 93 жилийн түүхэн гэрэл зургийг он цагийн дарааллаар байрлуулан дэлгэжээ. Энэ үйл ажиллагаанд нийслэлийн удирдлагууд, нийслэлийн хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтнүүд, хүүхдийн байгууллагын үе үеийн ахмадууд, хүүхдийн хөгжил оролцооны байгууллагууд, хүүхэд багачуудын төлөөлөл оролцов.

Ж.Болор
Гэрэл зургийг Б.Чадраабал

5. Мэдээг дахин уншаад дараах асуултад хариулж бичээрэй.


	Хариулт	Үүнийг яаж мэдэв?
Мэдээнд “өнөөдөр”, “эл өдөр” болсон үйл явдлыг бичжээ. Энэ үйл явдал болсон он, сар, өдрийг бичнэ үү.		
Энэ мэдээг хаана нийтлэгдсэн гэж үзэж байна вэ?		
Цасчихэр гэдэг нэрийн өмнө “н” гэж бичсэн нь ямар учиртай вэ?		
“пионер”, “хүүхдийн хөдөлгөөн” гэдэг үгс ямар утгатай вэ?		

6. Дараах даалгаврыг гүйцэтгэж, мэдээ бичихэд юу анхаарах ёстойг дүгнэн ярилцана уу.
- Бичигчийн уншигчдад хүргэх гэсэн гол мэдээлэл аль хэсэгт байна вэ?
 - Мэдээнд ямар ямар баримт ашигласан байна вэ?
 - Мэдээнд бичигчийн үзэл бодлоо илэрхийлсэн хэсэг байна уу?
 - Мэдээ хэн?, хаана? хэзээ?, юуг? (хэнийг?), яагаад?, яав? гэсэн зургаан асуултад бүрэн хариулт өгч чадаж байна уу?

7. Одоо, ирээдүй, өнгөрсөн гурван цагийн явдлыг илэрхийлэх гол үүрэгтэй үгсийг түүж ялган бичээрэй.

- Одоо цаг:
- Өнгөрсөн цаг:
- Ирээдүй цаг:

8. “Монгол улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 93 жилийн ойг тэмдэглэв” мэдээг хурааж бичээрэй.



Ойлголтоо нэгтгэн дүгнэе.

1. Мэдээ, мэдээллийг хурааж бичих аргыг хэрхэн ойлгосноо тайлбарлаарай.
 - а. Нэгдүгээр дасгалд байгаа эхийг ямар аргаар хурааж бичсэнээ ярилцаарай.
 - Түлхүүр үг, өгүүлбэрийг олж бичсэн.
 - Үйл явдал болсон цаг хугацаа, газар орныг чухал гэж үзсэн.
 - Үйл явдлыг нотлоход чухал гэсэн баримтуудыг сонгож авсан.
 - Асуудлын шалтгааныг чухалчилсан.
 - б. Баримт мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлт бичих нь хураан бичих нэг арга хэлбэр мөн үү? Багштайгаа хамтран ярилцаарай.
2. Товч болон дэлгэрэнгүй мэдээллийн ялгааг ойлгож аваарай.
 - а. Тавдугаар дасгалд байгаа хүснэгтэд тулгуурлан дараах асуултад хариулаарай.
 - Мэдээллийг уншигч, сонсогчдод ойлгомжтой хүргэхэд юу чухал вэ?
 - Мэдээлэл үнэн гэдгийг юугаар батлах вэ?
 - Хүмүүс яагаад үйл явдал хэзээ болсон бэ?, хаана болсон бэ? гэх мэтээр асуудаг вэ? Энэ нь юутай холбоотой вэ?
 - б. Дараах хоёр ойлголтыг гүйцээгээрэй.

..... мэдээ мэдээлэл нь баримтыг дурдаад, цөөн үгээр учир шалтгааныг тайлбарладаг.

..... мэдээ, мэдээлэл нь хэзээ? хаана?, хэн?/ юу?, хэнийг?, юуг? яагаад? яав? гэсэн асуултад бүрэн хариулагддаг.

3. Дараах мэдээг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.
 - а. Мэдээний 6 асуултад хариулагдаж байгаа эсэхийг шинжлээрэй.
 - б. Товч мэдээ болгон хураагаарай.

Дундговь /МОНЦАМЭ/. Есдүгээр сарын 22-нд Дундговь аймгийн төрийн албанд ажиллагсдын төлөөлөл “Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэнд-5” эко явган аялалд оролцлоо. Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, баг хамт олныг идэвхжүүлэх, ажилтнуудаа цэвэр агаарт гаргаж, идэвхтэй хөдөлгөөн хийлгэх зорилгоор зохион байгуулдаг энэ удаагийн явган аялалд 20 гаруй байгууллагын албан хаагчид оролцож аймгийн төв талбайгаас хойш дөрвөн км газарт “Зоогийн шанд” хүртэл аялсан юм.

Эко аяллын хүрээнд уулын оргил булаалдах, хөгжилтэй буухиа, багийн асуулт хариулт, багийн ахлагч нарын дунд тэмцээн, багийн хөгжөөн дэмжигчдийн тэмцээн зохиогдож, 11 баг тамирчид хүч чадлаа сорин оролцсоноос “Цахилгаан түгээх шугам сүлжээ”, Онцгой байдлын газар, МСҮТ-ийн багууд бусдыгаа тэргүүлж, ирэх жилийн явган аяллыг зохион байгуулах эрхтэй боллоо.

Д.Алтантогос
Monsame.mn/mn/read/165612

ҮЙЛ ЯВДЛЫГ МЭДЭЭЛЖ БИЧЬЕ

1. "Эко сургуулиуд үзэсгэлэн гаргана" мэдээнд өгүүлсэн үзэсгэлэнд тавигдсан дараах зургийг ажиглаад, өгсөн даалгаврыг гүйцэтгэнэ үү.



Байгаль орчны мэдээлэл сургалтын төв

- а. Зургийг ажиглаад хүүхдүүд юуг хүсэж мөрөөдөж байгааг ярилцана уу.
- б. Үзэсгэлэнд тавьсан эдгээр зургийн талаар товч мэдээ бичээрэй. Бичихдээ "Эко сургуулиуд үзэсгэлэн гаргана" мэдээг баримт нотолгоо болгоорой.
 - Үзэсгэлэнг хэн гаргасан бэ?
 - Эдгээр бүтээлүүд хэзээ, хаана тавигдсан бэ?
 - Эдгээр зургаар үзэсгэлэн гаргасан шалтгаан юу вэ?
- в. Бичсэн мэдээгээ дараах шалгуураар үнэлээрэй.

1. Мэдээ үнэн бодитой болж чадсан уу?
2. Мэдээ нь хэн?, хаана? хэзээ?, юуг? (хэнийг?), яагаад?, яав? гэсэн зургаан асуултад хариулт өгч чадсан уу?
3. Баримт нотолгоонд үндэслэсэн үү?
4. Баталгаатай гэдгийг харуулах эх сурвалж байна уу?

2. Дараах сэдвээс сонгон нэг мэдээ бичнэ үү. Мэдээ нь гол мэдээллээс гадна түүнд шууд хамаарах нэмэлт мэдээллээс бүрдсэн байна. Өөрсдийн бичсэн мэдээг дээрх шалгуураар үнэлээрэй.

- Бие дааж гүйцэтгэсэн үйл ажиллагаа
- Анги хамт олноороо оролцсон үйл ажиллагаа
- Сургуулийн хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагаа

6-р ангид судалсан хэлний зүйн мэдлэгээ бататган давъя.

1. Дараах эхийг уншаад өгсөн даалгаврыг гүйцэтгээрэй.

Туул тунин тунин ирэв

Туул... Туулын тухай амтай болгон шагширч байна. Хэдэн мянган жил халгин цалгин урссан хатан Туул нүд анихын ирмэгт тулаад байгаа гэнэ.

Морин давааны их аман дээр Туул дүн өвөл шиг цавцайж байлаа. Мөсөн дээрх цасан бүрхүүл нь хэв хэвээрээ. Дээгүүр нь алхахад цөмрөх янзгүй. Харин голд нь хүртэл хэсэг газар харзалсан жижиг цоорхойгоор Туулын ус хэржигнэн урсаж байх нь тэр. Гэхдээ цас мөсөн бүрхүүлээ дотроос нь хага татан яргаж цөнгөө түрэх тэнхэл үнэртсэнгүй. Одоо Монголын бүх гол цөнгөө түрчихсэн байгаа. Их ус, их урсгал оволзсон, хүчтэй ус мөрөн бол урины түрүүчээр мөс цасыг дэлбэ татан ганц л шөнийн дотор цөн түрж хонодог гэнэ.

Туулаа аймшигтай гомдоожээ. Аргаа барахдаа Хан Хэнтийн сарьдаг уулс хатан Туулаа хэзээ хойно унин тунин илгээв. Тэгээд уяхан гэгэлгэн Туул минь газрын холоос нутаг гүйсэн адуу шиг эцэн сульдэн ирэв. Туул туньж туньж ирлээ, та минь...

а. Дараах үгсийн утгыг эхийн хам бүтцээс тайлбарлаж бичээрэй. Монгол хэлний тайлбар толь бичиг ашиглаж болно.

- цөн түрэх-
- хага татан яргах-
- харзлах (харзалсан жижиг цоорхой)
- урины түрүүч

б. Дараах асуултын дагуу ярилцаж, эхийн утга санааг тайлбарлаарай.

А. Хэдэн мянган жил халгин цалгин урссан хатан Туул нүд анихын ирмэгт тулаад байгаа гэнэ.

Б. Харин голд нь хүртэл цас мөсөн бүрхүүлээ дотроос нь хага татан яргаж, цөнгөө түрэх тэнхэл үнэртсэнгүй.

А. Харин хэсэг газар харзалсан жижиг цоорхойгоор Туулын ус хэржигнэн урсаж байх нь тэр.

Б. Их ус, их урсгал оволзсон, хүчтэй ус мөрөн бол урины түрүүчээр мөс цасыг дэлбэ татан ганц л шөнийн дотор цөн түрж хонодог гэнэ.

в. Ижил дугаартай хос дүрслэлийг уншаад юуг юутай харьцуулсныг тайлбарлан ярилцаарай.

- Туул гол яагаад бусад гол шиг цөнгөө түрэхгүй байсан бэ?
- Зохиогч Туул голд аюул тулгараад байгааг ямар ямар үгээр дүрсэлсэн байна?
- Зохиогч энэ эхийг хэнд зориулж, ямар зорилгоор бичсэн гэж бодож байна?

Хэн бичсэн бэ?	Хэнд зориулсан бэ?	Ямар зорилгоор бичсэн бэ?	Ямар хэлбэрээр бичсэн бэ?

2. Өдөр тутмын амьдралдаа усыг гамтай хэрэглэхийг найз нартаа уриалсан эх зохиож бичээрэй. Энэ даалгаврыг дараах алхмаар гүйцэтгэнэ үү.

а. Дараах зургуудыг ажиглаад, усыг яаж хэрэглэдэг талаараа ярилцаарай.



б. Графикийг ажиглаад иргэдийн усны хэрэглээний байдлыг дүгнэн ярилцаарай.



Багшийн ном, Монгол хэл уран зохиол VI, 2005

в. Дээрх зураг ба график дахь мэдээлэл, ярилцах үедээ гарсан санаануудыг ашиглан, "Усны зохистой хэрэглээ" сэдвээр эх зохион бичээрэй.

3. Үг зүйн мэдлэг, чадвараа бататгаж, дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

а. “Туул тунин тунин ирэв” эхээс жинхэнэ нэр, үйл үг, орон цагийн нэрийг түүж, тохирох хэсэгт бичээрэй. Эхэд байгаа нийт үгийн хэдэн хувь нь энэ гурван аймагт хамаарахыг тооцоолоорой.

Үгийн аймаг	Жинхэнэ нэр	Үйл үг	Орон цагийн нэр	Бусад
Үг				
Үгийн тоо				

б. Хоёр бүлэг үгсийг бүтээврээр задалж бичээд, бүтээвр тус бүрийг тайлбарлаарай. Бүтээврүүдийг нийлүүлэн бичихэд өөрчлөлт гарч байгаа эсэхийг ажиглаад учрыг тайлбарлаарай.

Жишээ нь:

~ үнэртсэнгүй
 ~ цоорхойгоор
 ~ бүрхүүлээ
 ~ бүрхүүл нь
 ~ харзалсан
 ~ давааны

~ хонодог
 ~ шөнийн
 ~ барахдаа
 ~ урссан
 ~ цөнгөө
 ~ түрчихсэн

в. Дараах хоёр үгийн тайлбарыг ажиглаад, бусад үгсийг энэ маягаар тайлбарлан бичээрэй.

цоорхойгоор - Жинхэнэ нэр, ерийн нэр, ганц тоо, үйлдэхийн тийн ялгалын нөхцөлөөр “урсаж” гэсэн үгтэй холбогдсон.

урсаж- Үйл үг, эс тусах, нөхцөлдүүлэн холбохын нөхцөлөөр “байна” гэсэн үгтэй холбогдсон.

Тайлбарлан бичих үгс: Туулын, цөнгөө, холоос, амтай, урсгал, хонодог, ирэв, тулаад, илгээв

г. Эхээс “Туулаа”, “бүрхүүлээ”, “цөнгөө” гэсэн гурван үг ерөнхийлөн хамаатуулах нөхцөлөөр хувилсан байна. Асуулт тавиад ямар тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржиж, өгүүлбэрт ямар үүрэг гүйцэтгэснийг тайлбарлаарай.

д. Эхээс тийн ялгалын нөхцөлөөр хувирсан үгсийг олж, тохирох хэсэгт бичээрэй.

Тийн ялгалын нэр	Эхээс олох үгийн тоо	
Нэрлэх	8	Туул,
Харьяалах	5	Туулын, ...
Заах	5	цөнгөө,
Өгөх орших	2
Гарах		
Үйлдэх	1
Хамтрах	1	
Чиглэх		

е. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж бичээд, бүтээврийн нийлц дэх зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

багаж, анги, танхим, санал, хууль, урлаг, амжилт, танилцуулга

ё. Дараах асуулт, хариултыг хуулж бичихдээ цэгийн оронд үйлийн тохирох нөхцөлийг нөхөөрэй. Үйлийн нөхцөлийг нөхөж бичихдээ зөв бичгийн дүрмийн алдаа гаргахгүйг хичээгээрэй.

Харилцан яриа

-Уур амьсгал ба цаг агаар ямар ялгаатай вэ?

- Бид “Өчигдөр ч мөддөө тасар(...)гүй дээ гэмээр их бороо ор(...) бай(...) чинь өглөө нар тус(...) өнөөдөр ч сайхан өдөр бол(...) нь ээ” гэлц ... шүү дээ. Эсвэл хөгшид “Маргааш тэнгэр нэг л бишид(...) нь, сар хүрээл(...) хоно(...) бай(...) шүү” хэмээн тэнгэрийг шинж(...). Өчигдөр өнөөдөр, маргааш зэрэг цөөн хоногийн тэнгэрийн “араншин”- г цаг агаар гэдэг. Харин “энэ зун их хуурай, гандуу бай(...) шүү, өвөл өнтэй сайхан бол(...)” хэмээн ярилцах нь уур амьсгалын тухай ярьж бай(...) хэрэг юм. Ингэхлээр цаг агаар гэдэг нь богино хугацааны агаарын төлөв байдлыг хэлдэг бол уур амьсгал нь цаг агаарын олон жилийн төлөв байдал юм.

-Уур амьсгал өөрчлөгдөж байна, дулаарч байна, энэ нь ийм, тийм хор хохиролтой хэмээн хаа сайгүй л ярь(...) болжээ. Энэ чинь байгалиасаа л болж байгаа биш юм үү? Манайх шиг хүйтэн газар дулаар(...) л бай(...) сайн биш үү гэж бодогдох юм. Цаг агаар, уур амьсгал гэдэг чинь ямар ялгаатай юм бэ? Надад нэг сайн ойлгуул(...) өгөөч?

-Та нар зөв ажигла(...). Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт мэдэгдэхүйц бол(...), энэ нь дэлхийн хэмжээний асуудал болж байна. Зун богино бол(...) гэлцэх бол(...) богино хугацаанд хэт хал(...) нь нэмэгдэж байна. Манай орны хувьд гэхэд л өнгөр(...) далаад жилийн дотор дунджаар 2.14 орчим хэмээр дулаар(...) нь дэлхийн дунджаас 3 дахин эрчтэй дулаар(...) байна.

-Одоо дулаарлын талаар тайлбарл(...) өг(...). Дулаар(...) л байгаа гэх юм, нээрээ ч үнэн шүү. Биднийг бага байхад айхтар хүйтэн өвөл бол(...) байсан шиг санагд(...). Энэ чинь 30-40 жилийн өмнө шүү дээ. Үнэгэн малгай бүсэл(...) л явдаг сан. Одоо үнэгэн малгай өмс(...) хүн ч үгүй болж, хэрэв өмс(...) халууц(...) сүйд болох маягтай даг

шүү. Зундаа нэлээд сэрүүхэн болчих(...) юм уу даа. Тэг(...) хэрнээ цөөн хэд хоног бүр шат(...) шахам халахыг нь яана аа. Дээхэн үед бол налай(...) сайхан урт зун болдог байсан санагд(...). Энэ үнэн биз, ингэхэд би өөрөө уур амьсгал хэрхэн өөрчлөгд(...) байгааг бүр баримттайгаар ярьчих(...) уу даа

Мод дагаж ус, ус дагаж амьдрал, 2002 (WWF)

4. Өгүүлбэр зүйн мэдлэг, чадвараа бататгаж, дараах даалгаврыг гүйцэтгээрэй.
а. Өгүүлбэрийг дараах маягаар холбоо үг болгон задална уу.

Холбоо үгээр задлах өгүүлбэр: Эвдэрхий цоргоор долоо хоногт 90 литр ус асгардаг.

Холбоо үгээр задалсан нь: эвдэрхий цорго, цоргоор асгарах, ус асгарах долоо хоног, хоногт асгарах, ерэн литр, литр ус

- б. Дараах өгүүлбэрийг хуулж бичээд, гол гишүүдийг зурж тэмдэглээрэй. Хэдэн бүрэлдэхүүнтэй өгүүлбэр болохыг тодорхойлоорой. Жишээ нь:
- ~ Морин давааны их аман дээр Туул дүн өвөл шиг цавцайж байлаа.
(... бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр)
 - ~ Одоо Монголын бүх гол цөнгөө түрчихсэн байгаа.
(... бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр) гэх мэт

Ажиллах өгүүлбэр:

- ~ Эвдэрхий цоргоор долоо хоногт 90 литр ус асгардаг.
- ~ Та усны цоргыг хаахгүй орхивол нэг минут хүрэхгүй хугацаанд 60 литр ус асгарна.
- ~ Нэг өдөрт 100 литр цэвэр усыг жорлонгоор дамжуулан бохирын сувагт оруулдаг.
- ~ Бид усны хэрэглээгээ хянаж болно.

5. Дараах үгсийг утгаар нь зүйлчлэн ангилаарай.

- Хүний овог нэр, хочийн нэрс
- Адгуусан амьтанд оноож өгсөн нэрс
- Уул, ус, газар орон, хот суурин, аймаг, сум, гудамж талбайн нэрс
- Улс орон, тивийн нэрс
- Албан байгууллагын нэрс
- Бүтээгдэхүүний нэрс
- Сонин, сэтгүүл, вейб сайтын нэрс
- Ном зохиолын нэрс

Ангилан зүйлчлэх үгс:

Батхуягийн Тэмүүжин, Хойлог, Буйр нуур, Монгол улс, Чингэлтэй дүүрэг, Өдрийн сонин, Тунгалаг Тамир, Нүүдэл гоймон, Сонгино хайрхан дүүрэг, Атар талх, Нийгмийн даатгалын хэлтэс, Сурагчийн мэдээ, МУИС, Австрали тив, Говь-Алтай, Дархан хот, Хятад улс, Банхар, Хүдэр, Сахалт, Ягаан Гажид, Нийгмийн хонгор, Бух Гомбо, Оросын Холбооны Улс, мэдээ.мн, Дөлгөөн, Тайхар чулуу...

ӨӨРИЙГӨӨ ХЯНАХ ХУУДАС

УНШИХ

Мэдлэг, чадвар	Сайн чадна.	Давтана.	Дахин судална.
Эхийн орон, цагийн дараалал, учир шалтгааны уялдаа холбоо бүтцийг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таньж байна уу?			
Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлж чадаж байна уу?			
Уншсан эхээс орон ба цагийн дүрслэлийг ялгаж, үйл явдлын орчныг тодорхойлж чадаж байна уу?			
Уншсан эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлж чадаж байна уу?			
Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлаж чадаж байна уу?			
Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлаж чадаж байна уу?			
Эхээс гол мэдээллийг ялган уншиж чадаж байна уу?			
Үйл явдлын мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж чадаж байна уу?			
Уншсан эхэд жинхэнэ нэр, нэрийн тийн ялгал, биед ба эзэнд хамаатуулах нөхцөл, олон тооны дагаврыг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлж чадаж байна уу?			
Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэлзүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлж чадаж байна уу?			
Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлж чадаж байна уу?			
Өгүүлбэрийг хурааж, дэлгэрүүлэн, өгүүлбэрийн цөм ба дэлгэрэнгүй бүтэц үүсгэн найруулж чадаж байна уу?			

БИЧИХ

Захидал, намтар, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээг орон, цагийн дарааллаар өрнүүлэн учир шалтгааны уялдаа холбоотой бичиж чадаж байна уу?			
Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичиж чадаж байна уу?			
Тодотгон холбох нөхцөлтэй үйл үг, орон цагийн нэр ашиглан, орчныг дүрслэн бичиж чадаж байна уу?			
Эхэд өөрийн санаа, харилцан яриа оруулан дэлгэрүүлж чадаж байна уу?			
Хэлц ашиглан мэдрэмж, сэтгэгдэл, сэтгэл хөдлөлөө дүрслэн бичиж чадаж байна уу?			
Товч мэдээллийг холбоотой баримтаар дэлгэрүүлж чадаж байна уу?			
Үйл явдлыг хэн?, хаана?, юу? яагаад?, хэрхэн? яав? гэсэн асуултын дагуу мэдээлэн бичиж чадаж байна уу?			
Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулж чадаж байгаа юу?			
Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичиж чадаж байна уу?			

СОНСОХ- ЯРИХ

Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж чадаж байна уу?			
Санаа бодлоо бусдынхтай холбож, харилцан ярьж чадаж байна уу?			

СУРАХ БИЧИГТ АШИГЛАСАН ЭХ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Эхийн нэр	Хуудасны дугаар	Эх сурвалж
Алаг шаазгай араг дээр суугаад жир жир	9	Ж.Мягмарсүрэн. “Унагаа зуусан хулан”, 2000
Цэцэрлэгч өвгөн	12	Л.Н.Толстой. “Өгүүллэгүүд”, 1996
Минж бодож сэтгэдэг байж магадгүй	19	Ж.Мягмарсүрэн. “Унагаа зуусан хулан”, 2000
Нутаг усаа санахуй	34	Ц.Өнөрбаян, Монгол хэл 6, УБ, 1999
Үндэс	26	Дон Боско. “Дон Боскогоос хүүхэд залуучуудад илгээсэн захидал”, 2016
Сурцгаа, дүү нар минь!	18	Ч.Лхамсүрэн. “Шүлэг, найраглал” түүвэр, 1941
Дугуй	37	Д.Давааням. “Цасны хүү”, 1984
Хадат булаг	56	Н.Өлзийбат. “Сэтгэлийн эгшиг”, 1991
Ус	29	Ц.Дамдинсүрэн. “Зугаацахаар мордсон нь” “Монголын уран зохиолын товчоо”, 2007
Болжмор	72	“Davalgaa.mn”, 2016
Уучлах гэдэг ухааных	40	“Сургамжит өгүүллэг” зохиолын түүвэр, 2014
Чулуун сарлаг	32	Ж.Гал. “Чулуун сарлаг” “Монголын өгүүллэг туужийн дээж”, 3-р боть
Халуун гурил	51	Ж.Лхагва. Саарал даага 1970 он
Нэгэн сэхээ	22	Ш.Цэнд-Аюуш. “Адтай Мятав” Монголын уран зохиолын дээжис, 102-р боть, 2008
Зурагтай танилцсан минь	74	Л.Түдэв. “Хорвоотой танилцсан түүх”, “Бүтээлийн чуулган”, 4-р боть, 2002
Гэмшил	82	Д.Батбаяр. “Саахалтын нууранд ангир дуугарна”, 1964
Сүсэглэл	87	Дан.Нямаа. “Нарны алга”, 2012
Ээж	66	Д.Батбаяр. “Аниргүйн эрвээхэй”, 1983
Аав	89	Б.Лхагвасүрэн. “Түүвэр зохиол”, 2006
Анне Франкийн өдрийн тэмдэглэл	104	“Анне Франкийн өдрийн тэмдэглэл”, 2011 Б.Аминагийн орчуулгаар
Гүррагчаагийн өдрийн тэмдэглэл	117	Х.Цэвлээ. “Сэтгэлийн өчил”, 2004
Чаплины охиндоо бичсэн захидал	120	https://news.mn/r/701948/ хөрвүүлсэн Б.Гэрэл
Цөлжилт	134	Багшийн ном, Монгол хэл, уран зохиол VI, 2014
Фото зургууд	137-138	https://www.google.com/ цөлжилт
Эко сургуулиуд үзэсгэлэн гаргана	140	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, mne.mn, 2017
Монгол улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 93 жилийн ойг тэмдэглэв	141	МОНЦАМЭ, https://montsame.mn/mn/read89081 Ж.Болор, гэрэл зургийг Б.Чадраабал